

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИНСТИТУТИЙН ЗАРИМ НЭР ТОМЬЁО¹

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд² хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад Монгол Улсын Үндсэн хууль (*цаашид* “Үндсэн хууль” гэх), бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх, нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих, хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх, жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх зэрэг асуудлыг хуульчилсан байдаг. Энэ нь хуулийг батлан гаргахдаа хуулийн нэр томьёог жигдлэх, хуулийг нэг мөр хэрэглэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, төслийг хэлэлцэн батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томьёог зөв ойлгох нь чухал гэдгийг харуулж буйн илрэл юм.³

Хууль зүйн нэр томьёоны замналыг өөрийн орны хууль тогтоомжийн түүхэн үеүүдэд тулгуурлан он цагийн дарааллаар хураангуйлан үзвэл:⁴

- Эхний үед (1206-1921 он) Монголын эзэнт улсын төр хууль цааз тогтнож, чиг үүргээ хэрэгжүүлэх явцад цааз ёс, цааз хууль, цааз эрхэмж, хууль зүйл зэрэг уламжлалт нэр томьёоны үндэс суурь бүрэлдэн бий болсон;
- Хоёр дахь үед (1921-1991 он) Ардын эрхт ёсыг тогтоон явуулах болсноор Үндсэн хууль, шүүх цааз, журам дүрэм зэрэг хэлбэрээр хууль зүйн нэр томьёонд шинэлэг хандлага илэрхийн зэрэгцээ хөгжингүй орнууд, юуны өмнө зөвлөлт маягийн хуулиудыг үлгэр загвар болгосноор нэгдмэл хийгээд төрөлжсөн хуулиудыг боловсруулж, хууль зүйн нэр томьёо мэргэжлийн шинжтэй болж салбарлан хөгжсөн бөгөөд нэр томьёог жигдлэн сайжруулах үүднээс зарим алхмыг хийсэн;
- Гурав дахь үед (1992 оноос өнөөг хүртэл) Нийгмийн нэг тогтолцооноос нөгөөд шилжиж, бүхий л хүрээг хамарсан өөрчлөлт шинэчлэл хийгдэх болсноор өмнөх хуулиуд шинэ хуулиудад байр сууриа тавьж, дэлхийн жишгээр хууль зүйн нэр томьёонд шинэ үг хэллэг нэвтрэн, эх хэл болон харь хэлний агуулгыг утга зүйн үүднээс танин мэдэж харьцуулан жигдлэх шаарлага улам бүр өсөн нэмэгдсэн хэмээн томьёолж болно.

Хуулийн нэр томьёо хэт өргөн агуулгатай хийгээд олон салаа утгатай бол ердийн хуульд нэр томьёоны тайлбар хийдэг. Харин Үндсэн хуулийн бичвэрт нэр томьёоны тайлбар гэсэн хэсэг байхгүй, Үндсэн хуулийн цэцээс маргааныг хянан шийдвэрлэх замаар тайлбарлаад явдаг. Монгол Улсын Үндсэн хууль нь хатуу⁵ Үндсэн хуулийн ангилалд хамрагддаг тул нэгэнт Үндсэн хуульд тусгагдсан хууль зүйн нэр томьёо цаг хугацааны хувьд хоцрогдсон, оновчгүй

¹ Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал, Ж.Булгансүрэн, Ц.Оюунчимэг, О.Төрболд, Э.Уянга, С.Цэрэндолгор, У.Эрдэнэзаяа нар хамтран гүйцэтгэв.

² Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №25, (УБ, 2015).

³ Монгол Улсын Үндсэн хууль нийтдээ 7559 тэмдгэлгээнээс бүрдсэн байдаг бөгөөд үүнээс үг 5977, тоо 323, цэг 471, таслал 625, тэмдэгт 163 байдаг талаар, мөн манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж дахь түгээмэл хэрэглэж буй нэр томьёог судлан үзэхэд “этгээд, бүхий, бус” гэх үгс хамгийн их хэрэглэгдсэн байна гэсэн судалгааны дүн гарсан байдаг.

⁴ Т.Сэнгэдорж, “Монгол Улсын хууль зүйн нэр томьёо судлал: сургамж ба шийдэл”, Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, (УБ, 2016), 19 дэх тал.

⁵ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд ихээхэн хүндрэлтэй нэмэлт болзол тогтоосон Үндсэн хуулийг энэ ангилалд хамааруулдаг.

байсан ч өөрчлөх боломж хязгаарлагдмал байдаг. Үндсэн хуульд хэрэглэсэн нэр томъёог бусад хууль тогтоомж, эрх зүйн актад тусгаж, Үндсэн хуульд нийцүүлэн хэрэглэх шаардлагатай байдаг зэрэг нь үндсэн хуулийн эрх зүйн нэр томъёоны онцлог юм. 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан хууль зүйн нэр томъёо нь гуч шахам жил тогтвортой хэрэглэгдэж, хууль зүйн нэр томъёоны үндсэн эх сурвалж болж байгаа билээ.

Иймд бид энэхүү судалгааны хүрээнд Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн институт дахь тодорхой нэр томъёог эрдэмтэн, судлаачид болон үг зүйн толь бичигт хэрхэн тодорхойлж, тайлбарласан, тухайн нэр томъёог агуулгын хувьд хэрхэн ойлгож, хэрэглэх ёстой болон уг нэр томъёоны талаар гадаад улсын зарим жишээг авч үзлээ.

Судалгааны объект

Ерөнхийлөгч гэх нэр томъёо нь 1990-ээд оноос албан ёсоор хуульчлагдан, хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд 1992 оны Үндсэн хуулийн Гучдугаар зүйлээс Гучиндолдугаар зүйлд тус субъекттэй холбоотой зохицуулалтыг тусгасан байдаг. Уг судалгааны хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх хэсгээс дараах нэр томъёог сонгон судлав. Үүнд:

1. Ерөнхийлөгч;
2. Төрийн тэргүүн;
3. Ерөнхийлөгчийн сонгууль;
4. Сонгуулийн хоёр шат;
5. Анхан болон дахин санал хураалт;
6. Тангараг өргөх;
7. Зарлиг;
8. Огцруулах;
9. Бүрэн эрх;
10. Хориг;
11. Зөвшилцөх;
12. Итгэмжлэх жуух бичиг;
13. Онц байдал;
14. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл;
15. Дайчилгаа;
16. Дайны байдал.

Судалгааны арга зүй

Дээрх судалгааны ажлаар үгийн үндсийг тодорхой үндэслэлтэй гаргахын тулд шинжлэх ухааны греминивтик арга, түүхэн талаас нь түүхчлэх арга, тухайн үгийн агуулгыг илүү тодорхой болгохоор харьцуулалтын арга, мөн Үндсэн хуулийн холбогдох зүйл заалт, үгийн утга агуулгыг ойлгох үүднээс Үндсэн хууль тайлбарлах үгчлэх, системчлэх, утга зүйн аргуудыг тус тус хэрэглэсэн болно.

ҮГИЙН УГ ГАРВАЛ, ТҮҮНИЙ УТГА АГУУЛГА

ЕРӨНХИЙЛӨГЧ

Энэ үг латин хэлний “praesidēs” (тэргүүлэгч, ерөнхийлөгч, удирдагч) гэсэн үгнээс гаралтай. Латин хувилбар нь praesideō (тэргүүлэх) гэсэн үйл үгнээс үүсжээ. Үйл үгийг задалбал praе (урд, өмнө), sedeō (суух) гэсэн утгатай. “Урд, тэргүүнд суух” гэсэн үгийн эх утга нь “хурал даргалах” гэсэн утгаар ойлгогдоно. Тус үйл үгийн хоёрдугаар утга нь “удирдах, эрх барих” гэсэн

утга агуулна. Иймд *praesidēns* гэдэг нь “хурал даргалж буй хүн” буюу “удирдагч, эрх баригч” гэсэн утгатай юм.⁶

Бусад улсад засаглалын хэлбэрээс хамааран Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээ өөр өөр байна. Парламентын бүгд найрамдах засаглалтай улсад Ерөнхийлөгч ихэвчлэн бэлгэдлийн шинжтэй, тухайн улсынхаа хязгаарлагдмал эрх мэдэл бүхий төрийн тэргүүн байдаг бол Ерөнхийлөгчийн засаглалтай болон хагас Ерөнхийлөгчийн засаглалтай улсад үүрэг нь илүү ач холбогдолтой, Засгийн газрын тэргүүний үүргийг гүйцэтгэж, удирдан чиглүүлсэн шинжтэй байна.⁷ Мөн авторитари дэглэмтэй, нам төвтэй улсын удирдагч буюу дарангуйлагчийг Ерөнхийлөгч гэх нь бий.⁸

Английн Бүгд Найрамдах Улс (англ. the Commonwealth of England)-ын үед Английн Засгийн газрын хамгийн өндөр албан тушаалтныг илэрхийлэх зорилгоор “Ерөнхийлөгч” хэмээх үгийг анх хэрэглэжээ. Төрийн зөвлөлийн хэмжээгүй эрхийг халсны дараагаар Нийтийн танхимаас сонгогдсон гишүүд Бүгд Найрамдах Улсын гүйцэтгэх эрх мэдэл бүхий Засгийн газрын гишүүд болж, Төрийн зөвлөлийг Лордын Ерөнхийлөгч (англ. Lord President) удирдах бөгөөд Лордын Ерөнхийлөгч нь дангаараа бус зөвлөлтэй хамтран төрийн тэргүүний үүргийг гүйцэтгэдэг байв.⁹

Бүгд Найрамдах Улсын төрийн тэргүүн буюу “ганц тоон дээр” илэрхийлэгдэх нэр томьёо бүхий Ерөнхийлөгч гэсэн үгийг орчин үед сонгодог утгаар нь АНУ-ын 1787 оны Үндсэн хуульд “АНУ-ын Ерөнхийлөгч” гэсэн албан тушаалын нэршлээр анх оруулсан.¹⁰ Хэдийгээр АНУ-ын өмнөх Засгийн газруудад Конгрессын Ерөнхийлөгч гэх албан тушаал байсан боловч тэдгээр нь гүйцэтгэх эрх мэдлийг агуулахгүй, хурал даргалах хэлбэрийн шинжтэй байсан байна. Энэхүү нэр томьёог Америкийн коллеж, их сургуулийн захирлыг “Ерөнхийлөгч” гэдэг байснаас үүдэлтэйгээр гаргаж иржээ. Учир нь Британийн их сургуулиудын захирлыг “Канцлер” (англ. Chancellor), гүйцэтгэх захирлыг “Дэд канцлер” (англ. Vice Chancellor) зэргээр нэрлэдэг байсан ба “Ерөнхийлөгч” гэсэн нэр томьёо ихэвчлэн АНУ-ын Их, дээд сургуулийн боловсролын тогтолцоонд хэрэглэгддэг байв.

АНУ ийнхүү бүгд найрамдах засаглалтай улсынхаа төрийн тэргүүнийг “Ерөнхийлөгч” хэмээн нэрийдэх болсноос хойш эдүгээ Бүгд Найрамдах хэлбэртэй бараг бүх улс оронд түгэн дэлгэрсэн гэж үздэг.¹¹

Франц Улсад парламентын Ерөнхийлөгчийг “фр. Monsieur/Madame le Président” гэдэг байсан бөгөөд өдгөө тус улсад Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий шүүгчийн хувьд энэ нэр томьёог хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгч гэдэг нь тодорхой эрх зүйн байдал бүхий, тусгай үг тул дур зоргоор хэрэглэхгүй бөгөөд албан ёсоор улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий шүүгч хоёрыг ийн нэрлэдэг ажээ.

Латин Америкийн Хаити Улсад 1807 онд Хенри Кристоф “Ерөнхийлөгч” гэгдэх болсноор тивийнхээ анхны Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглалтай улс болжээ.¹² Мөн Европ тивд 1802 онд анхлан Итали Улс “Ерөнхийлөгч”-тэй болсон бол Африкийн анхны Ерөнхийлөгч нь

⁶ Henry Campbell Black, *Black's law dictionary*, 4th edition (St.Paul, Minn: 1968, West publishing Co), p.1424.

⁷ MS Shugart "Comparative Executive–Legislative Relations" *The Oxford handbook of political institutions (PDF)*. <https://doi.org/10.1093%2Foxfordhb%2F9780199548460.003.0018> (Сүүлд үзсэн: 2019.05.08)

⁸ Мөн тэнд.

⁹ E.V.Fryde, *Handbook of British Chronology* (Cambridge: Cambridge University Press, 1941, 1961, 1986).

¹⁰ АНУ-ын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйл, (1787).

¹¹ П.Очирбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр, (УБ, 2001), 17 дахь тал.

¹² Gaspard Théodore Comte de Mollien, *Haïti ou Saint-Domingue, Vol 2*. (Paris: L'Harmattan, 2006), p. 63.

1848 онд Либерээс төржээ. Түүнчлэн, Ази тивд анхны Ерөнхийлөгчийн албан тушаал 1912 онд Бүгд Найрамдах Хятад Улсад бий болсон гэж үздэг байна.¹³

Өнөөдрийн байдлаар дэлхий дахинд бүгд найрамдах засаглалтай улсыг “Ерөнхийлөгчийн тогтолцоотой”, “Хагас Ерөнхийлөгчийн тогтолцоотой”, “Парламентын тогтолцоо”-той хэмээн ангилж, ийм тогтолцоотой улсад төрийн тэргүүнээ “Ерөнхийлөгч” гэсэн нэр томъёогоор илэрхийлж байна. Тодруулбал, дэлхий дахинд “Ерөнхийлөгч” гэсэн томъёоллоор төрийн тэргүүнээ илэрхийлж буй 82 улс байна.¹⁴

Монгол хэлний хувьд “Ерөнхийлөгч” гэсэн үгийн үүсэл, чухам хэзээнээс хэрэглээнд орсон талаарх мэдээлэл хомс байна. Харин эрх зүйн зохицуулалтын хүрээнд 1990 оны 5 дугаар сарын 12-нд “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль”-ийг баталснаар “Ерөнхийлөгч” гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн шинэ байгуулалт /институт/¹⁵ бий болсон талаар тэмдэглэсэн байдаг.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Ерөнхийлөгч” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлдийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д дэх хэсэгт “Ерөнхийлөгч бол Үндсэн хуулийн гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэсэн бол Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” номонд: 1. Улсын дээд эрхийг барих газрыг ерөнхийлөгч удирдагчийн албан тушаал; 2. Эрдэм шинжилгээний томоохон байгууллагыг ерөнхийлөн удирдагчийн албан тушаал;¹⁶ академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” номондоо: “англ. president; ор. президент – Бүгд Найрамдах улсын хэлбэрт ерөнхийлөгч төрийн төдийгүй гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн;¹⁷ Ш.Чоймаа нарын “Монгол хэлний хэлзүйн толь бичиг I боть” номонд: “ерөнхийлөн удирдагч, улсын ерөнхийлөгч¹⁸ гэж тус тус тайлбарлажээ.”

Харин Г.Совд нарын “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”-т ерөнхийлөгч гэх нэр томъёог авч үзэхдээ тухайн улс орны засаглалын хэлбэрээс хамаарч төрийн тэргүүн нь ерөнхийлөгч эсхүл хаан байна гэж тэмдэглэсэн бол доктор, профессор Ц.Сарантуяа хууль зүйн нэр томъёог 1/латин, 2/ үндэсний гэж ангилсан бөгөөд үндэсний нэр томъёог 1/гадаад, 2/ орчуулгын, 3/орчуулгын бус (уугуул) гэж ангилж үзсэн. Бидний судалж буй Монгол Улсын Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн институттай холбоотой нэр томъёоны суурь нь болж буй “Ерөнхийлөгч” гэсэн үгийг дээрх ангиллын орчуулгын бус (уугуул) гэх ангилалд багтаасан байна.¹⁹

Дүгнэвэл, “Ерөнхийлөгч” хэмээх нэр томъёог удирдагч, тэргүүлэгч гэсэн утгаар тайлбарласан бөгөөд бүгд найрамдах засаглалтай улсууд төрийн тэргүүнээ “Ерөнхийлөгч” гэх нийтлэг нэр томъёоор илэрхийлдэг байна.

¹³ Сун Ятсэн (хят. 孫文; 孫中山; 孫逸仙; латин галиг Sūn Yìxiān)

¹⁴ Үүнийг тогтолцооноос нь үл хамааруулан албан ёсны нэр томъёогоор нь хавсралт 2-т хүснэгтээр үзүүлэв.

¹⁵ Б.Чимид, “Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал” Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь онол практикийн бага хурал (2003), 23 дахь тал.

¹⁶ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (УБ, 1966), 233 дахь тал.

¹⁷ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (дөрөв дэх хэвлэлт), (УБ, 2015), 189 дэх тал.

¹⁸ Ш.Чоймаа нар, Монгол хэлний хэлзүйн толь бичиг I боть, (Хөх хот, 2006), 324 дэх тал.

¹⁹ Ц.Сарантуяа, “Монгол Улсын хууль зүйн нэр томъёо судлал: сургамж ба шийдэл”, “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, (УБ, 2016), 36 дахь тал.

ТӨРИЙН ТЭРГҮҮН

Төрийн тэргүүн гэдэг нь улс орныг тэргүүлэгч хүн юм. Өдгөө дэлхий дээрх ихэнх улсад Ерөнхийлөгч хэмээх албан тушаалтан энэ үүргийг гүйцэтгэдэг бол Хаант засаглалтай улсад хаан, социалист улсад Ардын хурлын тэргүүлэгч, дарга нар энэ үүргийг гүйцэтгэдэг байна. Тусгаар тогтносон улс орон төрийн тэргүүнтэй байх бөгөөд төрийн тэргүүнийхээ эрх, үүрэг, эрх хэмжээг Үндсэн хуулиараа тогтоодог байна.²⁰ Төрийн тэргүүнээ “Ерөнхийлөгч” хэмээн албан ёсоор нэрийддэг 82 улс байдаг талаар өмнөх хэсэгт дурдсан билээ.

Төрийн тэргүүн нь үндэсний эв нэгдэл, бүрэн эрхт улсын хуульт ёсыг албан ёсоор төлөөлдөг нийтийн албан тушаалтан юм.²¹ Гагцхүү тухайн улсын төрийн дэглэм, эрх мэдэл хуваарилалтаас хамаарч төрийн тэргүүн нь бэлгэдлийн шинжтэй байх эсхүл Засгийн газрын тэргүүн байх эсэх нь тодорхойлогддог байна. Тухайлбал, парламентын засаглалд төрийн тэргүүн нь тухайн улсын “де-юре” (de jure)²² удирдагч байдаг бол Ерөнхий сайд нь “де-факто” (de facto)²³ удирдагч байдаг. Эсрэгээрээ, хагас-ерөнхийлөгчийн засаглалтай улсад төрийн тэргүүн болон Засгийн газрын тэргүүний аль аль нь улсынхаа “де-факто” удирдагчид байдаг.

Парламентын засаглалтай орнуудад төрийн тэргүүн нь ерөнхийдөө бэлгэдлийн шинжтэй, Засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагаанд чиглэл өгдөггүй, улс төрийн албан тушаалыг ямар нэг байдлаар хэрэгжүүлдэггүй этгээд байна.²⁴ Төрийн тэргүүн нь мөн Засгийн газрын тэргүүний үүргийг хавсран гүйцэтгэдэг орнуудад улсын бэлгэдлийн шинжтэй төлөөлөгч байхаас гадна гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг хамгийн дээд эрэмбэ бүхий улс төрийн удирдагч байдаг.

Үндсэн хуулиараа тодорхойлсон төрийн дэглэм, засаглалын хэлбэрээс хамааруулан “төрийн тэргүүн”-ийг үндсэн дөрвөн төрөлд хувааж болох юм:

1. Парламентын тогтолцоот (стандарт загвар) – Онолын хувьд стандарт загвар бүхий парламентын тогтолцоонд төрийн тэргүүн нь гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газрын тэргүүнтэй зөвшилцөн хэрэгжүүлдэг (Тухайлбал, ИБУИНВУ, Энэтхэг, ХБНГУ);
2. Парламентын тогтолцоот (гүйцэтгэх бус загвар) – Төрийн тэргүүн нь маш хязгаарлагдмал гүйцэтгэх эрх мэдэл бүхий, голдуу улсынхаа бэлгэдэл, ёс төдий үүрэг гүйцэтгэдэг загвар (Тухайлбал, Швед, Израиль);
3. Хагас-Ерөнхийлөгчийн тогтолцоот - төрийн тэргүүн нь Засгийн газар, танхимын тэргүүнтэй хамтран гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг (Тухайлбал, ОХУ, Франц, Шри-Ланка);

²⁰ Sir Arthur Watts "Heads of State" In Wolfrum, Rüdiger (ed.). *Max Planck Encyclopedia of Public International Law* (Oxford International Public Law: Oxford University Press, 2010), <https://opil.ouplaw.com/view/10.1093/law:epil/9780199231690/law-9780199231690-e1418> (сүүлд үзсэн: 2019.05.01)

²¹ Joanne Foakes, *The Position of Heads of State and Senior Officials in International Law* (Oxford, UK: 2014, Oxford University Press), p.110-111.

²² Мөн тэнд, “Хууль ёсны” гэсэн утгатай латин үг. Олон Улсын эрх зүй дэх улс орны тусгаар тогтнолыг “бүрэн” хүлээн зөвшөөрөх хэлбэр бөгөөд төрийн тэргүүний хувьд “бүрэн эрх” бүхий удирдагч гэсэн утгаар хэрэглэгдэнэ.

²³ Мөн тэнд, “Харьцангуй бараг баримт” гэсэн утгатай латин үг. Олон Улсын эрх зүй дэх улс орны тусгаар тогтнолыг “бүрэн бус” хүлээн зөвшөөрөх хэлбэр. Улс төрийн онолд “де факто удирдагч” гэж төрийн удирдлагыг Үндсэн хуулийн бус буюу бусад хууль бус аргаар авсан этгээдийг хэлдэг. Энд зарим эрхийг эдлэх гэсэн утгаар номын зохиогч Жоанн Фоакес оруулсан.

²⁴ Мөн тэнд, 62 дахь тал.

4. Ерөнхийлөгчийн тогтолцоот - төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүний үүргийг давхар гүйцэтгэх бөгөөд гүйцэтгэх бүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг (Тухайлбал, АНУ, Индонези).

Монгол Улсын тухайд 1206-1924 он хүртэл Чингис хаанаас эхлэн үе залгамжилсан 37 хаан, Манжийн хаадыг дамжин Богд хаан хүртэл төрийн тэргүүн маань хаад байжээ.²⁵ 1924 онд батлагдсан БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн хоёрт “харьяат улсад Бүгд Найрамлах Ардын засгийг явуулж, дажутан гэдэг ерөнхий даргыг сонгохгүй улсын бүх дээд эрхийг УИХ-д ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраа хадгалах” гэж зааснаас хойш Монгол Улсын төрийн тэргүүний хууль ёсны статус алга болж, Улсын Бага Хурлын тэргүүлэгчид, Тэргүүлэгчдийн дарга, Ерөнхий сайд, Ардын Их Хурлын тэргүүлэгчид, Тэргүүлэгчдийн дарга, намын дарга хавсран “хамтын тэргүүний” хэлбэртэй байж хожим энэ албан тушаалтнаас “Нам, төрийн тэргүүн” гэж өргөмжилдөг болсоор 1990 он хүрчээ.²⁶

Төрийн тэргүүн гэх нэр томъёо тухайн нийгмийн цаг үеийн байдал, тогтолцоо, засаглалын хэлбэрээс хамаараад тодорхой хэмжээний ялгаатай тодорхойлогдож ирсэн байх тул Монгол Улсын хувьд тус нэр томъёо хэрхэн ойлгогдож ирснийг дараах цаг хугацаагаар ангилан авч үзье:

Их Засаг хууль (Их Монгол Улсын үед)	1921-1924 оныг хүртэлх үе	1924-1990 оныг хүртэлх үе	1990-ээс одоог хүртэлх үе
<p>Тус хуулийн 1 дүгээр зүйлд “Мөнх тэнгэрийн хүчин дор Их монгол улсын Далай хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай”, 2 дугаар зүйлд “Тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг эргэлзээгүй” хэмээн тус тус заажээ.</p> <p>Их Монгол Улсаас өмнөх үе, Их Монгол Улсын үе, Бага хаадын үе, Манжийн ноёрхлын үе зэргээс 720 шахам жил манай улс хаант засагтай, төрийн тэргүүн нь “хаан” байж иржээ. XIII зууны эрх зүйн гол</p>	<p>1921 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр “Богд хаан ба Засгийн газар хоорондын холбогдлыг илэрхийлсэн тангараг дүрэм”-ийг баталж, хэмжээт засагтай ард улсад “төрийн тэргүүн” болох “хаан” нь ямаршуу байр суурь, эрх мэдэлтэй байхыг тодорхойлсон.</p> <p>Тангарагийн гэрээ байгуулагдсанаар Монгол Улсад засаглалын хэмжээ, хуваарилалтын эхлэл тавигдаж, уг чанартаа Үндсэн хуульт хаант</p>	<p>1924 оны 5 сард Богд Жавзандамба хаан нэгэнт таалал төгссөн тухайд ардын Засагт улсын ёсонд нийцүүлэн Бүгд Найрамдах засгийг явуулахаар тогтсон. 1924 оны Үндсэн хуулийн боловсруулах ажлыг гардан хийсэн Б.Цэрэндорж төрийн тэргүүнгүй байхын сайхныг хойт хөршөөс үлгэр авч, төрийн тэргүүнтэй байхын муу уршгийг урд хөршийн жишээгээр тайлбарлаж байсан.²⁸ Тийнхүү Богдыг дахин тодруулахгүй, “Да жунтан” хэмээх улсын ерөнхий дарга /төрийн тэргүүн/-ийг сонгохгүй гэж</p>	<p>1990 онд АИХ-ын чуулган “БНМАУ-ын Төрийн дээд байгууллагын бүтцийн тухай” тогтоол гаргаж, “БНМАУ-ын төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч байна” гэсэн томъёолол хуульчлагдан тусгагдсан. 1990 оны 5 дугаар сарын 12-нд “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль”-ийг баталж, 13 дугаар зүйлд “БНМАУ-ын Ерөнхийлөгч бол Ардын төрийн тэргүүн, БНМАУ-ын тусгаар тогтнол, монголын ард түмний эв нэгдлийн баталгаа мөн” гэж тодорхойлсноор Монгол Улсад</p>

²⁵ П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль /хэрэгжилт, хяналт, судалгаа/, (УБ, 2017), 181 дэх тал.

²⁶ 1924 оноос өнөөг хүртэлх Төрийн тэргүүний үүрэг гүйцэтгэгч болон Төрийн тэргүүний мэдээллийг хавсралт 3-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

²⁸ Мөн тэнд, 11 дэх тал.

<p>эх сурвалж болох Их Засаг хуулийн дээр дурдсан заалтаас үзвэл, Чингис хааны зарлигийг эргэлзээгүй бөгөөд дагаж мөрдөхөөр хуульчилсан байна.</p>	<p>засгийн нийтлэг төрх тодорсон байна.²⁷</p>	<p>шийдэж, анхны Үндсэн хуульдаа тунхаглажээ.</p> <p>Тэр цагаас хойш ЗХУ-ын жишгээр төрийн “хамтын тэргүүн”-тэй байх ёсыг 66 жил даган баримталсан түүхтэй.²⁹</p> <p>Өнгөрсөн зууны энэ хэлбэр нь улс орны хэмжээний эрхэм дээд шийдвэрийг хэн нэгэн тушаалтан ганцаараа гаргахгүй, харин хууль, зарлигийг Тэргүүлэгчид хэмээх хамтын бүрэлдэхүүний олонхийн саналаар батлан дагуулдаг зарчимд үндэслэн байсан бөгөөд гол төлөв түүгээр нь “хамтын тэргүүн” гэж байжээ.</p>	<p>Ерөнхийлөгч гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн шинэ байгуулалт /институт/³⁰ бий болжээ. Ийнхүү парламентын бүгд найрамдах улсын Ерөнхийлөгчийн статустайгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан тушаал анхлан бий болсон юм.</p>
--	--	--	--

1990 оноос өмнө нам нь төрийг орлон ажиллах болсны хэрээр социалист орнуудын намын удирдагчийг төрийн тэргүүн гэж Олон Улсын хүрээнд хүртэл тооцож харилцдаг, сонин хэвлэлд бичдэг байв. Доктор, профессор Б.Чимид “Төрийн тэргүүн гэж төрийн албан тушаал талаасаа ямар ялгаатай нь гол биш, төрийг орлосон намын дарга байсан нь тодорхойлох үүрэгтэй байжээ. Өөрөөр хэлбэл, “намын нэрээр улсын тэргүүний үүргийг гүйцэтгэх болсон нь цагтаа бодит зүйл, угтаа гажуудал байж дээ” гэж сэтгэлд арга буюу бууна³¹ хэмээн илтгэлдээ бичжээ. Харин 1990 оны 5 дугаар сарын 12-нд баталсан “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль”, 1992 оны 1 дүгээр сарын 13-нд баталсан “Монгол Улсын Үндсэн хууль”³²-д “Ерөнхийлөгч”-ийн институтийг бий болгосноор Монгол Улсад “төрийн тэргүүн” гэх нэр томъёо дахин хэрэглэгдэх болж, тэрхүү “төрийн тэргүүн” нь “Ерөнхийлөгч” байхаар тогтжээ.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Төрийн тэргүүн” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Б.Чимид “Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь” номондоо “төр тэргүүлдэг гэх дээрх санааг засаг төрийн гурван салааг тус тусад нь даргалдаг мэтээр гуйвуулан хэтрүүлж болохгүй. Харин Үндсэн хуулиар бэхжүүлсэн засаг төрийн байгууллын оршин тогтнохуйн үүднээс тэдгээр

²⁷ Я.Долгоржав “Онол, практикийн бага хурлыг нээж хэлсэн үг” Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь онол практикийн бага хурал (УБ, 2003), 7 дахь тал.

²⁹ Б.Чимид, “Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал” Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь онол практикийн бага хурал (УБ, 2003), 18 дахь тал.

³⁰ Мөн тэнд, 23 дахь тал.

³¹ Мөн тэнд, 20 дахь тал.

³² Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, (1992),

салаа мөчрийн аль алинд нь хууль зүйн хувьд эцсийн бодитой нөлөө үзүүлэхүйц бүрэн эрх, түүнийг хангах, юуны өмнө, эрх-зохион байгуулалтын механизмтай байх гэсэн ойлголт болно”³³ гэсэн бол Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” номонд: “Тэргүүн – 1. Толгой; толгой тэргүүн хорш; 2. толгойлогч, удирдагч, ерөнхийлөгч; *засгийн газрын тэргүүн; төлөөлөгчдийн тэргүүн*; тэргүүн захас (тэргүүлж даргалсан хүн); тэргүүн сайд (жинхэнэ сайд); 3. Хуучирсан нэгдүгээр зэрэг шагнагдсан тайж; *тэргүүн зэрэг*; 4. Юмны дээд тал, урд тал; тэргүүний залуур (онгоцны хэрэгсэл); 5. Нэгдүгээр, анхдугаар, анхны, эхний; *тэргүүн дэвтэр; тэргүүн боть*.”³⁴; гэсэн бол академич Ж.Амарсанаагийн редакторласан “Эрх зүйн мэдлэгийн товч толь” номонд: “Төрийн удирдлагын болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Үндсэн хуулийн дээд байгууллага. Тэрээр хамтын болон нэг хүний гэсэн хоёр төрөлтэй. Хөрөнгөтөн улсуудын төрийн тэргүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх хэлбэрээсээ шалтгаалан олон улсын харилцааны салбарт онцлогтой байдаг. Хөрөнгөтөн орны төрийн тэргүүн нь гадаад бодлогын асуудлаар бүрэн эрхгүй эсхүл бага хэмжээний бүрэн эрхийг эдэлдэг онцлог шинжтэй. Төрийн тэргүүн нь хаан, ван, ерөнхийлөгч буюу эсхүл төрийн зөвлөл, дээд зөвлөл, тэргүүлэгчид зэрэг хамтын удирдлагын байгууллага байдаг.”³⁵; академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” номондоо: “англ. head of state; ор. глава государства - Төрийн дээд төлөөлөгч, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг дээд албан тушаалтан. Хаант засаглалтай улсад (Их Британи, Швец, Испани, Япон) Т.т нь хаан байх бөгөөд хуулиар тогтоосон журмын дагуу эрх мэдлийг угсаа залгамжилна. БНУ-ын засаглалтай улсад Т.т нь ерөнхийлөгч бөгөөд хүн амаас шууд (ОХУ, Мексик) буюу шууд бус журмаар (АНУ, Аргентин), эсхүл олон шаттай сонгуулиар (Итали, ХБНГУ, Энэтхэг) сонгогдоно. Дэлхийн бараг бүх улсад Т.т нь ганцаарчилсан хувь хүн байхаар тогтоосон бөгөөд ерөнхийлөгчийн БНУ-д (АНУ, Мексик) нэгэн зэрэг гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн байдаг. Бараг бүх улсын Үндсэн хуулиар Т.т-нд өргөн бүрэн эрх олгосон: засгийн газрын тэргүүн ба сайд нарыг томилох, зэвсэгт хүчний дээд ерөнхий командлагч байх, уучлал үзүүлэх, хуульд хориг тавих, одон медиалаар шагнах, парламентын чуулганыг зарлан хуралдуулах, парламентыг тараах, хууль санаачлах зэрэг. Парламентын бүгд найрамдах улсад Т.т-ий бүрэн эрхийг түүний нэрийн өмнөөс засгийн газар хэрэгжүүлнэ.”³⁶; хэмээн тодорхойлсон бол Ш.Чоймаа нарын “Монгол хэлний хэлзүйн толь бичиг II боть” номонд: “Тэргүүн – толгой, манлай, эхний, дээд”³⁷ гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, “Төрийн тэргүүн” хэмээх нэр томъёо нь тухайн улс орны засаглалын хэлбэр, эрх мэдлийн хуваарилалтаас шалтгаалан янз бүр байгаа ч улс орныг тэргүүлэн удирдагч гэсэн нэгдмэл утгаар тайлбарласан байна. Мөн “төрийн тэргүүн” гэсэн нэршил нь “Ерөнхийлөгч” хэмээх нэр томъёоноос ялгаатай нь бүгд найрамдах болон хаант засаглалтай байхаас үл хамааран хэрэглэгддэг нийтлэг нэр томъёо буюу илүү өргөн хүрээний ойлголт болох нь харагдаж байна.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ

³³ Б.Чимид, Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь (төслийн багийн судалгааны ажлын тайлан), (УБ, 2005), 16 дахь тал.

³⁴ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (УБ, 1966), 578 дахь тал.

³⁵ Ж.Амарсанаа, Эрх зүйн мэдлэгийн товч толь, (УБ, 1986), 134 дэх тал.

³⁶ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (анхны хэвлэл), (УБ, 2007), 434 дэх тал.

³⁷ Ш.Чоймаа нар, Монгол хэлний хэлзүйн толь бичиг II боть, (Хөх хот, 2006), 900 дахь тал.

Англи хэлний “Presidential election” буюу Ерөнхийлөгчийн сонгууль нь Улсын төрийн тэргүүн болох Ерөнхийлөгчийг сонгох сонгууль юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд ард түмнээс сонгодгийг харгалзан “холимог” буюу “Парламент-Ерөнхийлөгч” хосолсон улс гэж дотоод, гадаадын зарим судлаач ангилсан нь бий. Гэхдээ “сонгох ёсон” бол төрийн удирдлагын хэлбэр хийгээд Ерөнхийлөгчийн статусыг тодорхойлох цорын ганц шалгуур биш³⁸ юм.

Энэ хэсэгт Ерөнхийлөгчийн сонгуулийн агуулгыг өргөжүүлэн авч үзэлгүйгээр тус сонгуулийн талаар Үндсэн хуульдаа тусгасан улсуудыг тогтолцоо бүрээр төлөөлөл болгон үзье.

Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал: Ерөнхийлөгчийн засаглалтай ихэнх улсад Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн болон Засгийн газрын тэргүүний үүргийг хамтад нь хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгч нь гүйцэтгэх эрх мэдлийг шууд удирддаг. Энэхүү тогтолцоонд Ерөнхийлөгч нь ард нийтийн саналаар шууд эсхүл сонгуулийн коллеж (англ. Electoral college³⁹) болон өөр бусад ардчиллын замаар сонгогдсон байгууллагаас шууд бусаар сонгогддог байна.

Жишээ 1 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн II зүйлийн 1 дэх хэсэг⁴⁰: “Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчид гүйцэтгэх эрх мэдэл хадгалагдана. Тэрээр дөрвөн жилийн хугацаанд чиг үүргээ Дэд Ерөнхийлөгчийн хамтаар хэрэгжүүлэх ба дараах байдлаар сонгогдоно:

Сонгогчид нь холбогдох Муждаа хоёр нэр дэвшигчтэй саналын хуудас бөглөх ба тэдгээрийн нэг нь өөртэй нь ижил Мужийн оршин суугч биш байна. Ийнхүү санал өгсөн хүмүүсийн жагсаалт, тоог тус бүрээр гаргаж жагсаалтыг баталгаажуулан битүүмжилж Сенатын Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Сенатын Ерөнхийлөгч нь Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын хамтаар бүх баталгаажуулалт, саналыг тоолно. Томилогдсон Сонгогчдын олонхийн саналыг авсан хүн Ерөнхийлөгч болно: хэрэв олонхийн санал авсан нэгээс илүү хүн байвал, саналын тоо тэнцвэл Төлөөлөгчдийн танхим саналын хуудсаар аль нэгийг нь Ерөнхийлөгчөөр сонгоно; тэгээд олонхийн санал авсан хүнгүй бол жагсаалтын хамгийн тэргүүнд бичигдсэн таваас Танхимын хэлсэн журмаар Ерөнхийлөгчийг сонгоно. Гэвч Ерөнхийлөгчийг сонгоход Мужуудаас санал хураасан байх ба Муж бүрийн Төлөөлөгчид тус бүр нэг саналын эрхтэй; энэ нь Мужийнн гуравны хоёрын ирцийг шаардах бөгөөд Мужийнн олонхийн сонголт шаардлагатай. Ерөнхийлөгчийг сонгосны дараа сонгогчдын хамгийн олон санал авсан хүн Дэд Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Гэвч хоёр буюу түүнээс дээш хэмжээний тэнцүү санал байвал Сенат саналын хуудсаар Дэд Ерөнхийлөгчийг сонгоно” гэжээ.

Дээрх жишээнээс харвал, АНУ-ын хувьд Ерөнхийлөгчийг “Сонгуулийн коллеж” (англ. Electoral college) гэх эрх бүхий байгууллагаас сонгодог өвөрмөц тогтолцоотой байна.

Жишээ 2 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Үндсэн хуулийн 77 дугаар зүйл⁴¹: “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний санал хураалтын дүн аравдугаар сарын эхний ням гарагт

³⁸ Б.Чимид “Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал” Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь ОПБХ (УБ: 2003): 27 дахь тал.

³⁹ The Electoral College – Сонгуулийн коллеж гэж АНУ-ын Үндсэн хуулиар байгуулагдсан, 4 жил тутамд солигддог, Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийг сонгох зорилго бүхий сонгогчдын байгууллага юм. Сонгуулийн коллеж нь 538 сонгогчтой, сонгуульд ялахад олонх буюу 270 сонгогчийн санал авсан байх шаардлагатай.

⁴⁰ АНУ-ын Үндсэн хууль, (1787).

https://www.constituteproject.org/constitution/United_States_of_America_1992?lang=en

⁴¹ Бразил Улсын Үндсэн хууль, (1988), https://www.constituteproject.org/constitution/Brazil_2017?lang=en

гарах бөгөөд хэрэв хоёр дахь санал хураалт болохоор байвал тухайн үеийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусах жилийн аравдугаар сарын сүүлийн ням гарагт дүн гаргаж, нэгэн зэрэг сонгоно.

Мөн нэр дэвшигчдийн аль нь ч эхний санал хураалтаар олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн үр дүнг танилцуулснаас хойш хорь хоногийн дотор дахин санал хураалт явуулах ба олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

Тус улсын Үндсэн хуулийн 82 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд сонгогдсон жилийн нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тоолно” гэсэн байна.

Бразил Улсын Ерөнхийлөгч нь дөрвөн жилийн хугацаатайгаар ард түмнээс шууд сонгогдох ба Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсантай адилаар “анхан болон дахин санал хураалт”-ыг хуульчилснаараа онцлог байна.

Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал: Энэхүү тогтолцоо нь парламентын засаглалтай адил Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гэсэн хоёр албан тушаалтан байх боловч ялгаатай нь Ерөнхийлөгч нь илүү “өдөр тутмын” шинжтэй чиг үүрэг хэрэгжүүлнэ.⁴² Энэхүү тогтолцооны гол төлөөлөл нь Франц бөгөөд тус улсаас улбаалан Румын, Шри-Ланка, Португал болон Францын колони байсан зарим улсууд “Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал”-ыг хэрэгжүүлдэг.

Жишээ 3 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Франц Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд⁴³ “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь бүх нийтийн сонгон шалгаруулалтаар таван жилийн хугацаатай сонгогдоно.”, 7 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь дийлэнх олонхийн саналаар сонгогдоно. Эхний санал хураалтаар олонхийн санал аваагүй бол түүнээс хойш арван дөрөв хоногийн дотор хоёр дахь санал хураалт явуулна. Эхний санал хураалтаар хамгийн олон санал авсан зөвхөн хоёр нэр дэвшигч хоёр дахь санал хураалтад оролцоно. Ерөнхийлөгч сонгох үйл явцыг Засгийн газраас зарласнаар хэлэлцэж эхэлнэ. Шинэ Ерөнхийлөгчийн сонгууль одоогийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас хориос доошгүй, гучин таваас дээшгүй хоногийн хугацаанд явагдана ...” гэж хуульчилжээ.

Франц Улс мөн Үндсэн хуульдаа дээрхээс гадна Ерөнхийлөгчийн сонгуулийн журмыг ерөнхийд нь боловч нэлээд дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан байна.

Монгол Улсыг тус тогтолцоонд буюу “Холимог парламентын засаглал”-тай улсад хамааруулах нь бий. Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлд Ерөнхийлөгчийн сонгуулийн ерөнхий журмыг зохицуулсан.

Парламентын бүгд найрамдах засаглал: Парламентын бүгд найрамдах засаглалын хувьд Ерөнхийлөгч нь де-факто, тодорхой гүйцэтгэх эрх мэдэлгүй (Австрийн Ерөнхийлөгчийн адил) эсхүл де-юре, тодорхой гүйцэтгэх эрх мэдэлгүй (Ирландын Ерөнхийлөгчийн адил) байх ба ихэвчлэн бэлгэ тэмдгийн шинжтэй албан тушаалтан байна. Энэхүү тогтолцоонд гүйцэтгэх эрх мэдэл олонхийн суудал авсан эрх баригч намын дарга болох Ерөнхий сайдад хадгалагдана. Гэсэн хэдий ч Ерөнхийлөгч нь төрийн албаны тэргүүн, зэвсэгт хүчний Ерөнхий командлагч байдаг.⁴⁴ Ийм засаглалтай улсад Австри, Армени, Албани, Бангладеш, Бүгд

⁴² MS Shugart "Comparative Executive–Legislative Relations" *The Oxford handbook of political institutions* (PDF). <https://doi.org/10.1093%2Foxfordhb%2F9780199548460.003.0018> (Сүүлд үзсэн: 2019.05.30)

⁴³ Франц Улсын Үндсэн хууль, (1958), https://www.constituteproject.org/constitution/France_2008?lang=en

⁴⁴ MS Shugart "Comparative Executive–Legislative Relations" *The Oxford handbook of political institutions* (PDF). <https://doi.org/10.1093%2Foxfordhb%2F9780199548460.003.0018> (Сүүлд үзсэн: 2019.05.30)

Найрамдах Чех, ХБНГУ, Унгар, Исланд, Энэтхэг, Ирланд, Израиль, Итали, Мальта, Пакистан, Сингапур зэрэг хамаарна.

Жишээ 4 (Парламентын бүгд найрамдах засаглал): Унгар Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд⁴⁵ 1. “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийг 5 жилийн хугацаагаар Парламентаас сонгоно.”, 2. “35-аас дээш насанд хүрсэн Унгар Улсын аливаа иргэн Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдоно.”, 3. “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа дахин сонгож болно.” гэж заасан бол тус хуулийн 11 дүгээр зүйлд 1. “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийг өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас гуч хоногоос доош, жар хоногоос дээшгүй хугацаанд эсхүл хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд гуч хоногийн дотор тус тус сонгоно. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацааг Танхимын Дарга тогтооно. Үндэсний Ассамблей Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийг нууц санал хураалтаар сонгоно.”, 2. “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг нэр дэвшүүлж явуулна. Үндэсний Ассамблейн гишүүдийн дор хаяж тавны нэг нь бичгээр санал болгосноор нэр дэвшүүлэлт хүчинтэй. Санал хураалт явуулахаас өмнө Үндэсний Ассамблейн дарга нэр дэвшигчдийг батална. Үндэсний Ассамблейн гишүүн тус бүр нэг нэр дэвшигчийг санал болгож болно. Хэрэв Үндэсний Ассамблейн гишүүн нэгээс илүү хүнийг нэр дэвшүүлбэл тухайн гишүүний санал болгосон бүх нэр дэвшигч хүчингүй.”, 3. “Эхний санал хураалтаар Үндэсний Ассамблейн гишүүдийн гуравны хоёрын саналыг авсан нэр дэвшигч Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдоно.”, 4. “Эхний санал хураалт үр дүнд хүрээгүй бол хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтад эхний санал хураалтад хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг оруулна. Эхний санал хураалтаар эхний байранд тэнцүү санал авсан бол хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг оруулна. Эхний санал хураалтаар хоёрдугаар байранд тэнцүү санал авсан бол хамгийн олон санал авсан болон хоёрдугаарт орсон нэр дэвшигчийг аль алиныг нь оруулна. Хоёр дахь санал хураалтаар санал өгөгчийн тооноос хамааралгүйгээр олонхийн хүчинтэй санал авсан нэр дэвшигч Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдоно.”, 5. “Санал өгөх үйл явц дараалсан хоёроос дээшгүй өдрийн дотор явагдаж дуусна ...” гэж хуульчилжээ.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Ерөнхийлөгчийн сонгууль” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” номонд: “Тус тольд энэхүү холбоо үгээр тайлбарлаагүй бөгөөд “Сонгууль” хэмээх үгийг – депутат, хариуцлагатай албан тушаалтан, байгууллагын гишүүдийг олноороо хэлэлцэж шилэн томилох; сонгууль хийх; сонгуулийн тойрог; нийт, тэгш, шууд, нууц саналаа өгөх сонгууль; сонгуулийн өмнөх хурал.”⁴⁶ гэсэн бол академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номонд: “англ. presidential election; ор. президентские выборы – МУ-д хоёр шаттай сонгууль. Анхан шатны сонгуульд УИХ-д суудалтай нам дангаараа буюу хамтран нэр дэвшүүлнэ.”⁴⁷; Э.Уранчимэг “Монгол хэлний шинэ үг, хэллэгийн толь” номондоо: “Улс төр, улсын ерөнхийлөгчийг ард түмний саналаар сонгох үйл ажиллагаа⁴⁸ гэж тайлбарласан байна.”

Дүгнэвэл, парламентын засаглалтай улсад Ерөнхийлөгч нь парламентаас сонгогдох бөгөөд жишээ болгон авсан Унгар Улсын хувьд Ерөнхийлөгчийн сонгууль, ялангуяа анхан

⁴⁵ Унгар Улсын Үндсэн хууль, (2011), https://constituteproject.org/constitution/Hungary_2016?lang=en

⁴⁶ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (УБ, 1966), 479 дэх тал.

⁴⁷ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (дөрөв дэх хэвлэлт) (УБ, 2015), 190 дэх тал.

⁴⁸ Э.Уранчимэг, Монгол хэлний шинэ үг, хэллэгийн толь, Монгол хэл соёл 13, (УБ, 2014), 115 дахь тал

болон хоёр дахь санал хураалтын талаар Үндсэн хуульдаа нэлээд дэлгэрэнгүй зохицуулсан байна.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХОЁР ШАТ

Ерөнхийлөгчийн сонгууль явагдах хэлбэр буюу нэг сонгуулийн хоёр үйлдэл. Өөрөөр хэлбэл, бие даасан хоёр шат биш бөгөөд нэг нь нөгөөгүйгээрээ орших боломжгүй, нийлээд нэг сонгуулийг бүрэлдүүлж буй үйл явц юм. Монгол Улсын хувьд сонгуулийн анхан шатанд Ерөнхийлөгчөө ард түмнээс шууд сонгож, хоёр дахь шатанд УИХ олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргадаг.

Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байх тухайд Монгол Улсын Үндсэн хуулийн төсөл хэлэлцэх үед зарчмын зөрөөтэй санал гарч байсныг эрдэмтэд тэмдэглэсэн нь бий.⁴⁹

Монгол Улсын Үндсэн хууль батлагдахаас өмнөх хувилбар	Монгол Улсын Үндсэн хуулийн батлагдсан хувилбар	Монгол Улсын Сонгуулийн тухай хууль ⁵⁰
<p>УБХ-аас Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байх бөгөөд анхан шатанд сонгогчдын санал хурааж хамгийн олон санал авсан хоёр хүнийг 2 дахь шатанд УИХ дээр өрсөлдүүлэн санал хурааж сонгох хувилбарыг ард түмнээр хэлэлцүүлэн АИХ-д өргөн мэдүүлсэн байв. Гэтэл “Бие даасан депутатуудын бүлэг” голлог “Ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгоно” гэсэн санал оруулж, “Ерөнхийлөгчөө сонгож чаддаггүй ард түмнийг ямар ард түмэн гэх вэ?”⁵¹ гэсэн маргаан өрнөжээ. Уул маргаан АИХ-ын хуралдаанаас хальж намуудын хоорондын болж өрнөөд “мухардалд орох” тийш хандсан тул УИХ-ын болон намуудын удирдагчдыг</p>	<p>Батлагдсан хувилбар нь Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай гэснээр төслийнхтэй адил мэт боловч 2 дахь шатанд 2 хүнийг өрсөлдүүлэх бус, харин “анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрнө” гэснээр ялгаатай болсон байна.⁵³</p>	<p>Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт “Хоёр дахь шатны сонгууль гэж анхан шатны сонгуульд оролцож саналаа гаргасан сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж УИХ түүний бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахыг хэлнэ” гэж заасан ба эрдэмтэд энэ заалтыг зүй ёсоор шүүмжилж, энд дурдсан хоёр дахь шатны сонгуулийг сонгуулийн бие даасан шат гэж үзэхгүй, учир нь энэ нь ард түмний сонголтыг дээд байгууллагаас хүлээн зөвшөөрч байгаа ердийн үйл явц бөгөөд нэр дэвшигчийг сонгох “сонгууль” явагддаггүй гэжээ.⁵⁴ Өөрөөр хэлбэл, “УИХ энд үзэмжээрээ шийдвэр гаргахгүй, нэг дэх шатанд олонхийн санал авсан нэр</p>

⁴⁹ Б.Чимид “Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал” Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь ОПБХ (УБ, 2003): 25 дахь тал.

⁵⁰ Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №4, (2016).

⁵¹ Б.Чимид “Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал” Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь ОПБХ (УБ, 2003): 27 дахь тал.

⁵³ Мөн тэнд, 26 дахь тал.

⁵⁴ Ч.Энхбаатар нар, Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг (УБ, 2015), 39 дэх тал.

<p>Ерөнхийлөгч зохицуулан зөвшилцөж, “ард түмнээс сонгох”, тэгэхдээ 2 дахь шат байна гэсэн дундын хувилбарт хүрч батлагдсан түүхтэй.⁵²</p>		<p>дэвшигчийн авч хэлэлцэн Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж албан ёсоор хүлээн зөвшөөрч хууль батлах үүрэгтэй. Үүнийг бүх нийтийн санал асуулгын дүнг парламент хууль батлах замаар баталгаажуулдаг бусад улсын практиктай харьцуулж болно. Энэ нь шийдвэрийг хоёрдмол байдлаар хүчин төгөлдөр болгож байгаа хэрэг биш, харин ард түмний илэрхийлсэн шийдвэрийг хууль зүйн хэлбэрт оруулж байгаа явдал юм”⁵⁵ хэмээн тайлбарласан байна.</p>
---	--	---

Монгол Улсын Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна гэж заасан. Уг нь нэр дэвшигчийн талаар нийт сонгогчдын санал хурааж, хамгийн олон санал авсан хоёр хүнийг УИХ-д оруулан өрсөлдүүлж, гишүүдийн саналыг нууцаар хураан олонхийн саналаар эцэслэн сонгох төслийг АИХ-д оруулсан байдаг. Түүнийг хэлэлцээд хоёр дахь шатны сонгуулийг дараах байдлаар өөрчилжээ.

Энэ заалтын ёсоор анхан шатны сонгуулийн дараа УИХ Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нь шалгаж хүлээн зөвшөөрөх нь 2 дахь шат болох бөгөөд үүгээрээ ард түмнээс сонгогдмогц бүрэн эрх олдог бусад зарим орны практикаас ялгаатай юм. Нэгэнт УИХ “зөвшөөрөх” хууль гаргах эрхтэй учир сонгууль зохих журмаар явагдаагүй, сонгогдогч Үндсэн хуулиар тавих шаардлагад нийцэхгүй гэж тогтоогдвол анхан шатны сонгуулийг хүчингүй болгох хууль зүйн үндэстэй нь учир шалтгааны үүднээс ойлгомжтой юм. Үүгээр нь Үндсэн хуульд “хоёр шаттай” хэмээн тооцож үлдээсэн байна.⁵⁶

Анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж түүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.⁵⁷

Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)-ийн Гучин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Ерөнхийлөгчийн сонгууль нь шууд сонгууль атлаа түүний хоёр дахь шатыг тодорхой илэрхийлээгүй мэт боловч Сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Анхан шатны сонгууль гэж сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн төлөө саналаа нууцаар гаргаж, Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийг хэлнэ.” гэж, мөн зүйлийн 9.2-т “Хоёр дахь шатны сонгууль гэж анхан шатны сонгуульд оролцож саналаа гаргасан сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж УИХ түүний бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахыг хэлнэ.”⁵⁸ гэж тус тус тодорхойлон бичжээ. Энэ нь сонгуулийн хоёр дахь шатанд

⁵² Мөн тэнд.

⁵⁵ Мөн тэнд.

⁵⁶ Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, (Уб, 2008), 260 дахь тал.

⁵⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, (1992).

⁵⁸ Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №4, (2016),

сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрч хууль гаргах боломжгүй, шинэ нөхцөл байдал илэрвэл сонгуулийн хоёр дахь шатанд эцсийн шийдвэр гаргах эрх бүхий төлөөлөгчдийн байгууллага болох УИХ-ын саналыг сонгуулийн хоёр дахь шат гэж үзэж буй болно.⁵⁹

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр шат” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна;”, Сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгчийн сонгууль нь дараах шаттай байна”, 9.1.2-т “анхан шат;”, 9.1.3- т “хоёр дахь шат.”, мөн тус зүйлийн 2 дахь хэсэгт “Анхан шатны сонгууль гэж сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн төлөө саналаа нууцаар гаргаж, Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийг хэлнэ.”, 3 дахь хэсэгт “Хоёр дахь шатны сонгууль гэж анхан шатны сонгуульд оролцож саналаа гаргасан сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж УИХ түүний бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахыг хэлнэ.” хэмээн тусгаж өгсөн бол Г.Совд нарын “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” номонд: “Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна гэдэг бол сонгууль бүрд заавал дамжих ёстой биш, шаардлагатай үед хоёрдахь шатаар дамжиж болох заалт юм. Хэрэв Ерөнхийлөгчийн сонгуулийн анхан шатны санал хураалтад гурав буюу түүнээс дээш тооны нэр дэвшигч оролцоод тэдгээрийн хэн нь санал хураалтад оролцсон сонгогчдын олонхийн санал авч чадаагүй бол тайлбарлан буй зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг дахин санал хураалтад оруулж сонгох боломжийг нээлттэй орхисныг хоёр дахь шат гэж ойлгох нь зүйтэй.”⁶⁰ гэж тайлбарлажээ.

Дүгнэвэл, Монгол Улсын хувьд сонгуулийн анхан шатанд Ерөнхийлөгчөө ард түмнээс шууд сонгож, хоёр дахь шатанд УИХ олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрдөг хоёр шат бүхий тогтолцоотой болохыг Үндсэн хуулиар баталгаажуулсан байна.

АНХАН БОЛОН ДАХИН САНАЛ ХУРААЛТ

Дахин санал хураалтыг улсуудын сонгуулийн эрх зүйд “Two-round system” буюу “Хоёр тойргийн тогтолцоо” гэсэн нийтлэг нэр томъёогоор илэрхийлдэг. Түүнчлэн, хоёрдугаар санал хураалт (*англ.* second ballot), сүүлийн шатны санал хураалт (*англ.* runoff voting), хоёр дахь санал хураалт (*англ.* ballotage) зэрэг нэр томъёогоор зарим улсад хэрэглэх нь бий.

Дахин санал хураалт буюу “Хоёр тойргийн тогтолцоо”-г Ерөнхийлөгч, Парламент, орон нутгийн сонгуулийн аль алинд нь хэрэглэдгээрээ Франц Улс энэхүү ойлголтын гол төлөөлөл болдог ба дэлхий даяар 40 гаруй улс Ерөнхийлөгчөө сонгохдоо тус аргыг хэрэглэж байна.⁶¹

Сонгуулийн эрх зүйд санал хураалт явуулах хэд хэдэн арга байдгаас “дахин санал хураалт” нь нэр дэвшигчдээс гагцхүү нэг нь сонгогдох зорилго бүхий санал хураах арга хэлбэр юм. Үүний дагуу эхний санал хураалтад нэр дэвшигчдийн аль нь ч олонхийн санал авч

⁵⁹ П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль /хэрэгжилт, хяналт, судалгаа/, (УБ, 2017), 186 дахь тал.

⁶⁰ Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2000), 162 дахь тал.

⁶¹ Electoral Reform Society “Two-Round System”, <https://www.electoral-reform.org.uk/voting-systems/types-of-voting-system/two-round-system/> (сүүлд үзсэн: 2019.05.01)

чадаагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг тодруулж, хоёр дахь санал хураалтыг явуулдаг.⁶²

Хэдийгээр хоёр дахь санал хураалтаас цааш гурав дахь санал хураалт гэж байхгүй, дээр дурдсан хоёр хувилбар үлдэх боловч дэлхийн улсууд “хоёр-тойргийн тогтолцоо”-г өөр өөрсдийн арга хэлбэр, журмаар зохицуулж байгаа буюу хоёр дахь санал хураалтад хоёроос илүү нэр дэвшигч оролцохыг зөвшөөрдөг улс ч байна. Энэ хувилбарын дагуу хоёр дахь санал хураалтаар сонгогдоход бусдаасаа саналын тоогоор илүүрхэж байхад хангалттай ажээ. Тухайлбал, Чех болон Кени Улсад энэ аргаар хоёр дахь санал хураалтыг явуулдаг.⁶³ Мөн зарим цөөн тохиолдолд, тухайлбал, Гана Улсад хоёр дахь санал хураалтад хэн нь ч олонхийн санал авч чадаагүй бол гурав дахь санал хураалтыг явуулдаг байна. Гэвч ихэнх улсад эхний санал хураалтаар хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг дахин санал хураалтад оруулах хувилбар зонхилж байна.

Түүх сөхвөл, анх Германы Эзэнт гүрний үед буюу 1871-1918 оны хооронд Райхстаг (тухайн үеийн Германы хууль тогтоох байгууллага)-ийн сонгууль болон 1908-1911 оны Шинэ Зеландын сонгууль хоёр удаагийн санал хураалттай болж байжээ. Түүнчлэн, 1925, 1932 онуудад Ваймарын Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч “хоёр-тойргийн тогтолцоо”-гоор сонгогдсон бөгөөд сонирхолтой нь, эхний санал хураалтад оролцоогүй нэр дэвшигч хоёр дахь санал хураалтад оролцож болох ба сонгогдохын тулд заавал олонхийн санал авсан байхыг шаардаагүй байна.⁶⁴

“Хоёр-тойргийн тогтолцоо” буюу дахин санал хураалтыг ойлгомжтой, хөгжилтэй байдлаар (тухайлбал, нэр дэвшигчдийг жимс, ногоогоор төлөөлүүлэн тайлбарласан жишээ байна) тайлбарласан жишээ цахим орчинд байршсан сонгуулийн эрх зүйн гарын авлагуудад олон байгаагаас энд дурдвал:

Жишээ 1: АНУ-ын Теннесси мужийн нийслэл хотыг сонгох санал хураалт⁶⁵

АНУ-ын Теннесси муж нийслэл хотоо сонгох гэж байна гэж үзье. Тус мужийн хүн ам 4 томоохон хотдоо төвлөрөн суурьшдаг. Бүх сонгогчид эдгээр хотод амьдардаг гэж үзвэл нийслэлээ аль болох өөрийн амьдардаг хотод ойрыг сонгохыг эрмэлзэнэ.

Нийслэл хотод нэр дэвшигчид нь:

Мемфис, мужийн хамгийн том хот боловч бусад хотуудаасаа хол зайтай

Нэшвилл

Ноксвилл

Чаттануга

Эхний санал хураалт /Round 1/:

Мемфис: 42%

Нэшвилл: 26%

Ноксвилл: 17%

Чаттануга: 15%

Хоёр дахь санал хураалт /Round 2/:

Эхний санал хураалтаар аль нь ч олонхийн буюу 50%-иас дээш санал аваагүй тул хамгийн олон санал авсан Мемфис, Нэшвилл хотуудыг хоёр дахь санал хураалтад оруулахаар

⁶² Eric Pacuit, "Voting Methods", *The Stanford Encyclopedia of Philosophy* (Fall 2017 Edition), Edward N. Zalta (ed.), <https://plato.stanford.edu/archives/fall2017/entries/voting-methods/>

⁶³ Electoral Reform Society "Two-Round System", <https://www.electoral-reform.org.uk/voting-systems/types-of-voting-system/two-round-system/> (сүүлд үзсэн: 2019.05.01)

⁶⁴ Dieter Nohlen, Philip Stöver, *Elections in Europe: A Data Handbook*, (Baden-Baden: Nomos, 2010), p.762.

⁶⁵ *Tenn Voting Example* /Тус жишээ нь бодит бус, зохиомол жишээ болно./

боллоо. Энэхүү санал хураалтад эхний санал хураалтаар Мемфис болон Нэшвилл хотод саналаа өгсөн сонгогчдын санал хэвээр бөгөөд хасагдсан хоёр хотын сонгогчид саналаа хуваах шаардлагатай. Ийнхүү санал хураалтын үр дүн дараах байдлаар гарав:

Нэшвилл: 58%

Мемфис: 42%

Үр дүнгээс үзвэл, хоёр дахь санал хураалтаар Нэшвилл хот олонхийн санал авч ялагч болсон байна. Гэтэл эхний санал хураалтад Нэшвилл ердөө 26%-ийн санал авсан билээ. Учир нь Мемфис хот хэдийгээр эхний тойрогтоо давуу санал авсан ч бусад хотуудаасаа хамгийн хол зайтай нь юм. Үүнээс дүгнэвэл, эхний санал хураалтад давуу байсан нь дараагийн санал хураалтад мөн ялна гэсэн үг биш бөгөөд саналын тоо хоёр дахь санал хураалтаар яаж ч өөрчлөгдөх боломжтой.

Жишээ 2: Франц Улсын Ерөнхийлөгчийн сонгууль – 2002⁶⁶

Эхний санал хураалт /Round 1/:

Эхний жишээнээс ялгаатай нь энэ бол бодит тохиолдол юм. 2002 оны Франц Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд Францын гол хоёр намаас нэр дэвшигчид болох Жак Ширак, Лионель Жоспен нарыг ялах өндөр магадлалтай гэж байв. Гэсэн хэдий ч саналын хуудас дээр нийт 16 нэр дэвшигчийн нэр байсан бөгөөд эхний санал хураалтад хамгийн олон санал авсан гурван нэр дэвшигч нь:

Жак Ширак: (Баруун төвийн нам) 19.88%

Жан-Мари Ле Пен: (Хэт барууны нам) 16.86%

Лионель Жоспен: (Зүүн төвийн нам) 16.18% нар байлаа.

Хоёр дахь санал хураалт /Round 2/:

Ийнхүү хэн нь ч эхний санал хураалтад олонхийн саналыг авч чадаагүй тул хоёр дахь санал хураалтыг явуулсан бөгөөд хоёр дахь санал хураалтад оролцоогүй намын дэмжигчид Ле Пенээс илүү Ширакад саналаа өгснөөр Ширак маш давуу ялалт байгуулсан байна.

Жак Ширак: 82.21%

Жан-Мари Ле Пен: 17.79%

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай явагддагийн хувьд “дахин санал хураалт” нь гагцхүү эхний шатанд хамаарах ойлголт билээ. Тодруулбал, Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулах тухай болно. Хуулийн зохицуулалтаас үзвэл, хоёр дахь санал хураалт нь анхан шатны сонгуулийн сүүлийн үе шат бөгөөд гурав дахь санал хураалт гэж байхгүй, энэ үе шатын дараа (1) нийт сонгогчийн олонхийн санал авсан хүнийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж УИХ-аас бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, (2) хэн нь ч олонхийн санал аваагүй бол дахин сонгууль явуулах гэсэн хоёр хувилбар байна. Энэ утгаар Монгол Улсын зохицуулалт нь “дахин санал хураалт”-ын талаарх сонгуулийн эрх зүйн нийтлэг зарчим, утгад нийцэж байна гэж үзэх үндэслэлтэй.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Анхан болон дахин санал хураалт” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” номонд: “**Санал хураалт** – (санал хураах явц, санал хураах үйлийн нэр)”⁶⁷, академич Ж.Амарсанаа нарын “Эрх зүйн мэдлэгийн

⁶⁶ Raymond Kuhn “The French presidential and parliamentary elections”, *Representation* Vol. 39, (2002), p.46, <https://www.tandfonline.com/doi/abs/10.1080/00344890208523213?journalCode=rrep20>

⁶⁷ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (УБ, 1966 он), 468 дахь тал.

товч толь” номонд: “**Санал хураалт** – Улс орны дотоод амьдралын, тухайлбал хуулийн төслийн зэрэг асуудлаар ард нийтээс санал авах ажиллагааг санал хураалт гэнэ. Олон улсын харилцааны хүрээнд санал асуултаар аливаа нэг нутаг дэвсгэрийн улсын харьяаллын талаар ард түмний хүсэл зоригийг тодорхойлдог. Иймд санал хураалт нь ард түмэн үндэстний хүсэл зоригийг илэрхийлэх нэг хэлбэр юм⁶⁸, академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номонд: “**Санал хураалт** – (англ. voting; poll; ор. голосование) – *сонгууль ард нийтийн санал асуулгаар* хамтын шийдвэр гаргах ба *парламентад* шийдвэр гаргах арга.”⁶⁹ хэмээн тус тус тайлбарласан байна.

Дүгнэвэл, санал хураалт явуулах олон арга хэлбэр байдгийн нэг нь “хоёр-тойргийн тогтолцоо” буюу хоёр дахь санал хураалт явуулах бөгөөд энэхүү хоёр дахь санал хураалт явуулахыг Гиббард-Саттертвэйтийн теором (англ. Gibbard–Satterthwaite theorem)-ийн дагуу санал хураах тактик хийгээд нэр дэвших стратеги гэж үздэг.⁷⁰ Учир нь олон нэр дэвшигчийг оролцуулж, “санал хуваах” замаар сонгуулийн үр дүнд нөлөөлдөг байна.⁷¹ Дээр дурдсанчлан Франц Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь энэхүү санал хураах аргын хамгийн түгээмэл жишээ юм. Харин Монгол Улсын тухайд Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 5 болон 6 дахь хэсэгт зааснаас үзвэл тус ойлголтыг “дахин санал хураалт”, “хоёр дахь санал хураалт” гэсэн хоёр төрлийн нэр томъёогоор илэрхийлжээ. Харин СтХ-ийн 105 дугаар зүйлд “Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр дахь санал хураалт явуулах” хэмээн “хоёр дахь санал хураалт” гэсэн томъёоллоор хуульчилсан байна. Хэдийгээр эдгээр нь хоёрдмол утга агуулахгүй, нэг утгыг илэрхийлж буй боловч нэр томъёоны ялимгүй ялгааг нэг мөр болгох шаардлагатай байж мэдэх юм.

ТАНГАРАГ ӨРГӨХ

Тангараг хэмээх үг нь латин хэлний “iugo” хэмээх үгнээс үүдэлтэй⁷² бөгөөд англи хэлний “oath” орос хэлний “*присяга*” хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд ямар нэгэн үүргийг сахин биелүүлэхээ албан ёсоор ба ёслол төгөлдөр амлах (тангараглах)⁷³ гэсэн утгатай.

Тангараг өргөх өдөр нь улс төрийн албан тушаалтнуудаас ихэвчлэн Ерөнхийлөгчид хамаарах ойлголт ба хэдий ёслол, бэлгэдлийн шинжтэй боловч ач холбогдолтой үйл ажиллагаа юм. Энэ хэсэгт Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, өргөх тангарагтай холбоотой улсуудын Үндсэн хуулийн зохицуулалтыг судалж, тогтолцоо бүрээр төлөөлөл болгон авч үзье.

Жишээ 1 (Парламентын бүгд найрамдах засаглал): Бүгд Найрамдах Исланд Улсын Үндсэн хуулийн 80 дугаар зүйлд⁷⁴ “Исландын Ерөнхийлөгч нь албан тушаалаа хүлээн авахдаа Үндсэн хуулийн өмнө гарын үсэг зурж, тангараг өргөнө”;

Жишээ 2 (Парламентын бүгд найрамдах засаглал): Унгар Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан эсхүл бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бол сонгуулийн дүнг зарласнаас хойш найм дахь өдөр ажлаа хүлээн авна; Бүгд

⁶⁸ Ж.Амарсанаа, Эрх зүйн мэдлэгийн товч толь, (УБ, 1986), 118 дахь тал.

⁶⁹ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (дөрөв дэх хэвлэлт), (УБ, 2015), 363 дахь тал.

⁷⁰ Allan Gibbard "Manipulation of voting schemes: A general result", *Econometrica* 41 (4): p.587–601 <https://www.jstor.org/stable/1914083>

⁷¹ Мөн тэнд.

⁷² Латин-Англи толь бичиг, <https://latin-dictionary.net/search/english/oath>

⁷³ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ,2007) 407 дахь тал.

⁷⁴ Исланд Улсын Үндсэн хууль, (2011), https://constituteproject.org/constitution/Iceland_2011D?lang=en

Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн ажлаа хүлээн авахдаа Үндэсний Ассамблейн өмнө тангараг өргөнө”;

Жишээ 3 (Парламентын бүгд найрамдах засаглал): Пакистан Улсын Үндсэн хуулийн 42 дугаар зүйлд⁷⁵ “Бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө Ерөнхийлөгч нь гурав дахь хуваариар тогтоосон журмын дагуу Пакистан Улсын Хууль зүйн Сайдын өмнө тангараг өргөнө”;

Жишээ 4 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Португал Улсын Үндсэн хуулийн 127 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Улсын Ассамблейн өмнө ажлаа хүлээж авна, 2 дахь хэсэгт “Тангараг өргөх өдөр нь өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан эсхүл бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бөгөөд сонгуулийн дүн нийтлэгдсэнээс хойш найм дахь өдөр байна.”, 3 дахь хэсэгт “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч ажлаа хүлээн авахдаа дараах тангараг өргөнө: “Надад олгогдсон үүргийг шударгаар биелүүлж, Бүгд Найрамдах Португал Улсын Үндсэн хуулийг хамгаалж, чанд сахин мөрдөхөө хүндэтгэлтэйгээр тангараглая””;

Жишээ 5 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Румын Улсын Үндсэн хуулийн 82 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт⁷⁶ “Хүчин төгөлдөр сонгуулиар сонгогдсон нэр дэвшигч нь Сенат болон Төлөөлөгчдийн Танхимын өмнө хамтад нь дараах тангараг өргөнө: Бүх хүчин чадал, чармайлтаа Румын Улсын ард түмний биеийн болон оюуны сайн сайхны төлөө зориулж, улсын Үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэн ардчилал, иргэдийн үндсэн эрх, эрх чөлөө, Румын Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эв нэгдэл, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалахаа чин сэтгэлээсээ тангараглая. Үүний тулд Бурхан надад туслаг!”;

Жишээ 6 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): АНУ-ын Үндсэн хуулийн II зүйлийн 1 дэх хэсэгт “Ерөнхийлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө дараах тангараг буюу баталгааг үйлдэнэ: “Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчийн чиг үүргийг шударгаар биелүүлж, бүх чадлаараа Нэгдсэн Улсын Үндсэн хуулийг чандлан сахиж, батлан хамгаалахаа чин сэтгэлээсээ тангараглая””;

Жишээ 7 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Мексикийн Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд⁷⁷ “Ерөнхийлөгч албан үүргээ хүлээж авахдаа Конгрессын өмнө эсхүл Конгрессын чөлөө цагт Түр хорооны өмнө дараах тангарагийг өргөнө: “Миний бие Мексикийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль болон түүнээс үүдэн гарсан бусад хуулийг чанд сахиж, ард түмнээс надад өгсөн Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн үүргийг үнэнч, эх орончоор биелүүлж, тэдний сайн сайхан, улсынхаа хөгжил цэцэглэлтийн төлөө ажиллахаа тангараглая; хэрэв энэхүү үүргээ биелүүлж чадахгүй аваас Үндэстэн намайг хүчлэн шаардах болтугай.”, Ерөнхийлөгч тангарагийг дээр заасан журмаар өргөх боломжгүй аливаа тохиолдолд нэн даруй Нэгдсэн Конгрессын Танхимын зөвлөлийн гишүүдийн өмнө тангараг өргөнө” гэжээ.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Тангараг өргөх” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсэгт: “Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхэлж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно” хэмээн заасан бол Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” номонд: “Тангараг - ам алдах, тангараг тавих”, академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номонд: “Тангараг –(англ. *oath*; ор. *присяга*) ямар нэгэн үүргийг сахин биелүүлэхээ албан ёсоор ба ёслол төгөлдөр амлах (тангараглах). Т.-ыг улс орны ерөнхийлөгч албан тушаалд орохдоо өргөдөг. МУ-д үзэгч,

⁷⁵ Пакистан Улсын Үндсэн хууль, (1973), https://constituteproject.org/constitution/Pakistan_2017?lang=en

⁷⁶ Румын Улсын Үндсэн хууль, (1991), https://constituteproject.org/constitution/Romania_2003?lang=en

⁷⁷ Мексик Улсын Үндсэн хууль, (1917), https://constituteproject.org/constitution/Mexico_2015?lang=en

цагдаагийн албан хаагч зэрэг төрийн нэлээд хэд хэдэн албан тушаалтан тангараг өргөх тухай заажээ.”⁷⁸, Г.Совд нарын “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” номонд: “Санал хураалтад оролцсон сонгогчдын олонхийн санал авч сонгогдсон Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг албан ёсоор нийтэд зарласан өдрөөс хойш гуч хоногийн дотор УИХ-ын чуулганаар хэлэлцэж, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргадаг. Ийнхүү Ерөнхийлөгч энэ чуулган дээр тангараг өргөж сэнтийдээ залран бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлдэг. Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын журмыг УИХ тогтоодог. Ерөнхийлөгчийн тангараг нь хуульд бичигдсэн хэлбэрийн хувьд товч боловч агуулгын хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх, үүрэг, хариуцлагыг бүгдийг багтаасан гүнзгий агуулгатай, ямар ч тайлбар, шалтгаангүй хэрэгжүүлэх ёстой Үндсэн хуулийн хэм хэмжээ юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрхэмлэн хамгаалах эрдэнэ нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, ард түмний эрх чөлөө, дээдлэн сахих шүтээн нь Монгол Улсын Үндсэн хууль, шударгаар сахин биелүүлж байх хууль зүйн болон ёс зүйн дээд зарчим нь Ерөнхийлөгчийн үүрэг байх юм. Хэрвээ Ерөнхийлөгч энэ тангарагийнхаа аль нэг зүйлийг санаатай болон болгоомжгүйн аль нэг хэлбэрээр өчүүхэн төдий зөрчвөл хүлээх хууль зүйн хариуцлага нь Ерөнхийлөгчийг албан тушаалаас огцруулах үүргийн санкцтай. Тангараг гэгчийн хатуу сахилга, хууль цаазын хүчин чадал энэ болой.”⁷⁹

Харин Б.Чимид агсан бичихдээ тангараг өргөнө гэдэг бол “эцсийн өндөр хариуцлагыг нийт ард түмнийхээ өмнө хүлээж буйн дээд илрэл юм. Тангарагаасаа няцвал Ерөнхийлөгчийг огцруулах Үндсэн хуулийн анхдагч үндэслэл болдогийн учир энд буй.” хэмээжээ.

Дүгнэвэл, Ерөнхийлөгчид гүйцэтгэх эрх мэдэл хадгалагддаггүй буюу парламентын бүгд найрамдах засаглалтай улсын Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн тангарагийн талаар товч дурдсан байхад эсрэгээрээ Ерөнхийлөгчийн болон Хагас-Ерөнхийлөгчийн засаглалтай улсад тангарагийн талаар нэлээд дэлгэрэнгүй хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, засаглалын хэлбэр, тогтолцоо буюу Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээнээс хамааран тангараг өргөх өдөр мөн Ерөнхийлөгчийн тангараг өргөхдөө хэлэх үгийн талаарх зохицуулалт ялгаатай байна. Ингэхдээ тухайн улсын үнэт зүйлээс хамааруулан үг хэллэг (шашны холбогдолтой зэрэг үгс) мөн өөр байна.

ЗАРЛИГ

Зарлиг гэдэг нь Түрэг хэлний “Jrlg ~ yarlig”⁸⁰ хэмээх үгнээс үүдэн Монгол Улсад хэрэглэгдэж ирсэн бөгөөд англи хэлний “decree” орос хэлний “указ”⁸¹ гэсэн үгтэй дүйцүүлэн хэрэглэдэг. Уг нэр томъёог түүхийн үүднээс янз бүрээр тайлбарлаж ирсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд уг нэр томъёо нь 13-н удаа давтагдсан байх бөгөөд Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд гаргадаг эрх зүйн актыг зарлиг⁸² гэдэг агуулгаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгч нь бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргадаг шийдвэрийг албажуулан баталсан эрх зүйн акт нь зарлиг ба захирамжийн хэлбэртэй байна. Захирамж нь тодорхой асуудлын талаар гаргасан шийдвэр

⁷⁸ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ, 2007), 407 дахь тал.

⁷⁹ Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2000), 162-164 дахь тал

⁸⁰ Ж.Амарсанаа, Монгол улсын Үндсэн хуульд орсон харь үг, (УБ,2013), 8 дахь тал.

⁸¹ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ, 2007), 202 дахь тал.

⁸² Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ,2000), 180 дахь тал.

байдаг бол Зарлиг нь хэм хэмжээ тогтоосон байдгаараа зориулалт, үйлчилэх цар хүрээ, эрх зүйн үр дагавраараа ялгаатай.⁸³

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг (англ. decrees of the president of Mongolia; ор. Указ президента Монголия)- Ерөнхийлөгчөөс бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль, бусад хуулиудад нийцүүлэн гаргасан эрх зүйн акт. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг нь дараах нэн чухал шинжтэй⁸⁴ гэж зарим эрдэмтэн үзсэн байна. Үүнд:

- Эрх зүйн актын тогтолцоонд Үндсэн хууль, хууль, УИХ-н бусад шийдвэр, Засгийн газрын тогтоолын дараах байр суурийг эзэлнэ;
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх ба чиг үүргийн эрх хэмжээнд багтах нийгмийн харилцааг зохицуулна
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөнө;
- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна.

Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг гаргах бүрэн эрхтэй боловч энэ нь Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог. Харин Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлд зааснаар, Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээний бусад асуудлаар гаргасан зарлиг нь давхар баталгаажуулалт шаардахгүй.

Зарлиг нь хууль зүйн хүчин чадлаараа ялгагдана. Хэм хэмжээний тогтоосон зарлиг нь эрх зүйн хэм хэмжээг агуулсан бөгөөд дахин давтан хэрэглэгдэх үйлчилгээтэй байдаг. Жишээ нь, онц байдал зарласан, бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарласан зэрэг зарлигууд нь тодорхой нөхцөл байдалтай холбоотой асуудлуудыг зохицуулдаг бөгөөд тэр нөхцөл байдал арилаагүй цагт дахин давтагдан хэрэглэгдэж үйлчилдэг юм.⁸⁵ Хэм хэмжээний бус зарлиг нь эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх акт юм.⁸⁶ Жишээ нь Улсын Ерөнхий шүүгчийг буюу Ерөнхий прокурорыг томилох, иргэнийг одон медалиар шагнах, цол хүртээх ялтан этгээдэд уучлал үзүүлэх гэх мэт зарлигууд багтдаг.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Зарлиг” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: “Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана.” хэмээн заасан бол Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” номонд: “Улсын дээд бүрэн эрхийг барих газраас гаргасан хуулийн чанартай шийдвэр, их хурлын тэргүүлэгчдийн зарлиг, хааны хэлсэн зарласан үг ба бичиг хааны зарлиг эзний зарлиг, хүндэтгэвэл зохих хүний хэлсэн үг багшийн зарлиг ноёны зарлиг ламын зарлиг;”⁸⁷, академич Ж.Амарсанаагийн “Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг” номонд: “хааны тунхаг; улсын эрх барих газар, албан тушаалтнаас гаргасан шийдвэр; хааны хэлсэн, зарласан үг болон бичиг;”⁸⁸ гэсэн бол академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” номондоо “Монгол улс болон хэд хэдэн улсад төрийн тэргүүний (ерөнхийлөгчийн) гаргадаг нэлээд чухал эрх зүйн актын нэр. Зарлигаар дээд албан тушаалтныг томилох ба албан тушаалаас чөлөөлөх, одон, медалиар шагнах, цэргийн дээд цол ба хүндэт цол олгох зэрэг

⁸³ ХБНГУ-н Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2009), 171 дахь тал.

⁸⁴ Ш.Цогтоо, Ерөнхийлөгчийн институт ба Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, *Эрх зүй сэтгүүл*, №2, (2014), 67 дахь тал.

⁸⁵ Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2000), 180 дахь тал.

⁸⁶ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ, 2007), 281 дахь тал.

⁸⁷ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (УБ, 1966), 268 дахь тал.

⁸⁸ Ж.Амарсанаа, Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг, (УБ, 2013), 8 дахь тал.

асуудлыг шийдвэрлэнэ. Нийтлэг журмын дагуу зарлиг нь тухайн улсын Үндсэн хууль ба бусад хуульд нийцсэн байх ёстой⁸⁹, О.Сүхбаатарын “Монгол хэлний харь үгийн толь” номонд: “1. Улсын эрх барих газраас хуулийн чанартай шийдвэр, 2. Хаан хүний хэлсэн үг, зарласан үг болон бичиг, 3. Хүндтэй хүний хэлсэн үг⁹⁰ хэмээн тус тус тодорхойлсон байна.

Дүгнэвэл, “Зарлиг” хэмээх үг нь эртнээс Монгол хэлний үгийн санд хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд одоо хүртэл зарлиг гаргах этгээд нь өөрчлөгдсөнөөс утгын хувьд гажаагүй байна.

ОГЦРУУЛАХ

Огцруулах хэмээх нэр томъёог англи хэлний “resignation”; “retirement” орос хэлний “отставка”⁹¹ гэсэн нэр томъёотой утга дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд латин хэлний “renuntiatio”⁹² үгнээс гаралтай. Нийтлэг утгаараа огцруулах хэмээх нэр томъёог албан тушаалтныг тодорхой эрхэлж буй албан тушаалаас нь хасах буюу халах гэж ойлгож болохоор байгаа бол төрийн өндөр албан тушаалтныг огцруулж хариуцлага хүлээлгэх асуудлыг импечментийн журмаар шийдвэрлэж улмаар сонгууль болон ард нийтийн санал асуулгыг хүчингүйд тооцох зэрэг үр дагаврыг бий болгодог байна.⁹³

Иймд гадаадын зарим оронд Ерөнхийлөгчийг огцруулах буюу импечмент⁹⁴ хийх асуудлыг хэрхэн журмалсан талаар авч үзье.

Жишээ 1: АНУ-ын 1787 оны Үндсэн хуульд заасан импечментийн сонгодог загвар нь парламентын доод танхим ялгааг томъёолон дэвшүүлж, харин дээд танхим нь шүүхийн журмаар ялгааг хянан үзэж, шийдвэрээ гаргана.⁹⁵ Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт зааснаар: “Ерөнхийлөгч эх орноосоо урвасан, хахууль болон ийм төрлийн гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчил гаргасны төлөө импечментээр албан тушаалаас нь огцруулж болно”⁹⁶ хэмээн заасан байдаг. Импечмент хийхийн тулд дараах үе шатыг дамжсан байх шаардлагатай. Үүнд:

Нэгдэх шат: АНУ-ын Конгрессийн төлөөлөгчдийн танхим Ерөнхийлөгчийн эсрэг мөрдөн шалгах тусгай (бие даасан) прокурор томилохыг хүснэ.

Хоёр дахь шат: АНУ-ын хууль зүйн сайдын хүсэлтээр гурван холбооны шүүгчдийн зөвлөл тусгай прокурорыг томилж, мөрдөн шалгах ажлын хүрээг тогтоож өгнө.

Гурав дахь шат: Тусгай прокурор нь өөрийн ажилтнуудыг бүрдүүлж, буруутгаж буй асуудлаар нарийн мөрдөн шалгалт хийж, хэргийн талаар цуглуулсан бүх нотлох баримтыг Төлөөлөгчдийн танхимд шилжүүлж өгнө.

Дөрөв дэх шат: Төлөөлөгчдийн танхим хэргийн талаар авсан нотлох баримтуудыг хэлэлцэж ердийн олонхоор Ерөнхийлөгчийг огцруулах тухай шийдвэр гаргана: хэрэв энэхүү хэргийн талаарх буруутгасан дүгнэлтийг танхим дэмжиж байгаа бол импечментийн тухай зүйл гэгчийг бэлдэнэ, түүнд Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэл бүрийг нарийн заадаг. Үүний дараа Синетад хэлэлцүүлэхээр импечментийг хүргүүлнэ.

⁸⁹ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ, 2007), 202 дахь тал.

⁹⁰ О.Сүхбаатар, Монгол хэлний харь үгийн толь, (УБ, 2018), 135 дахь тал.

⁹¹ Мөн тэнд, 332 дахь тал.

⁹² Латин хэлний толь бичиг, <https://www.latin-dictionary.net/search/english/retirement>

⁹³ Ж.Амарсанаа нар, Хууль зүйн тайлбар толь, (УБ, 2003), 275 дахь тал.

⁹⁴ Өндөр албан тушаалтныг огцруулах.

⁹⁵ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ, 2007), 229 дахь тал.

⁹⁶ АНУ-ын Үндсэн хууль, Хоёрдугаар зүйл, (1787).

Тав дахь шат: Сенатад буруутгалыг дэмжүүлэх үүднээс төлөөлөгчдийн танхим яллагчийг томилно.

Зургаа дахь шат: Сенатын Ерөнхийлөгч (өөрөөр хэлбэл, АНУ-ын ерөнхийлөгч буюу АНУ-ын түр ерөнхийлөгч) Дээд шүүхийн даргыг Импечментийн шүүхийн даргын хувьд нь тангараг өргүүлж, хурал даргалуулахаар урина. Импечментийн шүүхийн дарга юуны өмнө импечментийн тангарагтны шүүхийн хувьд нь АНУ-ын бүх Сенатын гишүүдээр тангараг өргүүлнэ: төлөөлөгчдийн танхимын нэрийн өмнөөс ялагчид Импечментийн шүүхийн өмнө импечменттэй холбогдсон зүйл ангиудыг ёс төдий тунхаглана.

Долоо дахь шат: Импечментээр ерөнхийлөгчийн эсрэг буруутгаж буй үндэслэл, түүнчлэн эдгээр асуудалд түүнээс хариу авах хугацааг тодорхойлон заасан шүүхийн мэдэгдлийг баталж Ерөнхийлөгчид илгээнэ. Шүүхийн мэдэгдлийг Сенатын түшмэл (гүйцэтгэгч) Цагаан ордонд ёс төдий гардуулна.

Найм дахь шат: Импечментийн шүүхээс ирүүлсэн Ерөнхийлөгчийн эсрэг дэвшүүлсэн бичгийг үндэслэн Ерөнхийлөгчөөс, түүний өмгөөлөгчид (өөрөөр хэлбэл, түүний өмгөөлөгчдийн команд) “Ерөнхийлөгч гэм буруугаа хүлээж байна”, эсхүл “Ерөнхийлөгч гэм буруугүй” гэсэн агуулгатай хариуг илгээнэ түүнчлэн ялагчид төлөөлөгчдийн танхимын нэрийн өмнөөс өөрсдийн буруутгаж буй үндэслэлийг Импечментийн шүүхэд явуулна.

Ес дэх шат: Хэргийг шүүхээр хэлэлцэхэд эхлээд ялагчид өөрсдийн үндэслэгээг дэвшүүлнэ: дараа нь өмгөөлөгчид буруугүй болох талаар өөрсдийн үндэслэлээ гаргаж тавина.

Арав дахь шат: Шүүхээр хэлэлцэх үед талуудаас гаргасан материалуудыг үнэлэх зорилгоор тангарагтны шүүгчид зөвлөлдөх тасалгаа руу явна (зөвлөлдөх танхимд түүний дараа өөрсдийн саналыг илэрхийлэхэд нь зориулж Сенатын гишүүн бүрт 15 минут өгнө), эцэст нь “гэм буруутай”, эсхүл “гэм буруугүйн” аль нэг хэлбэрээр шийдвэр гаргана. Ерөнхийлөгчийг гэм буруутайд тооцоход 67 санал шаардлагатай буюу оролцсон Сенатуудын 2/3-ийн санал хэрэгтэй

Арван нэг дэх шат: Тангарагтны шүүх бүрэн бүрэлдэхүүнээрээ гаргасан шийдвэрээ нээлттэй хуралдаан дээр зарлана.⁹⁷

АНУ-ын түүхэнд 1868 онд Ерөнхийлөгч Andrew Johnson (АНУ-ын 17 дахь Ерөнхийлөгч) ба 1999 онд Ерөнхийлөгч William Seffevson Clinton (АНУ-ын 42 дахь ерөнхийлөгч) нарт тус тус тус импечмент хийж огцруулах асуудал хөндөгдөж байсан.⁹⁸

Жишээ 2: 1993 оны ОХУ-ын Үндсэн хуулийн 92 дугаар зүйлийн 2-т эрүүл мэндийн шалтгааны улмаас болон импечментээр оргцруулж болох талаар тусгасан⁹⁹ бөгөөд ерөнхийлөгч огцорвол засаг захиргааны даргууд бүрэн эрхээ өөрийн санаачилгаар хүлээлгэн өгөх эсхүл ард түмний итгэлийг алдсанаас болж албан тушаалаасаа огцрох ба дахин энэ албан тушаалд сонгогдох эрхгүй болно.¹⁰⁰ ОХУ-ын импечмент нь дараах үе шаттай явагддаг. Үүнд:

Нэг дэх шат: Төрийн думын нийт гишүүдийн гурваны нэгийн санаачлагаар Ерөнхийлөгчийн эсрэг үүссэн үндэслэлүүдийг мөрдөн шалгах тусгай комисс байгуулдаг.

⁹⁷ Кристофер Осаке, Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги бүдүүвч, (УБ, 2005), 107 дахь тал.

⁹⁸ Keith E. Whittington, Bill Clinton was no Andrew Johnson, Comparing two impeachments, *Journal of constitutional law*, Vol.2:2, p.424.

⁹⁹ ОХУ-ын Үндсэн хууль, 92 дугаар зүйл, (1993).

https://www.constituteproject.org/constitution/Russia_2014?lang=en

¹⁰⁰ Т.Азжаргал, Үндсэн хуулийн дэг журам зөрчсөн үйлдэлд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах үндэслэл журам, *Хүний эрх онол арга зүйн сэтгүүл*, №2, (2015), 40 дахь тал.

Хоёр дахь шат: Тусгай комисс Ерөнхийлөгчийн эсрэг дэвшүүлсэн үндэслэлүүдийг мөрдөн шалгаж, улмаар өөрийн дүгнэлтийг Төрийн думд өргөн барина.

Гурав дахь шат: Төрийн думын нийт депутатын гуравны хоёрын саналаар эх орноосоо урвасан буюу бусад хүнд гэмт хэрэг үйлдсэний хувьд ОХУ-ын Ерөнхийлөгчийг буруутгасан үндэслэгээг дэвшүүлэн тавьж байгаа тухай шийдвэр гаргана.

Дөрөв дэх шат: Хэрэв Ерөнхийлөгчийн үйлдэлд гэмт хэргийн шинж байгаа бол ОХУ-ын Дээд шүүх баталгаажуулсан дүгнэлт гаргана.

Тав дахь шат: Ерөнхийлөгчийг буруутгасан үндэслэгээ нь тогтоосон журмыг зөрчөөгүй бол ОХУ-ын Үндсэн хуулийн Шүүх дүгнэлт гаргаж өгнө.

Зургаа дахь шат: Холбооны зөвлөл Импечментийн шүүхийн журмаар хэргийн талаар сонсож, нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар ОХУ-ын Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах эсэх тухай шийдвэр гаргана.¹⁰¹

Жишээ 3: Франц Улсын тухайд,

Нэг дэх шат: Францын Ерөнхийлөгчийг эх орноосоо урвасан гэж үзвэл, түүний эсрэг үндэслэлээ Үндэсний хурлын нийт гишүүдийн дунд илээр хураасан саналын олонхоор батална.

Хоёр дахь шат: Сенат өөрийн гишүүдийн дийлэнх олонхийн ил санал хураалтаар Францын Ерөнхийлөгчийн эсрэг эх орноосоо урвасан хэмээн буруутгасан тухай шийдвэр гаргана. Францын Ерөнхийлөгчийг буруутгасан тухай Сенатын шийдвэр нь Үндэсний хурлын шийдвэртэй адил байна.

Гурав дахь шат: Үндэсний хурал болон Сенатын ижил тооны гишүүдээс бүрэлдсэн шүүн таслах Дээд танхим байгуулагддаг. Тэр нь өөрийн гишүүдээс даргыг сонгоно.

Дөрөв дэх шат: Шүүн таслах Дээд танхим нь Ерөнхийлөгчийн хэргийг дэвшүүлсэн үндэслэлээр хэлэлцэнэ.

Жишээ 4: Холбооны ерөнхийлөгч ХБНГУ-ын төлөөллийн байгууллагуудын өмнө улс төрийн хариуцлага хүлээхгүй бөгөөд өөрийн үйл ажиллагааныхаа талаар Бундестаг болон Холбооны хурлын өмнө тайлан тавихгүй.¹⁰² Гэхдээ ХБНГУ-ын Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь заалтад Бундестаг, эсхүл Бундесратаас Холбооны Ерөнхийлөгчийг энэхүү Үндсэн хууль, бусад Холбооны хууль тогтоомжийг санаатай зөрчсөн хэмээн Бундесратын гишүүдийн дөрөвний нэг санал өгсөн, эсхүл Бундестагийн гишүүдийн доод тал нь дөрөвний нэгийн саналаар эгүүлэн татахыг дэмжсэн тохиолдолд Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хандаж болох бөгөөд Холбооны Үндсэн хуулийн шүүхээс Холбооны Ерөнхийлөгчийг энэхүү Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор санаатайгаар зөрчсөн гэм буруутайг нь тогтоосон бол түүнийг албан тушаалаас нь чөлөөлж болохоор тусгасан байна.¹⁰³ Хариуцлагад татсанаас хойш Холбооны Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсныг түр захирамжаар тогтоож болно.

ХБНГУ-ын өнөөгийн улс төрийн механизмд Холбооны Ерөнхийлөгч үндсэндээ билэгдлийн чанартай үүрэг гүйцэтгэх бөгөөд гагцхүү хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хооронд зөрчил үүссэн тохиолдолд засаглах бодит бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.¹⁰⁴

¹⁰¹ Кристофер Осаке, Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги бүдүүвч, (УБ, 2005), 111 дэх тал.

¹⁰² Ч.Энхбаатар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын төрийн эрх зүй, (УБ, 2009), 109 дэх тал.

¹⁰³ Орч: Christian Tomuschat and David P. Currie, Donald P. Kommers in cooperation with the language service of the German Bundestag, Basic Law for the Federal Republic of Germany, art 61, <https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf>

¹⁰⁴ Ч.Энхбаатар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын төрийн эрх зүй, (УБ, 2009), 111 дэх тал.

Харин Монгол Улсын тухайд Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна.”¹⁰⁵ хэмээн заасан байна. Төрийн тэргүүний хариуцлагын тухай энэхүү заалт нь өмнөх заалттай холбоотой бөгөөд Ерөнхийлөгчид бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нэгэн үндэслэл буюу Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах журмыг заасан юм.¹⁰⁶ Дээрх заалтаас үзвэл ерөнхийлөгчийг тангаргаасаа няцсан буюу Үндсэн хууль ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг хянаж дүгнэлт гаргуулахаар Үндсэн хуулийн цэцэд хандаж өргөдөл, мэдээллийг иргэд, хүсэлтийг УИХ, Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокурор гаргах эрхтэй бөгөөд хүсэлтийг УИХ гаргахын тулд УИХ-ын нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь санал гаргасан нөхцөлд чуулганаараа хэлэлцээд чуулганд оролцсон нийт гишүүдийн ердийн олонхи нь Цэцээр хэлэлцүүлэхээр санал өгсөн бол цэцэд хандана. Улсын Дээд шүүх энэ асуудлыг тавихын тулд нийт гишүүдийн хурлаар хэлэлцэж олонхийн саналаар цэцэд хандана.¹⁰⁷ Улмаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийг Цэцийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Цэц өөрийн санаачилгаар шийдвэрлэх ёстой бол УИХ, Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Улсын Ерөнхий прокуророос ирүүлсэн хүсэлтийг хүлээн аваад шууд цэцийн хуралдаанд оруулан дүгнэлт гаргаж УИХ-д хуульд заасан журмын дагуу өгөх ёстой бөгөөд Цэцээс ерөнхийлөгчийг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзсэн тохиолдолд УИХ-ын чуулганд оролцсон нийт гишүүн буюу доод тал нь 39-н гишүүний дийлэнх олонх дэмжсэн тохиолдолд огцорхоор зохицуулсан байна.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Огцруулах” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг УИХ-ын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь албан ёсоор тавибал Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу УИХ хэлэлцэж Ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ.” хэмээн заасан бол Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” номонд “Эрхэлсэн албан тушаалаас хасагдан гарах: албан тушаалаас огцруулах, албанаас огцруулах”¹⁰⁸ гэсэн бол академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номонд “Монгол улсад өргөн утгаараа төрийн албанаас халагдах буюу төрийн албан тушаал эрхэлж байсан этгээд уг албан тушаалаа орхих. 2. Үндсэн хуулийн эрх зүйд засгийн газар түүний тэргүүн буюу сайдыг огцруулах. Өөрөөр хэлбэл, засгийн газарт итгэл хүлээлгэхгүй байгаагаар илэрхийлсэн буюу засгийн газар дахь дотоодын үл ойлголцох байдал, эрүүл мэндийн байдал, хуулиар тогтоосон насанд хүрсэн зэрэгтэй холбогдуулан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох. Үндсэн хуулиар түүнчлэн төрийн тэргүүн болон бусад зарим албан тушаалтныг огцруулах асуудлыг зохицуулсан байдаг.”¹⁰⁹ гэж тус тус тайлбарласан байна.

Дүгнэвэл, “Огцруулах” хэмээх нэр томьёо нь салаа утгагүй, нэг мөр ойлгогдох агуулгатай бөгөөд төрийн өндөр албан тушаалтанг огцруулах асуудал нь олон улсын жишигт өөр нэр томьёогоор хэрэглэгддэг болох нь харагдаж байна.

¹⁰⁵ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, (1992).

¹⁰⁶ ХБНГУ-н Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2009), 172 дахь тал.

¹⁰⁷ Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2000), 182 дахь тал.

¹⁰⁸ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (УБ, 1966), 408 дахь тал.

¹⁰⁹ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ, 2007), 332 дахь тал.

БҮРЭН ЭРХ

Бүрэн эрх буюу authority гэх нэр томъёо нь Латин хэлний “auctoritas” гэсэн үгнээс гаралтай бөгөөд дээрх нэр томъёог зарим судлаачид англи хэлний “sovereign” гэх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэх нь зөв гэдэг талаар байр сууриа илэрхийлсэн байдаг¹¹⁰.

Ерөнхийлөгчийн институтын хувьд ямар бүрэн эрх эдэлж байгаагаасаа хамааран тухайн засаглалын хэлбэр нь хамаардаг бөгөөд улс орон болгон өөрийн онцлогоос хамааран ерөнхийлөгчийг ялгаатайгаар зохицуулан бүрэн эрхийг нь тодорхойлсон байна. Үндсэн хуульдаа төрийн тэргүүнээ тодорхойлсон ерөнхий зохицуулалтаас холбогдох хэсгийг түүвэрлэн авч үзвэл:

Жишээ 1 (Парламентын хаант засаглал): Испани Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт¹¹¹ “Хаан нь төрийн тэргүүн, бат бөх байдал, эв нэгдлийн бэлгэ тэмдэг байна ...”;

Жишээ 2 (Парламентын эзгүй хаант засаглал¹¹²): “Шинэ Зеландын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд “Шинэ Зеландын эрх баригч нь төрийн тэргүүн бөгөөд хааны хэв маягтай байна”;

Жишээ 3 (Парламентын гүйцэтгэх-бус хаант засаглал): Японы Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд¹¹³ “Эзэн хаан бол төрийн болон ард түмний эв нэгдлийн бэлгэ тэмдэг бөгөөд түүний байр суурь нь халдашгүй дархан байдлыг өөртөө хадгалах ард түмний хүслээс үүснэ.”;

Жишээ 4 (Парламентын бүгд найрамдах засаглал): Итали Улсын Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд¹¹⁴ “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд үндэсний эв нэгдлийг илэрхийлнэ”;

Жишээ 5 (Парламентын бүгд найрамдах засаглал): Иракийн Үндсэн хуулийн 67 дугаар зүйлд¹¹⁵ “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд улсын эв нэгдлийн бэлгэ тэмдэг байж улсын бүрэн эрхт байдлыг илэрхийлнэ ...”;

Жишээ 6 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Португал Улсын Үндсэн хуулийн 120 дугаар зүйлд¹¹⁶ “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Португалийн Бүгд Найрамдах Улсыг төлөөлж, улсын эв нэгдэл, үндэсний тусгаар тогтнол, ардчилсан институцийн зүй ёсны үйл ажиллагааны баталгаа бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна”;

Жишээ 7 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт¹¹⁷ “Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд гадаад харилцаанд улсаа төлөөлнө”, (2) дахь хэсэгт “Ерөнхийлөгч нь Улс болон Үндсэн

¹¹⁰ Энэ талаар Д.Гангабаатар “Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал” номондоо Манайд “sovereignty”-г бүрэн эрхт байдал гэх тул “sovereign” гэдгийг бүрэн эрх гэж ойлгох ёстой боловч “бүрэн эрх” гэдэг хууль зүйн нэр томъёог манайд “authority” хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэж байна.” хэмээжээ.

¹¹¹ Испани Улсын Үндсэн хууль, (1978), https://www.constituteproject.org/constitution/Spain_2011?lang=en

¹¹² Англ. Parliamentary absentee monarchy – Парламентын хаант засаглалтай, бүрэн эрхийг нь Үндсэн хуулиараа зохицуулсан боловч өөр улсын харьяанд байдаг тул дотооддоо хаан, хатан залдаггүй улсыг ийнхүү нэрлэдэг байна. Тухайлбал, Шинэ Зеланд Улс нь хаант засаглалтай боловч шууд удирддаг хаангүй, Их Британи Умард Ирландын Вант Улсын хатан хааны удирдлагад байдаг.

¹¹³ Япон Улсын Үндсэн хууль, Орч. П.Амаржаргал (УБ, 2011), 10 дахь тал.

¹¹⁴ Итали Улсын Үндсэн хууль, (1947), https://www.constituteproject.org/constitution/Italy_2012?lang=en

¹¹⁵ Ирак Улсын Үндсэн хууль, (2005), https://www.constituteproject.org/constitution/Iraq_2005?lang=en

¹¹⁶ Португал Улсын Үндсэн хууль, (1976),

https://www.constituteproject.org/constitution/Portugal_2005?lang=en

¹¹⁷ БНСУ-ын Үндсэн хууль, (1948),

https://www.constituteproject.org/constitution/Republic_of_Korea_1987?lang=en

хуулийн тасралтгүй, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй”;

Жишээ 8 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Литва Улсын Үндсэн хуулийн 77 дугаар зүйлд¹¹⁸ “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Тэрээр Литва Улсаа төлөөлж, Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон бүх үүргийг биелүүлнэ”;

Жишээ 9 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 80 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт¹¹⁹ “Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна”, 2 дахь хэсэгт “Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нь Оросын Холбооны Улсын Үндсэн хууль, хүний болон иргэний эрх, эрх чөлөөний баталгааг хариуцагч байна ...”;

Жишээ 10 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Аргентин Улсын Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд¹²⁰ “Үндэсний гүйцэтгэх эрх мэдэл нь “Аргентин үндэстний Ерөнхийлөгч” хэмээх албан тушаалтай иргэнд хадгалагдана”;

Жишээ 12 ХБНГУ-ын тухайд тус улсын Үндсэн хуульд Холбооны ерөнхийлөгчийн эрх хэмжээ нь үндсэндээ төлөөллийн болон зарим тохиолдолд гүйцэтгэх шинжтэй байдаг. Холбооны Ерөнхийлөгч дотоод бодлогын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Холбооны хуулиудад гарын үсэг зурж, тэдгээрийг хэвлэн нийтлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- Парламентын баталсан хуулийг Тулгуур хууь зөрчсөн үндэслэлээр маргаан үүсгүүлэхээр холбооны Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлнэ.
- Бундестаг дахь улс төрийн хүчний харьцааг харгалзсаны үндсэн дээр холбооны Канцлерын албан тушаалд нэр дэвшигчийг санал болгоно
- Холбооны Канцлерын санал болгосны дагуу холбооны сайдуудыг томилно
- Хуульд өөрөөр заагаагүй бол холбооны Ерөнхийлөгч холбооны шүүгч, иргэний албан хаагч, офицер болон Зэвсэгт хүчний албан тушаалтныг томилох буюу чөлөөлөх эрхүүд эдэлдэг байна.

Монгол Улсын хувьд Ерөнхийлөгчийн бүрэн эрх гэдгийг төрийн тэргүүний хувьд ч, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд ч юу хийх үүрэгтэй, түүнийгээ биелүүлэхдээ ямар эрх боломж эдлэх ёстой вэ гэдэг утгаар авч үзэв.¹²¹ Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг “үндсэн”, “тодорхой” хэмээн ялган үзэх бөгөөд Үндсэн хуульд заасныг нь үндсэн, түүнийг ердийн хуулиар тодруулсан хийгээд нэмж олгосон эрх, үүргийг нь “тодорхой” гэнэ.¹²²

Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1-д заасан 12 заалт¹²³ бөгөөд эдгээрээс дийлэнх олонх буюу нийт 9 бүрэн эрх нь гүйцэтгэх засаглалын хүрээнд хэрэгжиж байна. Үлдсэн бүрэн эрх нь УИХ болон Шүүх эрх мэдэлтэй харилцахтай холбоотой эрх хэмжээ болж байна.¹²⁴ Харин тодорхой бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн

¹¹⁸ Литва Улсын Үндсэн хууль, (1992), https://www.constituteproject.org/constitution/Lithuania_2006?lang=en

¹¹⁹ ОХУ-ын Үндсэн хууль, (1993), https://www.constituteproject.org/constitution/Russia_2014?lang=en

¹²⁰ Аргентин Улсын Үндсэн хууль, (1853), https://www.constituteproject.org/constitution/Argentina_1994?lang=en

¹²¹ Б.Чимид, Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, (УБ, 2008), 148 дахь тал.

¹²² Мөн тэнд.

¹²³ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, (1992)

¹²⁴ Я.Төгөлдөр, “Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн институтын байр суурь эрх мэдлийн хэрэгжилтийн шинжилгээ”, *Монгол Улсын Төрийн байгуулал дахь засаглалын институтын талаарх судалгаа (судалгааны эмхэтгэл)*, (УБ, 2018), 39 дэх тал.

хуулийн 33 дугаар зүйлийн 4-т зааснаар “Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгоно” гэсэн заалтаас үүдэн нийт 40 орчим¹²⁵ салбар хуульд ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрхийг хуульчилж өгсөн байна.

Ерөнхийлөгчийн эдлэх үндсэн бүрэн эрхийг:

- Бэлгэ тэмдгийн шинжтэй чиг үүрэг;
- Хууль тогтоомжтой холбогдох бүрэн эрх;
- Гадаад харилцаанд хамаарах бүрэн эрх;
- Батлан хамгаалахтай холбоотой бүрэн эрх;
- Хууль тогтоогчийг тараах бүрэн эрх;
- Бусад бүрэн эрх¹²⁶ хэмээн тодорхойлж болно. Эдгээр бүрэн эрхийг тус бүрд нь авч үзвэл:

Бэлгэ тэмдгийн шинжтэй чиг үүрэг

Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэсэн нь засаг төр, нийгмийн тогтолцоонд түүний эрх зүйн байдлыг илэрхийлсэн гол тодорхойлолт юм.¹²⁷ Ерөнхийлөгч Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлыг бүхнээс дээгүүр тавьж, шаардлагатай үед нийгмийн бүлэг, хэсэг улс төрийн хүчнүүдийн хооронд зөвшилцөлд хүрэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Энэ ч үүднээс бэлгэ тэмдгийн төдий ухагдахуун биш засаглах эрх мэдлийн бүх салбаруудын тэнцвэрт харилцааг гагнан бэхжүүлж засаглах эрх мэдлийг бодитой биечлэн хэрэгжүүлэгч юм.¹²⁸ Ийнхүү ерөнхийлөгч нь төрийн тэргүүний хувьд төрийн бусад бэлгэ тэмдгээс ч илүү тухайн улсыг төлөөлж, улсын эв нэгдлийн бэлгэ тэмдэг болж байдаг.¹²⁹

Хууль тогтоомжтой холбогдох бүрэн эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт ерөнхийлөгч Улсын Их хурлаас баталсан хуульд бүхэлд нь буюу аль нэг бүлэг зүйл, хэсэгт нэг удаа хориг тавих эрхтэй бөгөөд хууль буюу шийдвэрт тавьсан хоригийг УИХ хүлээн авмагц хэлэлцэх асуудлын ээлж дугаар хүлээхгүй нэн даруй хэлэлцэж, хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ.¹³⁰ УИХ-ын гишүүдийн олонх хоригийг хүлээн аваагүй тохиолдолд хууль батлагдан гардаг.

Гадаад харилцаанд хамаарах бүрэн эрх

Ерөнхийлөгч нь гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, УИХ-тай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах, Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг УИХ-тай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах зэрэг, Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах бүрэн эрхтэй байдаг.¹³¹

Батлан хамгаалахтай холбоотой бүрэн эрх

Ерөнхийлөгч Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг тэргүүлдэг эрхтэйн хувьд нийгмийн болон улсын аюулгүй байдлыг хангах, хууль ёс, дэг журмыг бэхжүүлэх талаар хууль тогтоомжийн заалтын хүрээнд олон зүйл бүрэн эрхтэй.

¹²⁵ Эдгээр тодорхой бүрэн эрхийн талаар тусгасан холбогдох хуулийн зохицуулалтыг хавсралт 4-өөс дэлгэрүүлэн үзнэ үү.

¹²⁶ Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, (УБ, 2012), 174 дэх тал.

¹²⁷ Б.Чимид, Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, (УБ, 2008), 137 дахь тал.

¹²⁸ Г.Совд нар, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2000), 182 дахь тал.

¹²⁹ Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, (УБ, 2012), 175 дахь тал.

¹³⁰ Г.Совд нар, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2000), 168 дахь тал.

¹³¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, (1992).

Хууль тогтоогчийг тараах бүрэн эрх

Ерөнхийлөгч парламентыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл УИХ-ын даргатай зөвшилцсөний үндсэн дээр тараах санал УИХ-д тавьж болно. Үндсэн хуульд “УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно”. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл УИХ бүрэн эрхээ эдэлнэ” гэж заажээ. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор УИХ хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ыг тараах шийдвэр гаргах эрхтэй байгаа нь хууль тогтоогчид гүйцэтгэх засаглалаас тавих томоохон хяналтын хэлбэр мөн.

Бусад бүрэн эрх

Мөн тодорхой салбарт гавьяа байгуулсан, амжилт бүтээлтэй ажилласан хүмүүсийг урамшуулан шагнах, цол, медалиар шагнах, улс, цэргийн дээд цол хүртээх эрхийг Ерөнхийлөгчид олгосон. Мөн уучлал үзүүлэх, Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох гэх мэт бүрэн эрхийг Үндсэн хуульд тусгасан байна.

Бүрэн эрх хэмээх ойлголтыг Б.Чимид “Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь” номондоо “Бүрэн эрх /полномочне-authority/ гэдгийг энгийн ухамсрын түвшинд “эрх” гэж /нэг л их эрхтэй юм шиг/ ойлгох нь байнга ажиглагдана. Гэтэл энэ бол уг эзнийхээ гүйцэтгэх үүрэг, түүнийг биелүүлэхдээ эдлэх эрх боломжийг агуулсан тусгай утга бүхий хууль зүйн нэр томъёо билээ.”¹³² хэмээн тодорхойлсон бол академич С.Нарангэрэл Эрх зүйн эх толь бичиг номондоо “Бүрэн эрх хэмээх үг нь нийтлэг байдлаар нэг этгээдийн (төлөөлүүлэгчийн) нэрийн өмнөөс төлөөлүүлэгчийн эрх ба үүргийг буй болгох, өөрчлөх буюу дуусгавар болгох хэлцэл хийх нөгөө этгээдийн (төлөөлөгчийн) эрх¹³³ хэмээн тус тус тайлбарласан байна.

Дээрхээс үзвэл бүрэн эрх хэмээх нэр томъёо нь үгийн хувьд нэгдсэн нэг ойлголттой байх бөгөөд харин улс орны засаглалын хэлбэр, эрх зүйн тогтолцооноос хамаараад агуулгын хүрээнд бүрэн эрх гэдэгт юуг хамааруулж үзэх нь өөр өөр байна.

ХОРИГ

Англи хэлний “veto” гэх үгийг монгол хэлний хориг хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг байна. Төрийн тэргүүнээс парламентын баталсан хуультай санал нэгдэхгүй байх эрх. Ардчилсан улс орнуудад ветог эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх тогтолцооны тэнцвэржүүлэгч нэн чухал элемент гэж үздэг болой.¹³⁴ гэсэн байх бөгөөд АНУ-ын “Black’s law dictionary”¹³⁵ толь бичигт “би хориглож байна” гэсэн үгнээс гаралтай, засаглалын нэг салаа мөчир нь нөгөөгийнхөө үйл ажиллагааг хориглох эрх мэдэл юм. Үндсэн хуулийн эрх зүйд гүйцэтгэх засаглалын тэргүүн нь хууль тогтоогчийн баталсан хуульд гарын үсэг зурахаас татгалзах гэж хоригийг тодорхойлсон байна. Мөн “Oxford dictionary of law”¹³⁶ толь бичигт “1/Хориг тавих нь олон улсын эрх зүйд тодорхой саналыг аюулгүйн зөвлөлийн аль нэг гишүүн зөвшөөрөхөөс татгалзах эрх мэдлийг хэлнэ. 2/ Европын холбооноос ямар нэг шийдвэрийг

¹³² Б.Чимид, Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь (төслийн багийн судалгааны ажлын тайлан), (УБ, 2005), 22 дахь тал.

¹³³ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW Dictionary, (УБ, 2007), 94 дэх тал.

¹³⁴ С.Нарангэрэл. Хууль зүй судлалын Англи-Монгол тайлбар толь, (УБ, 2005), 516 дахь тал.

¹³⁵ Henry Campbell Black, *Black’s law dictionary*, 4th edition (St.Paul, Minn: 1968, West publishing Co), p.1595.

¹³⁶ Oxford dictionary of law, 6th.ed.(2006) p.564

санал нэгтэйгээр гаргах шаардлагатай хууль тогтоомжийг аль нэг гишүүн улс татгалзах эрх юм. Европын хорооноос санал болгосон хуулийг Европын парламент татгалзах эрх мэдлийг ойлгоно” гэжээ. Хоригийн институц нь эртний Ромд манай эриний өмнө VI зуунд Сенатад давамгайлах патрикануудаас блебуудын ашиг сонирхлыг хамгаалах боломжийг трибунд олгох зорилгоор хэрэглэгддэг байсан “intercessio” хэмээх тогтолцооноос үүсэлтэй юм. Трибуны хориг нь Сенатаас хууль батлахыг болиулахгүй боловч хуулийн хүчин чадлыг сулруулдаг байжээ.¹³⁷

Дэлхийн улс орнуудад Ерөнхийлөгчийн институт нь төрийн тэргүүний эсхүл гүйцэтгэх эрх мэдлийн аль нэгийг хэрэгжүүлдгээс шалтгаалан төрийн засаглалын хэлбэр тодорхойлогддог. Хориг нь Ерөнхийлөгчийн институцээр дамжин хэрэгждэг.

- *АНУ-ын* Ерөнхийлөгчийн эрх мэдэл нь хуулийн төсөл эсхүл тогтоолд хориг тавих болон хуулийг батламжлахаас татгалзах явдал юм. Ерөнхийлөгч арван өдөрт (ням гаригийг оруулахгүйгээр) Конгрессоос гаргасан хуулийн төсөлд гарын үсэг зурж батламжилна. Ерөнхийлөгч хориг тавьсан үед хууль санаачилсан танхимд хориг тавих үндэслэлийг тайлбарлан хууль тогтоомжоо буцаана. Энэ хоригийг зөвхөн танхим дахь Сенатын гуравны хоёрын саналаар өөрчилж болох юм. Хэрэв энэ тохиолдолд хуулийн төсөл нь Ерөнхийлөгчийн эсэргүүцлийг давж хууль болж гардаг байна. Конгресс арван өдрийн турш түр хугацаагаар хойшлуулснаар халаасны хориг тавьдаг. Ерөнхийлөгч Конгрессод хуулийн төслийг буцаахгүй. Ерөнхийлөгчийн гарын үсэг зурахгүй байх шийдвэр нь халаасны хориг байх тул үүнийг Конгресс давж заалдах боломжгүй байна.

Үндсэн хуульд Ерөнхийлөгч 10 хоногийн дотор Конгрессоор батламжлах арга хэмжээг авна. Ерөнхийлөгч 10 хоногийн дараа хуулийн төсөлд гарын үсэг зураагүй бол түүний гарын үсэггүй болж байх тул Конгресс 10 өдрийн туршид хойшлуулсан ч хуулийн төсөл хууль болдоггүй байна.¹³⁸ АНУ-ын Ерөнхийлөгчид 1789 оноос эхлэн хуулийн төсөлд хориг тавьсан байх бөгөөд Жорж Вашингтон 4 хуульд хориг тавьснаар эхэлж байсан бол хамгийн сүүлд Доналд Трамп 116 хуулийн төсөлд хориг тавьжээ.¹³⁹

- *Их Британи* Улсад 1265 онд парламент бий болж түүний баталсан хууль тогтоомжийг хаан батламжилж гарын үсэг зурснаар сая хүчин төгөлдөр үйлчлэх болсон. Английн хатан хаан Анна 1708 онд хориг тавих эрхээ хэрэгжүүлснээс хойш 1999 оныг хүртэлх хугацаанд парламентийн үйл ажиллагаанд хориг тавих эрх хэрэгжээгүй байна.¹⁴⁰ Хатан хаан II Элизабета Их Британийн парламентийн баталсан “Их Британийн зэвсэгт хүчнийг Ираны эсрэг явуулах цэргийн ажиллагаанд АНУ-ын талд оролцуулах тухай” хуульд Засгийн газрын санал болгосноор хориг тавьсан байна.

- *Франц Улсын* Үндсэн хуульд ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр хууль тогтоомжийг нийтлэх бөгөөд Үндсэн хуульд зааснаар парламентаас батлан ирүүлсэн хууль тогтоомжийн төслийг төрийн тэргүүн хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор бүхэлд нь эсхүл тодорхой зүйл, заалтыг дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй. Энэ хугацааг хэтрүүлсэн болон дахин хэлэлцээд ирүүлсэн төслийг ерөнхийлөгч татгалзах эрхгүй батламжлах ёстой ажээ.

¹³⁷ П.Амаржаргал, Парламентын хууль тогтоох бүрэн эрх ба Ерөнхийлөгчийн хориг, *Хууль дээдлэх ёс*, №2, (2014), 63 дахь тал.

¹³⁸ Pocket veto https://www.senate.gov/reference/glossary_term/pocket_veto.htm (сүүлд үзсэн: 2019.05.13)

¹³⁹ Summary of Bills Vetoed, 1789-present

<https://www.senate.gov/reference/Legislation/Vetoes/vetoCounts.html> (сүүлд үзсэн 2019.05.13)

¹⁴⁰ Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (УБ, 2018), 35 дахь тал

- Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Үндсэн хуульд¹⁴¹ заасан журмын дагуу батлагдсан хууль тогтоомжийг баталгаажуулах, гарын үсэг зурагдсаны дараа Холбооны ерөнхийлөгч батламжилж, Холбооны хууль тогтоомжийн эмхэтгэлд нийтлэх тухай заасан. Харин хориг тавих тухай тусгайлсан заалт тусгаагүй байна.

- Япон Улс Үндсэн хуульдаа хааны эрхийг бүрэн хязгаарласан байх бөгөөд хориг тавих эрх мөн давхар хязгаарлагддаг байна.¹⁴² Тус хуульд хориг тавих тухай тусгайлсан заалт тусгаагүй. Харин Төлөөлөгчийн танхим болон Зөвлөхүүдийн танхим хуулийн төслийг хэлэлцэн батлах бөгөөд төслийг нэг танхим 5 өдрийн дотор багтаан хэлэлцэж, нөгөө танхимдаа өгдөг. Ингэхдээ хоёр танхим голлох үүргийг гүйцэтгэдэг. Төлөөлөгчийн танхимын баталсан хууль тогтоомжийн төслийг зөвлөхүүдийн танхим батлахаас татгалзсан тохиолдолд төлөөлөгчийн танхим төслийг хоёр дахь удаагаа авч хэлэлцэн гишүүдийн гуравны хоёр нь хоригийг хүлээн авахаас татгалзаж төслийг урьдын хэвээр баталсан тохиолдолд төсөл хүчин төгөлдөр хууль болох эрхийн зохицуулалтыг тусгасан.

Ерөнхийлөгч хэмээх нэр томъёо үүссэн цагаас “Ерөнхийлөгчийн хориг” хэмээх ойлголт бий болсон. Тухайлбал, Монгол Улсад төрийн эрх мэдлийг хуваарилах талаар 1921 оны дүрэмд дурдаж байсан бөгөөд 1988 оны МАХН-ын Төв хорооны V бүгд хуралд дэвшүүлж байсан нь 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр “БНМАУ-ын Төрийн дээд байгууллагын бүтцийн тухай тогтоол”-ыг батлан гаргасантай нийцүүлэн Үндсэн хууль дахь нэг намын дангаар ноёрхлыг бэхжүүлсэн заалтыг халж, улс төрийн олон ургалч ёс, иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийг АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн 9 дүгээр чуулганаар хэлэлцүүлснийг 1990 оны 5 дугаар сарын 12-ны өдөр “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг баталсан”¹⁴³-аар Ерөнхийлөгчийн бүрэн эрх баталгаажин хэрэгжиж эхэлсэн байна. Энэ хуульд Ерөнхийлөгчийн хориг тавих, гарын үсэг зурж батламжлах тухай зааж өгсөн. Улмаар 1991 онд Ерөнхийлөгчийн тухай хуулийг батлан гаргаснаар Ерөнхийлөгчийн бүрэн баталгаажин АИХ, Бага хурлын шийдвэрт хориг тавих эрх хэмээн хуульчилсан. 1990-1992 онд Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар нь 30 гаруй хуулийг батлан гаргаж, үндсэн хуулийн эрх зүйн урьдач нөхцөлийг бүрдүүлсэн. Ерөнхийлөгч энэ хугацаанд 7 удаа хориг тавьсан байна.

Ийнхүү 1991 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхэлсэн АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2 дугаар хуралдаан нийт 76 хоног хуралдаж, 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр МУ-ын шинэ Үндсэн хуулиа баталсан. Ийнхүү Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1-д “УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ” хэмээн хуульчилсан. УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь нь буюу хэсэгчлэн хориг тавих эрхтэй байхаар зохицуулсан хэдий ч Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд заасан “баталсан хуулийг гарын үсэг зурж батламжлах” эрхийг шинэ хуулиар Ерөнхийлөгчид олгоогүй байна.

1992 оны Үндсэн хуулийн Хавсралт хуульд Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг ...1993 онд багтаан батлан гаргах ажлын хүрээнд 1992 оны 4 дүгээр сарын 4-нд Монгол Улсын Их Хурлын тухай, 1993 оны 6 дугаар сарын 5-нд Ерөнхийлөгчийн тухай хуулийг

¹⁴¹ Grundgesetz für die Bundesrepublik Deutschland <https://www.gesetze-im-internet.de/gg/BJNR000010949/.html> (сүүлд үзсэн 2019.05.13)

¹⁴² The Constitution of Japan https://japan.kantei.go.jp/constitution_and_government_of_japan/constitution_e.html (сүүлд үзсэн 2019.05.13)

¹⁴³ Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (УБ, 2018), 65 дахь тал.

батлан гаргасан. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 7-д “Хууль санаачлагчаас УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар саналаа илэрхийлж болно. Энэ нь уул хуульд хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад болохгүй.”, 8-д “УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина.” гэснийг өнөөг хүртэл хэвээр хадгалсан байна.

Харин Монгол Улсын Их Хурлын тухай хууль 1997 онд шинэчилсэн найруулгыг хийж, мөн онд Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийг батлан гаргасан.

Монгол Улсын Их Хурлынхуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн хоригийг хянан хэлэлцэх талаар заасан байх бөгөөд 6 хэсэг агуулгатайгаар оруулсан байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн үндэслэлийг Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч УИХ-д танилцуулна.

2. Ерөнхийлөгчийн хоригийн талаар тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг сонсоно. Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонссоны дараа асуулт, хариулт явуулж, гишүүд санал гаргаж болно. Ийнхүү санал, дүгнэлт гаргаж дууссаны дараа Ерөнхийлөгч тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсныг үндэслэн уг хоригийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар санал хураалт явуулна. Хэрэв Ерөнхийлөгч хууль, УИХ-ын бусад шийдвэрийн зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явуулна.

3. УИХ Ерөнхийлөгчийн хоригийн талаар тогтоол гаргана.

4. УИХ хоригийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэж батална.

5. Тухайн хууль, бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Ерөнхийлөгчийн хориг тавьсан хугацаатай давхацвал хоригийг хэрхэх тухай асуудлыг УИХ хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, бусад шийдвэр бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно.

6. Хориг тавьсан асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг уг шийдвэрийг баталснаас хойш 72 цагийн дотор Ерөнхийлөгчид илгээх талаар заажээ.

Харин 40 дүгээр зүйлд Ерөнхийлөгчийн хориг болон бусад Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлахаас бусад асуудлаар чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ороогүй төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр тухайн чуулганы явцад өргөн мэдүүлбэл Төрийн байгуулалтын байнгын хороо, зохих Байнгын хорооны санал, дүгнэлтийг харгалзан түүнийг чуулганаар хэлэлцэх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэх тухай заасан.

Хуулийн 44 дүгээр зүйлд “Улсын Их Хурал өөр хугацаа тогтоогоогүй бол шийдвэрийг ёсчилж илгээснээс хойш Ерөнхийлөгч ажлын 5 өдөрт багтаан тухайн хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсан бол түүнийг хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжинд хэлэлцэж чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол УИХ-ын тухайн шийдвэр хэвээр үлдэнэ, Ерөнхийлөгч УИХ-ын чуулган ажлаа дууссаны дараа УИХ-ын шийдвэрт хориг тавьсан бол УИХ ээлжит бус чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж болно. Ерөнхийлөгчийн хоригийг УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол дараагийн ээлжит чуулганаар эхний ээлжинд, улс

оронд онцгой нөхцөл байдал бий болсон, эсхүл УИХ-ын чуулганы ажиллагаа өндөрлөх гэж байгааг харгалзан Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг УИХ тогтоон өгч болох тухай, УИХ-ын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.” гэж заасан байна.

Анх удаа 1997 онд батлагдаж байсан Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль нь 2001 болон 2007 онд шинэчлэн найруулагдсан ба холбогдох заалтад 2018 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

2007 онд шинэчлэн найруулагдсан хуулийн 31, 53 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн хоригийн талаар заасан. Үүнд, Хууль, УИХ-ын бусад шийдвэрт Ерөнхийлөгч хориг тавьсан бол УИХ түүнийг чуулганы үеэр 14 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хориг тавьсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 10 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж тогтоол батлах тухай заасан. Мөн гишүүд энэ хуульд заасны дагуу үг хэлсний дараа Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэх асуудлаар ил санал хураалт явуулах бөгөөд хэрэв хууль, УИХ-ын бусад шийдвэрийн зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явуулж дүнг танилцуулах талаар заасан. Энэхүү заалтад 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан байна.

Тус хуульд байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр буюу 66.6 хувь нь хоригийг хүлээж аваагүй бол хууль, УИХ-ын бусад шийдвэр хүчин төгөлдөр үлдэх талаар, Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан бол хууль, УИХ-ын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй болгох, шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэн баталж болох тухай, Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан хууль, УИХ-ын бусад шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах бол холбогдох шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй байх талаарх зохицуулалтыг тусгасан. Мөн хуулийн 53 дугаар зүйлд хууль, УИХ-ын бусад шийдвэрийг Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Ерөнхийлөгч тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэх тухай, ийнхүү хориг тавьсан бол УИХ түүнийг хүлээж авснаас хойш дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжинд, тэгэхдээ ажлын 14 өдрийн дотор нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд түүнд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хоригийг хүлээн аваагүй бол тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөх тухай заажээ.

Улсын Их Хурлаас 2010 оны 12 дугаар сард Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг батлан гаргасан. Тус хуулийн 16.2-т “Ерөнхийлөгч Улсын Их Хурлаас Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах уг эхийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын долоо өдрийн дотор хянан үзэж хэрэв уг хууль бүхэлдээ буюу түүний аль нэг зүйл хэсэг, заалт, нэр томъёоны агуулга нь Үндсэн хуульд харшилсан гэж үзвэл Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар хориг тавьж болно.” гэж хуульчлан тодорхойлж өгсөн байна.

Ийнхүү 1990 оноос хойш 29 жилийн хугацаанд Үндсэн хуулийн “Ерөнхийлөгчийн хориг” тавих заалтад өөрчлөлт оруулаагүй хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлынтухай хууль, мөн Монгол Улсын Их Хурлынхуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтууд шинэчлэгдэж байсан төдийгүй сүүлд 2018 онд нэмэлт, өөрчлөлт орж байжээ.

Дээрх хуулийн заалтаас үзвэл Ерөнхийлөгчийн хориг нь түүний бүрэн эрх төдийгүй парламентийн үйл ажиллагааны харилцан хяналтын шинжтэй чиг үүргийг хэрэгжүүлдэг байна.

Энэ нь Ерөнхийлөгчийн бүрэн эрх /хориг тавих/ байх бөгөөд УИХ-ын хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох, парламенттай харилцах харилцааны хэлбэр төдийгүй ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн хуулийг батлан гаргах боломж юм.

Энэ талаар манай нэрт эрдэмтэн судлаачид¹⁴⁴ хэрхэн үзсэнийг тоймлон үзвэл, профессор Б.Чимид “Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуульд хориг тавих бүрэн эрх нь үзэмжийн хэрэг бус (1) Ард түмний язгуур ашиг сонирхолд харш, (2) Үндсэн хуулийн үзэл баримтлалд үл нийцсэн хуулийн заалтуудыг урдуураа зүгээр өнгөрүүлэх эрх төрийн тэргүүнд байх ёсгүй.” гэж тодорхойлсон бол профессор Г.Совд “хориг тавих эрх нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд эдлэх нэгэн зүйл үндсэн бүрэн эрх, УИХ-аас батлан гаргаж байгаа хууль болон бусад шийдвэрийг хүчин төгөлдөр болохын өмнө Улсын Ерөнхийлөгч үзээд хэрэв тэр хууль буюу бусад шийдвэрийг (1) Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан, (2) Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, (3) бусад эрх ашигт нийцэхгүй гэж үзвэл түүнийг бүхэлд нь буюу зарим заалтыг хүчингүй болгуулахаар хориг тавьж УИХ-д буцаах эрхтэй” гэж 3 үндэслэлийг тодорхойлсон бол Монгол Улсын анхны Ерөнхийлөгч асан П.Очирбат “Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр” номондоо “Ерөнхийлөгчийн хориг нь УИХ-ын шийдвэрт ямар нэг хэмжээгээр үл итгэсэн байдлын илэрхийлэл биш, хуулийг аль болох алдаа мадаггүй гаргах эцсийн анхааруулга, дахин бодох, дутуугаа гүйцээх, буруугаа зөвтгөх, цаг үеэ олох боломж олгох төрийн бодлогын нэгдмэл чанарыг илэрхийлэхэд ач тустай арга зам мөн.”¹⁴⁵, Д.Солонго хоригийг төрийн тэргүүнээс парламентийн баталсан хуулийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлэх эрх, Ардчилсан улс орнуудад вето нь эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх, тэнцвэржүүлэх ач холбогдол бүхий чухал хэрэглүүрт тооцогддог хэмээгээд (1) хууль, Үндсэн хуульд зөрчилдөх, (2) төгс боловсруулалт хийгдээгүй, (3) бусад хуультай үл авцалдах, (4) холбогдох харилцааг зохицуулах үндэслэл муу, (5) хууль хэрэгжүүлэх материаллаг болон зохион байгуулалтын нөхцөл хангагдаагүй, (6) парламент хууль хэлэлцэх, батлах тогтсон журам үл баримталсан зэрэг тохиолдол гэж тодорхойлсон байна.

“Ерөнхийлөгч” хэмээх төрийн тэргүүний тухай ойлголт бий болсон цагаас эхлэн Монгол Улсад Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүний хугацаа, тавьсан хоригийн тоог¹⁴⁶ дараах байдлаар хүснэгтээр харуулбал:

Д/д	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр	Бүрэн эрхийн хугацаа	Бүхэлд нь хориг тавьсан	Хэсэгчлэн хориг тавьсан	Хүлээн авсан эсэх		Нийт
					Тийм	Үгүй	
1.	Пунсалмаагийн Очирбат	1990-1992	2	5	3	4	7
2.	Пунсалмаагийн Очирбат	1993-1997	21	2	11	10	23
3.	Нацагийн Багабанди	1997-2001	6	11	12	5	17

¹⁴⁴ Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (УБ, 2018), 88 дахь тал.

¹⁴⁵ П.Очирбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр, (УБ, 2001), 27 дахь тал.

¹⁴⁶ П.Амаржаргал. “УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаан дахь Ерөнхийлөгчийн оролцоо, хууль тогтоомжид тавих хориг” Үндсэн хуульд ёс ба Ерөнхийлөгчийн бүрэн эрх сэдэвт олон улсын онол-практикийн бага хурал. (УБ, 2015), 113 дахь тал.

4.	Нацагийн Багабанди	2001-2005	4	11	7	5	15
5.	Намбарын Энхбаяр	2005-2009	3	6	7	2	9
6.	Цахиагийн Элбэгдорж	2009-2013	2	3	4	1	5
7.	Цахиагийн Элбэгдорж	2013-2017	4	-	3	1	4
8.	Халтмаагийн Баттулга	2017-одоог	4	-	1	3	4

Нийт хоригийн 2/3-г хүлээн зөвшөөрч, үлдэх хэсэг буюу 1/3-г хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн тогтоол гаргасан байна.¹⁴⁷

Дээрх хугацаа болон хориг тавьсан үндэслэл шалтгааныг 3 болон түүнээс дээш удаа давтагдсан гэх шалгуураар бүлэглэн авч үзсэн¹⁴⁸-ийг дурдвал,

- Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, зүйл заалтад нийцээгүй;
- Үндэсний аюулгүй байдал, төрийн бодлого, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой зөрчилдсөн;
- Ёс суртахуун нийтийн эрх ашигт нийцэхгүй;
- Төсвийн зарлагыг үндэслэлгүй нэмэгдүүлсэн, хэт үрэлгэн;
- Бодит амьдралд хэрэгжих үндэслэл муутай, судлаачдын саналыг аваагүй, хүн амын амьжиргаанд сөргөөр нөлөөлөхүйц;
- Түүхэн уламжлал, олон улсын жишигт нийцэхгүй;
- Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийг хязгаарласан;
- Үг найруулга, хууль зүйн техник, хууль тогтоох процесс ажиллагаа зөрчигдсэн гэх үндэслэлээр голлон дурдагджээ.

Энэхүү хориг тавих үндэслэл, шалгуур нь хэт ерөнхий, судалгаанд суурилсан байж чадахгүй байгааг Хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулан судалгаа үндэслэлтэй, хариуцлагатай ил тод байлгах нь эрх мэдлийн хяналт тэнцлийг хангах, ард иргэдийн эрх ашгийг хамгаалах чухал ач холбогдолтой.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Хориг” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол хэлний их тайлбар тольд “1/ хориул, хорио; саад хориг; хориг тавих; 2/ хүний муу буруу, өө сэв буюу бусдад муу санасан атгаг; муугий нь гаргаж, хоригий нь уудлах; 3/ хүн амьтны эрх эмзэг газар; толгойдоо хориг морь гэж тайлбарласан байна.”¹⁴⁹ гэсэн бол академич Ж.Амарсанаа нар “Хууль зүйн тайлбар толь бичиг” номондоо “Орчин үед төрийн ямар нэгэн байгууллагын гаргаж байгаа актын үйлчилгээг түр буюу бүрмөсөн зогсоохыг ойлгодог. Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд парламентаас гаргаж байгаа актын үйлчилгээг зогсоохоор төрийн тэргүүнээс бүрэн эрхийн дагуу тавьдаг актыг хориг гэдэг.”¹⁵⁰ хэмээн тайлбарласан байна. Мөн академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн тайлбар толь бичиг” номонд “Ямар нэгэн байгууллагын шийдвэрийн үйлчлэлийг түдгэлзүүлэх буюу зогсоох акт. Ялангуяа парламентаас баталсан хуульд төрийн тэргүүнд хориг тавих эрх олгосон нь онцгой чухал ач холбогдолтой. Хоригийг

¹⁴⁷ П.Амаржаргал, Парламентын хууль тогтоох бүрэн эрх ба Ерөнхийлөгчийн хориг, *Хууль дээдлэх ёс*, №2, (2014), 68 дахь тал

¹⁴⁸ Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (УБ, 2018), 93 дахь тал

¹⁴⁹ Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/dictionary/detail/110788> (сүүлд үзсэн 2019.05.09)

¹⁵⁰ Ж.Амарсанаа нар. Хууль зүйн тайлбар толь бичиг. Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Хүний эрхийн боловсрол төв, (УБ., 2003). 296 дахь тал

туйлын ба харьцангуй гэж ангилна. Туйлын хоригийн нөхцөлд парламентаас баталсан хууль тогтоомжийн үйлчлэлийг бүрэн зогсоох эрх хадгалагдана. Харьцангуй хоригийн үед төрийн тэргүүн зөвхөн хуулийн үйлчлэлийг түдгэлзүүлэх бүрэн эрхтэй байх бөгөөд парламентад түүнийг хоёр дахь санал хураалтаар батлах эсэх эрх байна. Ийнхүү хуулийн төслийг хэд хэдэн парламентад хоёр дахь удаа (эцэслэн) батлахад дийлэнх олонхийн санал (жишээ нь ОХУ, АНУ-д танхим бүрийн гишүүдийн 2/3-ын санал) шаарддаг. Тэрчлэн ерөнхий буюу хэсэгчилсэн хориг хэмээн ангилна. Эхнийхэд нь хуульд бүхэлд нь, харин хоёр дахь тохиолдолд зарим зүйл буюу хэсэгт хориг тавигдана.”¹⁵¹. Г.Совд нарын “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” номонд “хууль цаазын практикт хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль болон бусад шийдвэрийн үйлчилгээг саатуулах буюу зогсоох талаар төрийн тэргүүний эдлэх үндсэн бүрэн эрхийг илэрхийлэн дэлхий нийтээр хэрэглэж хэвшсэн Үндсэн хуульд ёсны ойлголтыг Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Ерөнхийлөгчөөс хууль тогтоомжид хориг тавих эрх гэж томъёолсон. Хуульд хориг тавих эрхийг хуулиар олгосон хүчин чадлын байдлаар нь туйлын /хязгааргүй/, харьцангуй /саатуулах/ гэж хоёр ангилдаг. Хориг тавих туйлын эрх эдэлсэн тохиолдолд төрийн тэргүүнээс хориг тавьсан хууль хүчин төгөлдөр болдоггүй, бүрмөсөн зогсдог бол хориг тавих харьцангуй эрх эдэлдэг төрийн тэргүүний хориг тавьсан хуулийг хууль тогтоогч дахин хэлэлцэж, хүчин төгөлдөр болж үйлчлэх эсэхийг шийдвэрлэдэг онцлогтой”¹⁵² зэргээр агуулга талаас нь дэлгэрэнгүй тайлбарласан байна.

Дүгнэвэл, олон улсын эрх зүйд VETO буюу хориг тавих эрх нь тодорхой саналыг аюулгүйн зөвлөлийн аль нэг гишүүн зөвшөөрөхөөс татгалзах эрх мэдлийг ойлгох тухай илэрхийлсэн бол Ардчилсан улс орнуудад ветог эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх тогтолцооны тэнцвэржүүлэгч нэн чухал элемент гэж үзжээ.

Харин Монгол Улсад хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль болон бусад шийдвэрийн үйлчилгээг саатуулах буюу зогсоох талаар төрийн тэргүүний эдлэх үндсэн бүрэн эрхийг илэрхийлэн дэлхий нийтээр хэрэглэж хэвшсэн Үндсэн хуульд ёсны ойлголтыг Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Ерөнхийлөгчөөс хууль тогтоомжид хориг тавих эрх хэмээн тайлбарласан бол Ерөнхийлөгч хэмээх нэр томъёо үүссэн цагаас “Ерөнхийлөгчийн хориг” хэмээх ойлголт бий болсон байна.

Үндсэн хууль дахь нэг намын дангаар ноёрхлыг бэхжүүлсэн заалтыг халж, улс төрийн олон ургалч ёс, иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийг 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр “БНМАУ-ын Төрийн дээд байгууллагын бүтцийн тухай тогтоол”-ыг батлан гаргасанаар Ерөнхийлөгчийн бүрэн эрх баталгаажих эхлэл тавигдсан төдийгүй Ерөнхийлөгчийн тухай хуулийг батлан АИХ, Бага хурлын шийдвэрт хориг тавих эрх баталгаажиж, 1990-1992 оны хугацаанд УИХ нь 30 гаруй хуулийг батлан гаргасанд 7 удаа хориг тавьсан байдаг.

Ийнхүү 1990 оноос хойш 29 жилийн хугацаанд Үндсэн хуулийн “Ерөнхийлөгчийн хориг” тавих заалтад өөрчлөлт оруулаагүй хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлынтухай хууль, мөн Монгол Улсын Их Хурлынхуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтуудаар зохицуулж тэдгээрт тухайн цаг үеийн шаардлагаар өөрчлөлт, шинэчлэлт хийж байсан төдийгүй сүүлд 2018 онд шинэчлэгдэж, нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Ерөнхийлөгчийн хориг нь түүний бүрэн эрх төдийгүй парламентийн үйл ажиллагааны харилцан хяналтын шинжтэй чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд Ерөнхийлөгчийн бүрэн эрх /хориг

¹⁵¹ С.Нарангэрэл. Эрх зүйн тайлбар толь бичиг, (Уб, 2007), 516 дахь тал.

¹⁵² Г.Совд нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. (Уб, 2000), 166 дахь тал.

тавих/ байх бөгөөд УИХ-ын хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох, парламенттай харилцах харилцааны хэлбэр, ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн хуулийг батлан гаргах боломж, хариуцлагатай ил тод, эрх мэдлийн хяналт тэнцлийг хангах, ард иргэдийн эрх ашгийг хамгаалах чухал ач холбогдолтой байна.

ЗӨВШИЛЦӨХ

Зөвшилцөх гэх нэр томъёог англи хэлний “consensus”,¹⁵³ орос хэлний “согласование консенсус”, герман хэлний “konses;”¹⁵⁴ хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд латин хэлний “consensus” гэх үгнээс гаралтай.¹⁵⁵ БНСУ-ын Хууль тогтоомжийн судалгааны хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хамтран гаргасан Англи-Солонгос-Монгол-Орос-Герман хууль зүйн толь бичигт “accord” гэсэн үгийг зөвшилцөл, хэлэлцээр гэж орчуулан буулгасан бол Виктор Кондэ “consensus” гэсэн үгийг нь зохион байгуулалттай санал хураах хэмээн орчуулан буулгасан бөгөөд “...Санал хураалтад хэлэлцэгч талууд буюу гишүүд татгалзсан санал гаргахгүйгээр шийдвэрт хүрэх процессыг хэлнэ. Энэ нь дийлэнх буюу гуравны хоёроор шийдвэр гаргахаас ялгаатай. Санал нэгтгэйгээр буюу эсрэг саналгүйгээр шийдэлд хүрнэ гэсэнтэй ойролцоо утгатай.”¹⁵⁶ гэжээ.

Эрх зүйн бүлийн хувьд ижил ХБНГУ-ын Үндсэн хуульд 9-н заалтад¹⁵⁷ зөвшилцөх асуудлыг тусгаж өгсөн байна. Тодруулбал: ХБНГУ-ын Үндсэн хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэв Муж нь энэхүү Үндсэн хууль, Холбооны бусад хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Бундесраттай зөвшилцсөний үндсэн дээр Холбооны Засгийн газраас тухайн Мужийг албадан үүргээ биелүүлэхийг шаардаж болно.”, 85 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Холбооны Засгийн газраас Бундесраттай зөвшилцөн захиргааны ерөнхий хэм хэмжээ баталж болно. Төрийн албан хаагч болон бусад нийтийн цалинтай ажилтны сургалтыг нэгдсэн журмаар зохицуулна. Түүний зөвшөөрснөөр дунд шатны байгууллагыг удирдах эрх бүхий этгээдийг томилно.”, 91б дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Холбоо болон Муж нь хамтын зөвшилцлийн үндсэн дээр боловсролын тогтолцооны үр дүнтэй байдлыг олон улсын жишигтэй харьцуулан үнэлэх, мөн холбогдох тайлан болон зөвлөмж боловсруулахад хамтран ажиллаж болно.”, 108 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Холбооны санхүүгийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллага нь 2009 оны долдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Холбооны хуулиар зохицуулагддаг гаалийн албан татвар, санхүүгийн монополь, онцгой албан татвар, мөн импортын гүйлгээний албан татвар, авто тээврийн хэрэгсэл, түүнтэй холбогдох бусад албан татварыг, түүнчлэн Европын хамтын нийгэмлэгийн хүрээнд төлөх хураамжийг хариуцна. Эдгээр байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг Холбооны хуулиар зохицуулна. Ийнхүү дунд шатны эрх бүхий байгууллагыг байгуулан, удирдлагыг Мужийн Засгийн газартай зөвшилцөн томилно.” мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Холбооны санхүүгийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллага нь 2009 оны долдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Холбооны хуулиар зохицуулагддаг гаалийн албан татвар, санхүүгийн монополь, онцгой албан татвар, мөн импортын гүйлгээний албан татвар, авто тээврийн хэрэгсэл, түүнтэй холбогдох бусад албан татварыг, түүнчлэн Европын хамтын

¹⁵³ Англи- Солонгос- Монгол- Орос- Герман – Хууль зүйн толь, №1642, (УБ, 2011), 184 дэх тал.

¹⁵⁴ Ж. Амарсанаа, Англи-орос-герман-монгол Олон улсын эрх зүйн толь, (УБ, 2004), 194 дэх тал.

¹⁵⁵ П.Цагаан, Хууль зүйн Латин, англи, орос монгол толь, (УБ, 2013), 61 дэх тал.

¹⁵⁶ Х.Виктор Кондэ, Хүний эрхийн олон улсын нэр томъёоны гарын авлага, НҮБХХ, (УБ, 2002), 29 дэх тал.

¹⁵⁷ ХБНГУ-ын 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 85 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 91б дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 108 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 115и дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 115й дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 129 дүгээр зүйлийн 1 дэх хэсгүүдэд тус тус зохицуулсан байна.

нийгэмлэгийн хүрээнд төлөх хураамжийг хариуцна. Эдгээр байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг Холбооны хуулиар зохицуулна. Ийнхүү дунд шатны эрх бүхий байгууллагыг байгуулан, удирдлагыг Мужийн Засгийн газартай зөвшилцөн томилно.”¹⁵⁸ гэх зэргээр зохицуулж өгсөн байна.

Монгол Улсын түүхэнд зөвшилцөх асуудлыг хэрэглэж ирсэн тухай баримт нь Монголын нууц товчоо юм. Энэхүү түүхийн эх сурвалжаас үзэхэд Монголын төр нь хэлбэрийн хувьд хэмжээгүй эрхт хаант засгийн төрхтэй боловч мөн чанараараа ардчиллын олон бүрдлийг өөртөө агуулсан, тун өвөрмөц шинж бүхий төр байв. Төр улсын тулгамдсан асуудалд ончтой хариу эрэлхийлж, нягтлан магадласаны үндсэн дээр их хаанд зөвлөх эрх бүхий байгууллага бол [Их Хуралдай](#) байжээ. Их Хуралдай нь төрийн дээд байгууллагын шинжийг агуулж байсан. Монголын нэгдсэн тулгар төр, улсын эрх ашгийн үүднээс хэн нэгэнтэй дайн зарлах, байлдаан явуулах, өөрийн залгамжлагчийг сонгох, төр улсын тулгамдсан асуудлын гарц, шийдлийг зөвшилцлийн аргаар шийдвэрлэдэг байжээ.¹⁵⁹

Ийнхүү Монголын төрд зөвшилцөх улс төрийн соёл хэвшин тогтсон уламжлалыг Дөчин дөрвөн хоёрын их цааз бичгээс харж болно. Тухайлбал, Манжийн эзлэн түрэмгийллийн эсрэг бүх нийтээрээ тэмцэх, буддын шашны шарын урсгалыг улсын шашин болгож түүний дэмжлэгээр Монгол овогтныг нэгтгэх, том ноёдын зөрчил сөргөлдөөнийг зогсоож хүчээ төвлөрүүлэх зэрэг асуудлуудыг зөвшилцөн хэлэлцэж шийдвэрлэжээ.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийг батлах явц нэлээд онцлог бөгөөд нийтийн зөвшилцлийн үзэл санааны дагуу явагдсан гэж үздэг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийг батлах үйл явц нь бүхэлдээ нийгмийг хамарсан зөвшилцлийн үр дүн болсон. Түүний төслийг ард нийтээр хэлэлцсэн, түүний баталсан АИХ-ын депутатууд Монгол Улсын засаг захиргааны анхан шатны нэгж болсон сумуудыг нийтэд нь төлөөлсөн, Их Хурлын хуралдааны үеэр улс төрийн намууд ажиллаж байсан зэрэг нь бүтцийн талаасаа зөвшилцөл хангагдсан гэсэн үг юм.¹⁶⁰

Монгол Улсын Үндсэн хуулийн зургаан зүйлд¹⁶¹ зөвшилцөх асуудлыг тусгаж өгсөн байна. Тухайлбал, Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл УИХ бүрэн эрхээ эдэлнэ.”, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “УИХ-д олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор УИХ-д оруулах;” гэх зэргээр хуульчлан оруулсан.

¹⁵⁸ Орч: Christian Tomuschat and David P. Currie, Donald P. Kommers in cooperation with the language service of the German Bundestag, Basic Law for the Federal Republic of Germany, <https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf>

¹⁵⁹ Т.Ганхуяг, Зөвшилцөл, (УБ, 2003).

¹⁶⁰ Мөн тэнд.

¹⁶¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4, 5 дахь заалт, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгүүдэд тус тус зөвшилцөж шийдвэр гаргах талаар зохицуулж өгсөн.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Зөвшилцөх” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол хэлний их тайлбар тольд “Аливаа маргаантай асуудлыг шийдэхдээ тодорхой нэг саналд хүрэхгүй боловч талуудын сонирхолд тохирсон шийдэлд хүрэх арга зам.”¹⁶², Монгол хэлний хадмал тольд “зөвшилц - зөвшихийн үйлдэлцэх хэв, харилцан зөвших;”¹⁶³, Монгол хэлний товч тайлбар тольд “зөвшилдөх - олноороо зөвших, зөвлөлдөх; зөвших - аливаа хэрэг явдлыг санал солилцон, шүүмжлэн хэлэлцэх”¹⁶⁴ гэсэн бол Улсын Дээд шүүхээс Ерөнхийлөгчийн тухай хуулийн зарим зүй заалтыг тайлбарлах тухай 1996 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 216 дугаар тогтоолд: 1.“Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан "зөвшилцөх" гэдгийг хууль тогтоомжид өөрөөр тодорхойлоогүй бол Ерөнхийлөгч, УИХ буюу Ерөнхий сайд тодорхой бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль бүрэн эрхэд хамаарах асуудлаар өөрийн гаргаж буй шийдвэр авах гэж буй арга хэмжээнийхээ талаар хуульд заасан байгууллага, албан тушаалтантай санал солилцохыг ойлгоно. 2.Хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...нам буюу намуудын сонгуулийн эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг УИХ-д оруулна" гэдгийг Ерөнхийлөгч Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх хүнийхээ тухай өөрийн саналыг тухайн нам буюу намуудад бичгээр оруулж нам бүрээс бичгээр саналыг нь авахыг ойлгоно гэж¹⁶⁵, академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номонд “Санал нэгтгэйгээр буюу эсрэг саналгүйгээр шийдэлд хүрнэ гэсэнтэй ойролцоо утгатай;”¹⁶⁶, гэсэн бол Монгол Улсын Үндсэн Хуулийн тайлбарт “зөвшилцөх гэдэг нэр томъёо бол төр, засгийн дээд байгууллага, албан тушаалтнуудын хооронд болон олон улсын харилцаанд ямар нэг асуудлыг шийдвэрлэхийн тулд урьдчилан хэлэлцээр хийж харилцан санал нэгдэх аргыг илэрхийлдэг...” гэсэн бол Д.Солонго “Төрийн эрх зүйн тайлбар толь” номонд “Эрх бүхий байгууллага батлан гаргах актын төсөл, эсхүл аль нэг албан тушаалд томилохоор нэр дэвшүүлсэн хүний талаар нөгөө байгууллагаас урьдчилан санал дүгнэлт авах ажиллагаа юм”¹⁶⁷ гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, “Зөвшилцөл” хэмээх үгийн утга, агуулга нь Монгол хэлний толь бичигт болон хууль зүйн эрдэмтдийн гадаад хэлнээс хөрвүүлсэн судалгаанаас харахад “хамтын шийдвэр; тодорхой асуудлыг санал нэгтэй; нэгдмэл санаа бодлоор шийдвэрлэх” гэсэн утгатай дүйж байгаа юм.

ИТГЭМЖЛЭХ ЖУУХ БИЧИГ

Төлөөлөгчийн газрын тэргүүнийг хүлээн авагч улсын төрийн тэргүүнд итгэмжлэх жуух бичгээр нотолдог. Итгэмжлэх жуух бичиг гэсэн нэр томъёо нь итгэл найдлага /*credencetum*/¹⁶⁸ гэсэн утга бүхий Латин үгнээс гаралтай бөгөөд Олон улсын эрх зүйн гол үндсэн эх сурвалж

¹⁶² МУ-ын Шинжлэх ухааны академи, Монгол хэлний их тайлбар толь

¹⁶³ Ш.Чоймаа нар, Монгол хэлний хадмал толь, (кирил- монгол- тайлбар), (2011), 341 дэх тал.

¹⁶⁴ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (УБ, 1966), 278 дахь тал.

¹⁶⁵ Энэхүү Дээд шүүхийн тайлбарыг академич С.Нарангэрэл "Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ" сэдэвт эрдэм шинжилгээний хурлын “Судалгаа хууль зүйн нэр томъёоны амин сүнс” илтгэлдээ “...нэгдмэл буюу хамтын санаа бодол гэсэн зөвшилцлийн үндсэн утгыг нь илэрхий гуйвуулан “санал солилцох”, “бичгээр саналыг нь авах” болгон хувиргажээ хэмээн шүүмжилсэн билээ.

¹⁶⁶ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW Dictionary, Анхны хэвлэл, (УБ, 2007), 219 дэх тал.

¹⁶⁷ Д.Солонго, Төрийн эрх зүйн тайлбар толь, (УБ, 2003), 39 дэх тал.

¹⁶⁸ <https://www.etymonline.com/>

болох” Дипломат харилцааны тухай Венийн Конвенцод /1961/¹⁶⁹ “credentials” англи үгээр илэрхийлсэн байдаг. Монгол хэлэнд итгэмжлэх жуух бичгийг “letters of credence” үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг байна.¹⁷⁰ Оксфордын хуулийн толь бичигт: letter of credence¹⁷¹ /lettre de creance/- тухайн улсаас шинээр томилогдсон дипломат төлөөлөгчөө хүлээн авагч орны төрийн тэргүүнд итгэмжилэн баталгаажуулсан албан бичиг баримт гэж бичсэн байна. НҮБ-ын ЮНЕСКО-гийн албан цахим хуудаснаа байршуулсан Монгол Улсын Үндсэн хуулийн¹⁷²(1992) англи хэлний орчуулгын хувилбарт “to receive the Letters of Credence” буюу “итгэмжлэх жуух бичгийг хүлээн авах” хэмээн орчуулжээ.

Өнөөгийн байдлаар Бүгд Найрамдах Литва Улс, Исламын Бүгд Найрамдах Иран Улс, Бүгд Найрамдах Хорват Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Сальвадор улс Үндсэн хуульдаа итгэмжлэх жуух бичиг /the letter of Credence/ гэсэн томъёоллыг¹⁷³ оруулсан байдаг.

Итгэмжлэх жуух бичиг гэсэн Үндсэн хуулийн нэр томъёог түүхэн талаас нь авч үзвэл, Их Монгол Улс 1206 онд байгуулагдсан цагаас хааны зарлигийг зарлан тунхаглах хүнд хааны дур зоригийн үнэн мөнийг, тухайн зарлигийн жинхэнэ болохыг батлан гэрчилсэн тусгай тэмдэг-пайзыг¹⁷⁴ уг зарлигийг дагалдуулан олгодог байжээ.

1924 оны Монгол Улсын Анхны Үндсэн хуульд “итгэмжлэх жуух” гэсэн нэр томъёо, хуулийн үг заалт ороогүй байна. Харин БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуульд *итгэмжлэх бичиг*, БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуульд *итгэмжлэх жуух бичиг* гэсэн нэр томъёо орж, 1992 оны Үндсэн хуульд энэхүү хуулийн томъёог тэр чигт нь хадгалжээ.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Итгэмжлэх жуух” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Я. Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д “Итгэх, найдах, түшиг тулгуур болох, (итгэмжлэх бичиг) нэг этгээд нөгөөдөө өөрийн төлөө ямар нэг зүйлийг гүйцэтгэхийг итгэмжлэн олгох бичиг”¹⁷⁵ гэсэн бол Монгол хэлний товч тайлбар тольд “жуух: жуух бичиг – ямар нэгэн төлөөний хүмүүст олгох итгэмжлэл үнэмших бичиг буюу итгэмжлэх жуух бичиг харь улсад улсаа төлөөлөн суулгах диплоамт төлөөлөгчид олгох бүрэн эрхийн бичиг”, Хууль зүйн тайлбар

¹⁶⁹ <https://www.legalinfo.mn/law/details/1164>; гадаад цахим эх сурвалж: (Сүүлд үзсэн 2019.06.07), http://legal.un.org/ilc/texts/instruments/english/conventions/9_2_1963.pdf, Vienna Convention on Consular Relations. (Сүүлд үзсэн 2019.06.07)

1963, Article 13: “1.The head of the mission is considered as having taken up his functions in the receiving State either when he has presented his credentials or when he has notified his arrival and a true copy of his credentials has been presented to the Ministry for Foreign Affairs of the receiving State, or such other ministry as may be agreed, in accordance with the practice prevailing in the receiving State which shall be applied in a uniform manner.

2.The order of presentation of credentials or of a true copy thereof will be determined by the date and time of the arrival of the head of the mission.”

¹⁷⁰ Д.Ганхуяг, Ш.Юмжав, Дипломат эрх зүй, (УБ, 2014), 63 дахь тал.

¹⁷¹ Jonathan Law, *A Dictionary of Law, 7th edition*, Oxford University Press, 2009, 323 дахь тал. “a formal document by which the head of an accredited state presents its newly appointed diplomatic agent to the head of state of the host country”.

¹⁷² <http://www.unesco.org/education/edurights/media/docs/6a6a23469e136afaa4860bf5869f6f8f659c6688.pdf> (Сүүлд үзсэн: 2019.06.10)

¹⁷³ https://constitution.com/?s=letter+of+credence+&post_type=post, (Сүүлд үзсэн: 2019.06.10)

¹⁷⁴ В.А.Рязановский, *Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, Их засаг хууль*, УБ.,2000, 15 тал. “пайзыг нэгдүгээрт, хааны зарлигийн баталгаа болгож; хоёрдугаарт, тухайн хүний, элч, түшмэл, алба гүйцэтгэгч гэх мэт эрхэлж буй хэргэм зэргийн тэмдэг болгож; гуравдугаарт, дагаар орон бууж өгөгсөдийг хамгаалах жуух болгож ашигладаг байсан байна.”

¹⁷⁵ Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (УБ,1966).

тольд “итгэмжлэл нэгэн этгээд (итгэмжлэгч) өөрийн нэрийн өмнөөс хууль зүйн үр дагавар бүхий тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, бүрэн эрхийг нөгөө этгээд (итгэмжлэгдэгч)-д олгосноо бичгээр тодорхойлсныг итгэмжлэл гэнэ”¹⁷⁶ гэж тодорхойлсон. Харин эрх зүйн мэдлэгийн товч тольд “нэг этгээдээс (итгэмжлэгчээс) нөгөө этгээдэд (итгэмжлэгдэгчид)-д өөрийн нэрийн өмнөөс хууль ёсны тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэхийн тулд бичгээр олгосон бүрэн эрх”¹⁷⁷ гэж дэлгэрэнгүй бөгөөд анхлан тайлбарлажээ. Мөн энэ талаар академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” номондоо “итгэмжлэл (латин *mandatum*; англ. *Letter of authorney procurasy*; *power of attorney*; орч. *доверенность*) нэг этгээд нь өөрийн нэрийн өмнөөс хууль зүйн үр дагавар бүхий тодорхой үйлдэл хийлгэхийн тулд нөгөө этгээдэд бүрэн эрх олгосноо бичгээр тодорхойлох,”¹⁷⁸, “*итгэмжлэх жуух* – (англ. *credential*; ор. *Верительные грамоты*) – элчин сайд буюу элчингийн зэрэг дэв бүхий дипломат төлөөлөгч түүний төлөөллийн шинж ба гадаад улсад тохоон томилогдсныг гэрчлэх баримт бичиг”¹⁷⁹, академич Ж.Амарсанаа “Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг” номондоо “Дипломат¹⁸⁰ Герэг хэлний үг- Дипломат захиа, итгэмжлэх жуух бичиг эзэмшигч дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн ба ажилтныг дипломатч гэнэ. Гадаад улс, олон улсын байгууллагатай гадаад харилцааны асуудлаар харилцах төрийн байгууллагын эрх бүхий албан ёсны этгээд гээд *letter of delegation*¹⁸¹ - *итгэмжлэл*,” Хуулийн нэр томъёоны дагалга” номонд¹⁸² “итгэмжлэл- аливаа байгууллага, эсхүл хувь хүн нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх чадавхтайг нь эрх бүхий байгууллагаас тогтоож албан ёсоор хүлээн зөвшөөрөх ажиллагаа;” гэж тус тус тайлбарлажээ.

Харин Проф. Чой. Лувсанжав нарын “English- Mongolian Dictionary”-д “*Credentials*”¹⁸³ – *итгэмжлэх жуух бичиг* гэж монгол хэлнээ буулгасан байдаг. Мөн доктор Д.Ундралсайхан *letter of credence*¹⁸⁴ – итгэмжлэх жуух бичиг хэмээн орчуулсан нь бий.

Дүгнэвэл, гадаад оронд улсаа төлөөлөн суухаар шинээр томилогдсон дипломат төлөөлөгчийн төлөөлөх чадварыг нотолсон албан ёсны баримт бичгийг итгэмжлэх жуух бичиг хэмээн ойлгох бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль дахь “итгэмжлэх жуух бичиг” хэмээх хуулийн нэр томъёог манай улс 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуульдаа анхлан томъёолжээ. Өнөөгийн Үндсэн хууль хүртэл дээрх нэр томъёо эдүгээ нийтдээ 59 жилийн турш хэрэглэж ирсэн хэвшин тогтсон томъёолол юм.

¹⁷⁶ Хууль зүйн тайлбар толь, (Уб, 2003), 140 дэх тал.

¹⁷⁷ Эрх зүйн мэдлэгийн товч толь, (Уб, 1986), 76 дахь тал.

¹⁷⁸ С.Нарангэрэл, Эрх зүйн мэдлэгийн товч толь, (2007, Анхны хэвлэл), 242-243 дахь тал. “итгэмжлэх жуух бичигт дипломат төлөөлөгчийг тохоон томилсон улсын тэргүүн үзэглэж, гадаад хэргийн сайдын гарын үсгээр баталгаажуулсан байдаг. Суух улсын төрийн тэргүүнд хаяглаж, түүнд ёслолын байдалтай гардуулна. Итгэмжлэх жуух бичигт дипломат төлөөлөгчийн овог, нэр, хоёр улсын хоорондын хэлэлцээрээр тодорхойлогдсон түүний зэрэг дэвийг заасан байна. Итгэмжлэх жуух бичиг нь ерөнхий бүрэн эрхийн шинжтэй байна. Хэрэв дипломат төлөөлөгчид олон улсын хэлэлцээрт гарын үсэг зурах даалгавар өгвөл, түүнд энэ талаар тусгай бүрэн эрх олгоно.

¹⁷⁹ С.Нарангэрэл, Хууль зүйн судлалын англи-монгол тайлбар толь, (Уб, 2005).

¹⁸⁰ Ж.Амарсанаа, Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг, (Уб, 2014), 15 дахь тал.

¹⁸¹ Англи- Солонгос- Монгол- Орос- Герман – Хууль зүйн толь, (Уб, 2013), 288 дахь тал.

¹⁸² Хууль зүйн үндэсний төв, Хуулийн нэр томъёоны дагалга, (Уб, 2004), 46 дахь тал.

¹⁸³ Проф. Чой. Лувсанжав, Ц.Сумъяа, English- Mongolian Dictionary, (Уб, 1990), 45 дахь тал.

¹⁸⁴ Д.Ундралсайхан, Орчин үеийн олон улсын эрх зүй, (Уб, 2016), 293 дахь тал.

ОНЦ БАЙДАЛ

Онц байдлыг англи хэлний “state emergency”, орос хэлний “чрезвычайное положение”¹⁸⁵ гэх үгтэй дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд онц байдал хэмээх ойлголт нь эртний Ромын эрх зүйн Юститиум (лат. Justitium)¹⁸⁶ гэх ойлголттой ижилхэн бөгөөд МЭӨ 465 онд Эквы омгийнхон дайрахаар айсуу гэсэн цуурхлаас болж хотод үймээн дэгдсэн тул анхны Юститиумыг зарлаж байжээ.

Онц байдал гэдэг нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад ердийн үед зөвшөөрөгдөхөөргүй үйлдэл хийх бүрэн эрхийг олгож буй үйл ажиллагаа буюу байгалийн гамшиг, иргэний дайн, зэвсэгт мөргөлдөөн зэргийн үед зарлаж болох ажиллагаа юм. Онц байдлыг зарлах нь ард иргэдэд өдөр тутмын хэвийн байдлаа өөрчлөх болон Засгийн газрын агентлагуудад онц байдлын шийдвэрийг хэрэгжүүлэх нөхцөл байдлыг үүсгэдэг.¹⁸⁷

Олон Улсын эрх зүйн дагуу онц байдлын үед тухайлбал, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэлгүйгээр хүнийг цагдан хорих буюу эрх, эрх чөлөөг хязгаарлаж болно. Өөрөөр хэлбэл, ИБУТЭТОУП-д заасан аливаа эрхийг хязгаарлаж болох ба гагцхүү тус пактын 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрхүүдээс ухарч үл болно. Тодруулбал, “ухарч үл болох эрх” (англ. Non-derogable rights) гэдэгт амьд явах эрх, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс ангид байх эрх чөлөө хамаарна.

Зарим улсууд онц байдлын үеэр Үндсэн хууль болон ОБТХ-даа нэмэлт, өөрчлөлт оруулах, нөгөө зарим нь Үндсэн хуулийн хүрээнд баталгаажуулсан эрх, зохицуулалтыг ямар ч үед, хүссэн хэлбэрээр өөрчлөх зэргээр Олон Улсын Пактыг зөрчдөг.¹⁸⁸ Үндсэн хууль нь Засгийн газар болон хувь этгээд хоорондын гэрээ байдаг тул ИБУТЭТОУП-д нэгдэн орсон улсууд заавал дагаж мөрдөх учиртай. Өөрөөр хэлбэл, онц байдалд хамаарах асуудлын хүрээг дураараа томьёолох боломжгүй юм. Пактад нэгдэн орсон гэдэг утгаар тус пактыг хувь этгээдээс илүү Засгийн газар биелүүлэх үүрэг хүлээх бөгөөд онц байдал зарласан тохиолдолд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдээлнэ.

Онц байдал нь аливаа улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл болдог бөгөөд зарлах журам, эрх зүйн үндэслэлийг улсууд пактад нийцүүлэн янз бүрээр зохицуулж байна.

Дэлхий даяар, ялангуяа Англи-Америкийн эрх зүйд өргөн хэрэглэгддэг АНУ-ын хууль зүйн нэр томьёоны “Блэкийн хууль зүйн толь”-д “Үндэсний онц байдал” (англ. National emergency) гэж “Үндэсний хэмжээний хямралт байдал; Холбоо болон үндэсний хэмжээнд хойшлуулшгүй бөгөөд онц арга хэмжээ авахыг шаардсан нөхцөл байдал” -ыг ойлгохоор тайлбарласан¹⁸⁹ байна.

¹⁸⁵ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW (УБ, 2007), Адмон, 352 дахь тал.

¹⁸⁶ William Smith, William Wayte and G.E.Marindin, John Murray, *A Dictionary of Greek and Roman Antiquities*, Volume 1, (London:1890), p.1052.

¹⁸⁷ Anna Khakee, *Securing Democracy?, A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30, (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.6.

¹⁸⁸ *Nuovi studi politici* “Declaratoria dello stato di emergenza e Consiglio supremo di difesa” (2005, n. 1/2): p. 107.

¹⁸⁹ Henry Campbell Black, *Black's law dictionary*, 9th edition, (Minn, St.Paul: West publishing Co, 2009), p.1122.

Блэкийн хууль зүйн толь төдийгүй 1943 оны шүүхийн шийдвэрт тусгагдсан байдлаас үзвэл, “Онц байдал” хэмээх ойлголт нь Англи-Америкийн эрх зүйд нэлээд эртнээс хэрэглэгдэж ирсэн гэж үзэж болохоор байна. Түүнчлэн эртний Ромын эрх зүйд МЭӨ 465 оноос хэрэглэсэн ойлголт гэж үзвэл эх газрын эрх зүйн бүлийн орнуудын хувьд мөн олон жилийн түүхтэй үйл ажиллагаа гэхээр байна.

Онц байдлын төрөлд юу хамаарах талаар нэгдсэн тодорхойлолт, жагсаалт байхгүй бөгөөд улсууд үндэсний хууль тогтоомжоороо хүрээг нь томъёолж байна.

Байгалийн гамшиг болон тахал нь эмх замбараагүй байдал буюу төрийн эрхэд халдсан үйлдлээс ялгаатай хариу үйлдлийг шаардаж, ялгаатай үр дүнг бий болгодог. Мөн террорист халдлага нь эдийн засгийн хямрал буюу гадаадын зэвсэгт довтолгооноос ялгаатай. Энэ мэтчилэн нийгэмд гарч болох онц байдал хоорондын ялгаа нь Үндсэн хууль боловсруулагч болон энэ чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтдийн хувьд ихээхэн бэрхшээлтэй асуудал болдог байна.¹⁹⁰ Онц байдалд хамаарах асуудлын хүрээг тодорхойлж чадахгүй байх нь мөн онц байдлыг хуулиар зохицуулахтай холбогдсон харилцаанд эргэлзээ үүсэх үндэс болно. Дэлхий дахинд улсууд Үндсэн хуульдаа онц байдлын төрлийг зохицуулж буй хэлбэрээр нь дараах байдлаар 3 ангилж болно:¹⁹¹

- Өргөн утгаар нь зохицуулж буй (Герман, Грек, Унгар, Польш, Португаль, Испани);
- Явцуу утгаар нь зохицуулж буй (Австри, Бельги, Кипр, Чех, Дани, Финланд, Люксембург, Норвеги, Швейцарь);
- Дундаж хүрээнд зохицуулж буй (Болгарь, Эстони, Франц, Ирланд, Итали, Латви, Литва, Мальт, Нидерланд, Румын, Словак, Словени, Швед).

Дээрхээс үзвэл онц байдал гэдэгт бүхий л төрлийн ноцтой аюул, байгалийн гамшиг, дайны байдал зэргийг хамааруулах эсэхийг улс орон Үндсэн хуульдаа ялгамжтай байдлаар зохицуулж байна.¹⁹² Гэвч энэхүү ялгамжтай байдал гэдгийн зааг ялгаа нь нэг талаас дайны байдлыг онц байдалд хамааруулах эсэх, нөгөө талаас бусад онц байдлын төрлүүдийг хамааруулах эсэх гэсэн асуудалд оршино.

Саяхныг хүртэл захиргаадалтын дэглэмд байсан буюу Эстони, Польш, Испани зэрэг улсууд Үндсэн хуульдаа онц байдлыг илүү нарийвчилсан байдлаар зохицуулсан байна. Тодруулбал, үүнийг “гурван шатлалт тогтолцоо” (англ. Three-level system) гэх бөгөөд дайны байдал, онц байдал, байгалийн гамшиг зэргийг нийлүүлэн “онцгой арга хэмжээ” буюу “онц байдал” хэмээн томъёолжээ. Гэтэл Унгарын Үндсэн хуульд зааг ялгааг нь нарийн тодорхойлоогүй ч онц байдлын таван өөр түвшинг хуульчилжээ. Тэдгээр нь дайны байдал, үндэсний хямралт байдал, онц байдал, урьдчилан сэргийлэх батлан хамгаалах байдлыг зарлах эсхүл үргэлжлүүлэх зэрэг болно.

Ирээдүйд үүсэж болзошгүй онц байдлын хэлбэр, төрлийг урьдчилан нарийн тодорхойлох боломжгүй тул улсууд ихэвчлэн Үндсэн хуульдаа “Үндсэн хуулийн дэг журамд заналхийлсэн”,

¹⁹⁰ Anna Khakee, *Securing Democracy?, A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30, (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.10.

¹⁹¹ Мөн тэнд, 11 дэх тал.

¹⁹² Мөн тэнд.

“нийтийн дэг журамд ноцтой заналхийлсэн”, “тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлсэн” зэрэг томъёоллоор онц байдлыг тусгажээ.¹⁹³

Харин Монгол Улсын хувьд энэхүү ойлголт хэзээнээс нэвтэрсэн талаар түүх сөхвөл, 1940 оны БНМАУ-ын Үндсэн хуульд “онц байдал” гэсэн агуулга бүхий заалт байхгүй боловч хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 11 дэх хэсэгт “Бага хурлын чөлөө цагт хэрэв Бүгд Найрамдах Монгол Ард Улсад дайнаар довтолох буюу эсхүл харилцан туслалцаж дайран довтологчдоос хамгаалалцахаар Олон Улсын хооронд тогтоосон гэрээний үүргийг гүйцэтгэх учир тохиолдвол Бага Хурал нь дайн бүхий байдлыг зарлах”¹⁹⁴ хэмээн Бага Хурлын Тэргүүлэгчдийн эрхлэх асуудлыг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, 1940 оны Үндсэн хуульд дайны байдал зарлах эрх зүйн зохицуулалт байсан боловч онц байдлын талаар тусгаагүй.

1960 оны БНМАУ-ын Үндсэн хуульд мөн “онц байдал” гэсэн ойлголт байхгүй бөгөөд гагцхүү хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн “р” дэх хэсэгт “БНМАУ-д халдан довтолоход буюу түүнчлэн харийн довтолгооноос харилцан бие биеэ хамгаалах талаар Олон Улсын гэрээгээр авсан үүргээ биелүүлэх хэрэгцээ тохиолдвол Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт дайны байдал зарлана”¹⁹⁵ хэмээн Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн бүрэн эрхийг заасан байна.

1992 оны Үндсэн хуульд анх удаа “онц байдал” гэсэн ойлголтыг тусгаж, хуулийн Арван есдүгээр зүйлийн 2, Хорин тавдугаар зүйлийн 1-ийн 18, мөн зүйлийн 2, Хорин долдугаар зүйлийн 5, Гучин гуравдугаар зүйлийн 1-ийн 12 дахь хэсэгт тус тус уг ойлголтыг хуульчилжээ.

Ингэхдээ Улсын Их Хурлаас 1995 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ОБТХ-ийг баталж, хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг онц байдал гэнэ” хэмээн тодорхойлжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно:

1/улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;

2/Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон” хэмээн заажээ.

¹⁹³ Мөн тэнд, 12 дахь тал.

¹⁹⁴ 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, Ханнс-Зайделийн сан, (УБ, 2007), 32 дахь тал.

¹⁹⁵ Мөн тэнд, 106 дахь тал.

Академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номондоо “онц байдал”-ыг “тухайн улс орны амьдралд нөлөөлөхүйц онцгой нөхцөл байдал бий болсныг эрх зүйн үүднээс тодорхойлсон нэр томъёог онц байдал гэнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйд тус улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл байдал бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэм.”¹⁹⁶ хэмээн тайлбарлажээ.

Дүгнэвэл, улс орнууд өөрийн орны зан заншил, иргэншил, онцлогоос шалтгаалж онц байдалд өөр өөр асуудлыг өргөн болон явцуу хүрээнд авч үзэж байна. Гэсэн хэдий ч түгээмэл байдлаар байгалийн гамшиг, гоц халдварт өвчин зэрэг шалтгааны улмаас нийгэмд аюултай нөхцөл байдал үүссэн үед онц байдал зарлахаар тогтоосон байна.

Мөн онц байдлыг тусгай журам болон салбар хуулиудаар зохицуулдаг улс орнууд байхад манай улстай адил бие даасан хуулиар зохицуулдаг улс орнууд ч цөөнгүй байна.

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэх нэр томъёог монгол хэлэнд “national security council”¹⁹⁷ гэх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг байна.

АНУ-ын тухайд Үндэсний аюулгүй байдал гэх ойлголтыг анх АНУ-ын ерөнхийлөгч Т.Рузвельт Панамын сувгийг нэгтгэхтэй холбогдуулан 1904 онд конгресс дээрээ хэлсэн байдаг.¹⁹⁸ АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл¹⁹⁹ нь үндэсний аюулгүй байдлын талаарх бүх асуудлаар Ерөнхийлөгчид зөвлөгөө өгдөг Засгийн газрын агентлаг юм. (1947 оны Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 402 дугаар зүйлд зааснаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг үүсгэн байгуулсан). Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (NSC) бол үндэсний аюулгүй байдалд хамаарах бүх асуудлаар Ерөнхийлөгчид зөвлөгөө өгөх хороо. Үүнд: дотоодын, зэвсэгт хүчний болон гадаад асуудлууд хамаарна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь Ерөнхийлөгчийн удирдаж буй Засгийн газрын удирдлагад хамаарна. Энэ нь Ерөнхийлөгчийн ахлах үндэсний аюулгүй байдлын зөвлөх болон кабинетын гишүүдээс бүрддэг.²⁰⁰

Францын Үндсэн хуульд үндэсний батлан хамгаалах асуудлыг ерөнхий сайд хариуцаж, хариуцлага хүлээнэ гэж заасан байдаг. Францын батлан хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч Ерөнхий сайдаас гадна гадаад хэргийн сайд, Санхүү эдийн засгийн сайд, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга нар ордог байна. Францын Ерөнхийлөгч нь АНУ-ын Ерөнхийлөгч шиг зэвсэгт хүчинд ямар нэгэн тушаал шууд өгдөггүй. Хэрэв тийм зайлшгүй шаардлага гарвал

¹⁹⁶С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ, 2007), 353 дахь тал.

¹⁹⁷ Мөн тэнд, 483 дахь тал.

¹⁹⁸ Ж.Амгалан, “Үндэсний аюулгүй байдал гэсэн ойлголтыг хамаагүй ярих нь сөргөөр нөлөөлнө” (сурв. Г.Цолмон), 2015.10.27, <http://unuudur.mn>, (Сүүлд үзсэн 2019.05.14).

¹⁹⁹ Henry Campbell Black, *Black's law dictionary*, 9th edition, (Minn, St.Paul: West publishing Co, 2009), p.1125.

²⁰⁰ <https://study.com/academy/lesson/national-security-council-definition-history-members-role.html> (Сүүлд үзсэн: 2019.06.20).

Ерөнхий сайд, Батлан хамгаалах сайд, Үндэсний батлан хамгаалах Зөвлөлтэй зөвшилцөж байж шийдвэрээ гаргадаг байна.²⁰¹

Харин Филипин Улсын хувьд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь хоёр үндсэн хэсгээс бүрддэг бөгөөд үүнд, төрийн асуудал эрхэлсэн зөвлөл, үндэсний аюулгүй байдлын зөвлөл хамаарна. Зохих асуудлыг эрхэлсэн зөвлөл нь ерөнхийлөгчийн удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг. Уг зөвлөлд Конгрессийн ба танхимын гишүүд, бусад Засгийн газрын гишүүд болон ерөнхийлөгчийн урилгаар иргэд оролцож болдог.²⁰²

Филипиний Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь 1950 оны 7 сарын 1-ний өдөр Ерөнхийлөгч Quirino-ийн 330 дугаар захирамжаар анх байгуулагдсан. Үүний дараа 1986 онд бүтэц зохион байгуулалтаа шинэчилсэн байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь төрийн асуудал эрхэлсэн зөвлөлийг тасралтгүй дэмжлэг үзүүлдэг байгууллага бөгөөд уг байгууллагыг үндэсний аюулгүй байдлын зөвлөл удирддаг байна.²⁰³

Монгол Улс 1992 оны нэгдүгээр сарын 13-нд баталсан шинэ Үндсэн хуулиараа Ерөнхийлөгчийн институцийг бий болгож, уг хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт 10 дахь заалтад Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийн дотор “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх” гэж заасан. 1990 оны анхны ардчилсан чөлөөт сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Бага Хурал 1992 оны 5 дугаар сарын 29-нд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийг баталж уг зөвлөлийг байгуулсан юм.²⁰⁴ Энэ хуулиар Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зарчим, чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тодорхойлон заасан байна. Тодруулбал: “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага мөн бөгөөд Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь Монгол УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Засгийн газар, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнаас бүрдэнэ хэмээн заажээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь Ерөнхийлөгч бөгөөд УИХ-ын дарга, Ерөнхий сайд зөвлөлийн гишүүн байдаг. УИХ-ын дэд дарга, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, УИХ дахь нам, эвслийн бүлгийн ахлагч нар зөвлөлийн хуралдаанд зөвлөх эрхтэй оролцдог²⁰⁵ байна.

“Үндэсний аюулгүй байдал” хэмээх үгийг Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд /2001 он/ “Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ;” гэсэн бол Британика нэвтэрхий тольд “Аюулгүй байдлыг хүн ба эд хөрөнгийг янз бүрийн аюулаас хамгаалах арга, хэрэгслийн систем”, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010 он)-д “Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг

²⁰¹ П.Очирбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр, (УБ, 2001), 62 дахь тал.

²⁰² <http://www.nsc.gov.ph/> (Сүүлд үзсэн: 2019.06.20).

²⁰³ Мөн тэнд.

²⁰⁴ 1992 оноос хойш Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн болон нарийн бичгийн даргаар ажиллаж байсан хүмүүсийн мэдээллийг хавсралт 5-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

²⁰⁵ Л.Лүндээжанцан, Ч.Энхбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, (УБ, 2000), 170 дахь тал.

сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ;²⁰⁶ В.И.Далийн тайлбар тольд “Аюулгүй байдал гэдэг нь аюулаас ангид байх, хадгалах чанар, найдвартай байдал”, С.И.Ожеговын орос хэлний тольд “Хүн буюу ямар нэгэн юманд аюул учрахгүй байх төлөв”, П.Шагнягийн Олон улсын харилцааны франц тольд “хамгаалагдсан төлөв”²⁰⁷, ОХУ-ын Аюулгүй байдлын тухай хууль (1992 он)-ийн нэр томъёоны тайлбарт “Төр, нийгэм, хувь хүний амин чухал ашиг сонирхол гадаад, дотоодын аюул заналаас хамгаалагдсан байдлыг хэлнэ;” гэсэн бол академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номондоо “Үндэсний аюулгүй байдлын зөвлөл үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн явагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага. Ажлаа УИХ-ын өмнө хариуцна²⁰⁸ гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, дэлхийн улс орнуудын онцлог, эрх зүйн бүл, соёл, иргэншлээс хамаарч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг өөр өөр байдлаар нэрлэж байх боловч чиг үүргийн хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг тэрхүү байгууллагууд нь хэрэгжүүлж байна. Тэдгээр байгууллага үндэсний аюулгүй байдлын хамтарсан хороо²⁰⁹, үндэсний батлан хамгаалах зөвлөл²¹⁰, үндэсний аюулгүй байдлын зөвлөл²¹¹ гэх мэтээр нэрлэдэг байна.

ДАЙЧИЛГАА

Дайчилгаа хэмээх үгийг англи хэлний “mobilisation” хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг байна. АНУ-ын Үндсэн хуулиар конгресст олгосон 2 эрх мэдлийн нэг нь АНУ гадны халдлага болон босогчдыг дарах хуулийг хэрэгжүүлэх зорилгоор зэвсэгт хүчнийг дайчлах эрх²¹² бөгөөд Дайнд иргэдийн хүч шаардлагатай байгаа боловч сайн дурынхан хангалтгүй байгаа тохиолдолд хуульд заасны дагуу дайчилгаа зарлаж дайнд оролцох чадвартай хүмүүсийг дайчилгаанд хамруулдаг.²¹³

Дайчилгаа (Зэвсэгт хүчинд алба хаах) анх дэлхийн 1 дүгээр дайн, 1939 онд дэлхийн 2 дугаар дайны үед анх Их Британи Улсад хэрэглэж байсан бөгөөд дэлхийн 2 дугаар дайн дууссаны дараа үндэсний албаны нэрээр нэрлэгдсэн. Дайны үед 18-аас 41 насны бүх эрэгтэйчүүдийг дайчлан дуудах боломжтой. Зэвсэгт хүчин нь анх олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үймээнийг таслан зогсоох зорилготой байсан боловч хожим нь шархадсан хүмүүсийг асрах үүргийг мөн гүйцэтгэж байсан. 1948 оны дараа 19-өөс 25 насны эрэгтэйчүүдийг 21 сараар цэргийн алба хаалгаж байсан (дараа нь 2 жил болгон нэмсэн) байна.²¹⁴

Монгол Улсын тухайд Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд дайчилгаа зарлах тухай зарлиг гаргана. Уг зарлиг дайчилгааны ямар хэлбэрийг зарлаж байгааг, мөн дайчилгаа

²⁰⁶ Мөн тэнд.

²⁰⁷ Б.Өлзийхуяг, “Аюулгүй байдлын ухааны хөгжлийн асуудал”, Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл, №2 (36) (2018): 18 дахь тал.

²⁰⁸ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ, 2007), Адмон, 485 дахь тал.

²⁰⁹ Австрали, Ирланд гэх мэт (англ. National security committee).

²¹⁰ Армен, Бразил гэх мэт (англ. national defence council).

²¹¹ Монгол, Эстони, Энэтхэг, Тайланд, Турк гэх мэт (англ. National security council).

²¹² Henry Campbell Black, *Black's law dictionary*, 9th edition, (Minn, St.Paul,: West publishing Co, 2009), p.1083.

²¹³ <https://www.vocabulary.com/dictionary/conscription> (Сүүлд үзсэн: 2019.06.20).

²¹⁴ Мөн тэнд.

зарлахад хүргэсэн цэрэг, улс төрийн нөхцөл байдал, дайчилгаа явуулах нутаг дэвсгэр, дайчлах хүний тоо, насны хязгаар, цэргийн мэргэжлийн ангилал, дайчлах эд хөрөнгийн төрөл, тоо хэмжээ, дайчилгаа эхлэх хугацаа, явуулах дараалал, дайчилгааг зохион байгуулах журам зэрэг дайчилгааны арга хэмжээг явуулахад нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой бусад асуудлыг тусгана.²¹⁵

1998 онд Дайчилгааны тухай хууль батлагдсанаар дайчилгааны эрх зүйн үндэс бүрдсэн бөгөөд 2002 онд “Улсын дайчилгааны төлөвлөгөө”-г Монгол Улсын Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан. Дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөөг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхийг “бүх нийтийн дайчилгаа”, нутаг дэвсгэрийн зарим хэсэгт дайчилгаа явуулах буюу хязгаарлагдмал зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөөний зөвхөн зарим арга хэмжээг хэрэгжүүлэхийг “хэсэгчилсэн дайчилгаа” гэнэ.²¹⁶

Манай улсад дайчилгааны зарлан мэдээллийн систем нь:

1. Дайчилгааг нууцаар зарлах:

- Үндсэн арга – Электрон дайчилгааны систем буюу телефон холбооны хэрэгсэл /гэр, ажлын болон үүрэн телефон/ эсхүл факсаар зарлан мэдээллийг явуулна. Иймээс цэргийн үүрэгтний хувийн мэдээлэл ялангуяа холбоо барих утасны дугаар чухал ач холбогдолтой. Цэргийн бэлтгэн үүрэгтэн нь цэргийн үүрэгтний нэгдсэн портал сайтаар дамжуулан хувийн мэдээллээ байнга тодотгох шаардлагатай.
- Нөөц арга – Цэргийн бэлтгэх үүрэгтэнд зарлан мэдээллийг үндсэн аргаар хүргэж чадаагүй тохиолдолд дайчлах тушаал эсхүл дайчлан дуудах мэдэгдлийг гэрийн хаягаар нь хүргэдэг.
- Дайчлах тушаалыг зөвхөн дайны аюул бодитойгоор нүүрлэсэн тохиолдолд өгөх ба дайчлан дуудах мэдэгдлийг сургуулийг журмаар дайчилгаа зарлахад хэрэглэдэг.

2. Дайчилгааг илтээр зарлах:

- Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл тухайлбал, телевиз радиогоор дайчилгааны зарлан мэдээллийг бүх нийтэд зориулан илтээр явуулна. Зарлан мэдээллийг хүлээн авмагц цэргийн бэлтгэл үүрэгтэн нь цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлтэйгээр нэн даруй өөрийн томилгоот дайчилгааны төвд очих үүрэгтэй байдаг байна.²¹⁷

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Дайчилгаа” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Дайчилгааны тухай хуульд “Дайчилгааг улс орны эдийн засаг, нийгмийг шаардлагатай үед дайны байдалд шилжүүлэх, зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулахын тулд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээ”²¹⁸ гэсэн бол Цэргийн нэр томъёоны тайлбар тольд “...зэвсэгт хүчнийг байлдааны бэлэн байдалд оруулах, улс орны төрийн болон төрийн бус байгууллагууд, эдийн засгийг дайны байдалд шилжүүлж, дайнд шаардагдах өөрийн цэргийн хяналтын цогц арга хэмжээ”²¹⁹ гэжээ. Мөн Ч.Энхбаатар нарын “Монгол Улсын Үндсэн хуулийн

²¹⁵ Б.Эрдэнэчимэг, Улсын дайчилгааны төлөвлөлт, түүний нийгэм эдийн засгийн ач холбогдол, Батлан хамгаалах судлал сэтгүүл, №7 (17), (2007), 50 дахь тал.

²¹⁶ Мөн тэнд.

²¹⁷ Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан, (УБ, 2018), Хууль зүйн үндэсний хүрээлэн, 14-15 дахь тал.

²¹⁸ Дайчилгааны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №6,(1998).

²¹⁹ Цэргийн нэр томъёоны тайлбар толь, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, (УБ:, 2014), 138 дахь тал.

тайлбар” номонд “Цэргийн дайчилгаа зарлана гэдэг нь онц байдал болон дайны байдалтай болсон буюу бусад онцгой нөхцөл байдалтай холбогдсон гарцаагүй шаардлагатай үед хийгддэг. Цэргийн дайчилгаа гэдэгт зөвхөн цэргийн насны эрчүүд хамаардаг төдий ухагдахуун биш хүмүүсийн, хөдөлмөрийн, эд материалын зэрэг бүхнийг хамарсан дайчилгаа байдаг.²²⁰ “Улс орны эдийн засаг, нийгмийг дайны байдалд шилжүүлэх, зэвсэгт хүчнийг байлдааны цагийн орон тоогоор нөхөн хангахын тулд дайчилгааны бэлтгэх нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах зорилгоор төр, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас хуулийн дагуу авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээг “дайчилгаа” гэнэ”²²¹ гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, тус нэр томъёог ихэнх улс орон хэрэглэдэг бөгөөд цэргийн дайчилгаа зарлах үндэслэл улс орон бүрт ялгамжтай хэдий ч түгээмэл байдлаар нийтийг хамарсан үймээн самуун даамжирч, зэвсэгт мөргөлдөөн үүсэх нөхцөл бий болсон, зэвсэгт мөргөлдөөн үүссэн тохиолдолд дайны байдал зарлан цэргийн дайчилгаа зарладаг байна. Мөн тухайн улс орны хүн ам, насны байдлаас шалтгаалан дайчилгаа зарлахдаа бүх эрэгтэйчүүд /тухайн улсын хуулиар тогтоосон насны бүх эрэгтэйчүүд/-ийг хамруулж болдог байна.

ДАЙНЫ БАЙДАЛ

Дайны байдал гэх нэр томъёог англи хэлний “State of war” болон “belligerence” гэх хоёр өөр янзаар утга дүйцүүлэн хэрэглэдэг байна. Дайны байдал гэдэг үг нь утгын хувьд хоёр улсын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсч бий болсон эсхүл албан ёсоор дайн зарлаагүй боловч дайсагнасан шинжтэй байгаа үе эсхүл хууль ёсны дагуу зарласан болон зайлшгүй байдлаар зэвсэгт мөргөлдөөнд оролцсон, Дайн үргэлжлэх нөхцөл байдал бий болсон зэрэг үеийг ойлгодог байна. Анх 1928 онд 15 улс Парисын гэрээгээр хоорондын харилцаа, үл ойлголцох явдлаа дайны аргаар зохицуулахаас татгалзсан нь дайныг хориглосон анхны олон талт гэрээ²²² болсон юм.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн “10 А” Үндэсний аюулгүй байдал гэх бүлэгт онцгой нөхцөл буюу үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн нөхцөл бий болсон хууль тогтоох эрх мэдэл хамтарсан хороо буюу парламентын дээд, доод танхимаас бүрдсэн институцэд шилжихээр зохицуулсан.

Дайны байдал үүссэн үед, Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтаас хамааран парламент нь шийдвэр гаргах явцад дараах гурван аргаар оролцож болно (ач холбогдол нь буурах дарааллаар):

1. Үндсэн хуулиар дайн зарлах, энх тайван тогтоох эрхийг парламентад олгосон байх. Гэхдээ өнөөдөр бодит амьдрал дээр аливаа дайн мөргөлдөөн ямар нэг анхааруулгагүйгээр эхлэх нь олонтаа бөгөөд парламент шийдвэр гаргахаас өмнө үйл явдал өрнөх магадлалтай тул энэ нөхцөл харьцангуй хийсвэр юм.
2. Үндсэн хуулийн дагуу гүйцэтгэх засаг нь дайн зарлах, энх тайван тогтоохын өмнө парламентаас шуурхай зөвшөөрөл авах. Ийм заалт нь байлдааны ажиллагаа эхлүүлэх,

²²⁰ ХБНГУ-н Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2009).177-178 дахь тал.

²²¹ Мөн тэнд, 168 дахь тал.

²²² Олон Улсын нийтийн эрх зүй /гарын авлага/, 51 дэх тал.

хилийн чанадад цэргийн ажиллагаа явуулахаас өмнө асуудлыг хэлэлцэх боломжийг парламентад олгоно.

3. Үндсэн хуульд дайн зарлах шийдвэрийг парламентаас урьдчилан зөвшөөрөл авалгүй, зөвхөн мэдэгдэхээр заасан байх. Ихэнх орны Үндсэн хуульд чухам ингэж заасан байдаг.²²³

Дайн зарласнаар эрх зүйн үүднээс дайны байдал үүснэ. Дайн эхэлснээр дайтагч талуудын хооронд энхийн харилцаа зогсож дипломат болон консулын харилцаа тасардаг бөгөөд дайтагч улсад шууд хамаарах хөрөнгө (дипломат болон консулын газрын төлөөлөгчийнхөөс бусад)-ийг хураадаг. Байлдаан болж байгаа газрыг дайны талбар гэж нэрлэдэг. Дайн эхэлснээр дайтаж байгаа улсуудын хоорондын гэрээ хэлэлцээрийн үйлчлэлд нөлөө үзүүлдэг боловч олон талт гэрээний хувьд тэдгээр улсын хувьд бүр мөсөн зогсоно гэж үздэггүй. Дайтаж байгаа улс, түүний иргэдийн эрх ашгийг нөгөө дайтаж байгаа улсад төлөөлөх ажлыг уг талуудтай дипломат харилцаатай гурав дахь улс гүйцэтгэж болдог бөгөөд үүнийг голдуу төвийг сахисан улс гүйцэтгэдэг. Орчин үед дайн өдөөх нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчиж гэмт хэрэг үйлдсэнд тооцдог.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно” гэжээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс дайн бүхий байдал зарлах нөхцөл бүрэлдсэн тухай оруулсан санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч өргөн мэдүүлснээр УИХ хэлэлцэж, дайн бүхий байдал зарлах эсэх талаар шийдвэр гаргадаг.

“Дайны байдал” хэмээх үгийг Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид дараах байдлаар тайлбарлажээ.

Манай улсын хувьд дайны байдал, дайн бүхий байдал хэмээх нэр томъёог өөр өөр утгаар тайлбарлан хэрэглэж байна. Тодруулбал: Дайны байдлын тухай хуульд /1995 он/ “Дайны байдал гэж Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл бий болох үед төрийн эрх барих дээд байгууллагаас Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт тогтоох улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн, цэргийн онцгой дэглэмийг хэлнэ” гэсэн бол Дайн бүхий байдлын тухай хуульд /1998 он/ “...дайн бүхий байдал” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд аюул занал учруулж, зэвсэглэн халдсан улс, түүний холбоотонтой дайн бүхий байдал зарласан мөчөөс түүнийг цуцлах хүртэл харилцах харилцааны онцгой хэлбэрийг хэлнэ” гэж ялгамжтай байдлаар тайлбарлажээ. Мөн академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” номондоо “англ. Military situation; ор. Военное положение – 1. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйд улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал аюул заналхийлэл учруулж, зэвсэглэн халдсан улс, түүний холбоотонтой зарласан харилцааны онцгой хэлбэр, 2. Олон улсын эрх зүйд олон улсын буюу дотоодын шинж чанартай зэвсэгт мөргөлдөөн. Дотоодын мөргөлдөөний үед эл нэр томъёог бага хэмжээний бослого, үймээн төдий биш харин цар хүрээ нь өргөжиж, дайны байдал бий болсныг тухайн улс хүлээн зөвшөөрсөн үед хэрэглэнэ. Олон улсын шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд оролцогч улсууд энэхүү мөргөлдөөний цар хүрээ өргөжин дайны байдал буй болсныг хүлээн зөвшөөрсөн үед хэрэглэнэ. Ингэснээр олон улсын

²²³ Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт, Зарчим, механизм, үйл ажиллагаа, 119-120 дахь тал.

эрх зүйн хэм хэмжээ үйлчилж эхэлнэ;²²⁴ хэмээсэн бол “Цэргийн шинэчлэл” сэтгүүлд “Дайн гэдэг нь нийгмийн (геополитикийн) субъектүүдийн шинэ зорилго болон байр суурийн (хуучнаа бэхжүүлэх) төлөөх тэмцэлд хүрсэн ялалтаа бэхжүүлэх тэдний шинэ бүтэц, зураглал бий болгож, түүнийгээ удирдах зорилгыг тодорхойлсон нийгмийн үйл явц юм;²²⁵ “Дайн гэдэг нь өөрийн ашиг сонирхлын тулд нөөцийн хуваарилалт болон эсрэг талын боломжийг өөрчлөх зорилгоор нийгмийн нэг хэсэг субъект нөгөө хэсэг субъектын эсрэг зорилго чиглэл, зохион байгуулалттай хүч хэрэглэх үйл явц юм”²²⁶ гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, үгийн утга агуулгын хувьд нийтлэг ойлголттой ч тайлбар талаасаа харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Дайны байдал гэдэгт улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал аюул заналхийлэл учруулж, зэвсэглэн халдсан улс, түүний холбоотонтой зарласан харилцааны онцгой хэлбэрийг ойлгож болохоор байгаа бөгөөд гагцхүү энэ бослого үймээнээс өргөн цар хүрээг хамарсан байх шаардлагатай.

ДҮГНЭЛТ

Улс орон бүрийн эрх зүйн тогтолцоо, эрх зүйн хөгжил өөр байдагтай холбоотойгоор хууль зүйн нэр томьёо харилцан адилгүй зарим тохиолдолд үгийн тодорхойлолт ойлголт хүртэл өөр байдлаар хэрэглэгддэг тул нэр томьёоны асуудал нь байнгын судалгаа шинжилгээ шаардлагатай, судлаачдаас олон талын мэдлэг шаардсан нарийн ажил билээ.

Хууль зүйн нэр томьёо нь хууль зүйн техникийн нэг элемент бөгөөд хэм хэмжээг боловсруулахад хэрэглэдэг мэргэжлийн онцлог бүхий үгийн сан юм. Энэ ч үүднээс тус нэр томьёо нь хууль зүйн шинжлэх ухааны ойлголт ухагдахууныг үгээр томьёолсон хэлний элемент бөгөөд мэдлэг мэдээллийг дамжуулах хэрэгсэл болдог. Тиймээс хууль зүйн тодорхой нэг ухагдахууныг тухайн нэр томьёо нь ямар нэг салаа утгагүйгээр илэрхийлдэг байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, нэр томьёоны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь тодорхойлолт юм.

Сүүлийн жилүүдэд хууль зүйн нэр томьёог судлах, цэгцлэх, жигдрүүлэх талаар эрдэмтэн, судлаачид нэлээд ажлыг хийж, судалгааны цөөнгүй бүтээл хэвлэгдэн гарчээ. Хууль зүйн үндэсний хүрээлэн ч мөн энэхүү ажилд хувь нэмрээ оруулах үүднээс 2016-2026 оны Хөгжлийн стратеги хөтөлбөртөө “Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын удирдлага, зохион байгуулалт, арга зүй, дэд бүтцийг боловсронгуй болгох замаар судалгааны чанар, үр нөлөөг дээшлүүлж, хууль зүйн шинжлэх ухааныг хөгжүүлэх” зорилт дэвшүүлсэн. Уг зорилтын хүрээнд хууль зүйн нэр томьёог жигдрүүлэх, нэгдмэл сантай болох арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд энэхүү арга хэмжээний хүрээнд хийгдэх нэг ажил нь хууль тогтоомжийн нэр томьёоны судалгаа хийх юм. Тус ажил нь цаашид тасралтгүй үргэлжлэн хийгдэх нэлээд томоохон ажил бөгөөд бидний зүгээс энэ удаа Монгол Улсын Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн институттай холбогдох нэр томьёоны талаар судалгаа хийхээр зорьсон билээ.

²²⁴ С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, (Уб: 2015), Адмон, 164 дэх тал.

²²⁵ Р.Сүхбат, Дайны тухай онол ба орчин үеийн дайны агуулга хувьсал өөрчлөлт, онцлогийг шинжих нь, Цэргийн шинэчлэл сэтгүүл, №3 (51) (2013), 11 дэх тал.

²²⁶ Мөн тэнд.

Судалгааг шинжлэх ухааны хэд хэдэн арга зүйд тулгуурлан хийхийг оролдсон бөгөөд хууль зүйн болон хэл шинжлэлийн эрдэмтэн, судлаачдын бүтээлээс аль болох иш татахыг хичээлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 30-37 дугаар зүйлээс нийт 16 нэр томъёог сонгон авч судалгаа хийхээр хамтрах хүрээгээ тогтоож, эдгээр нэр томъёог Монгол Улсын эрдэмтэн судлаачид, болон бусад улсын эрх зүйн толь бичиг хууль тогтоомжид ямар агуулгаар хэрхэн хэрэгжиж байгаа талаар судаллаа. Зарим нэр томъёонд англи хэлний хэд хэдэн үгтэй утга дүйцүүлэн хэрэглэх, үгийн утгыг хэт явцууруулах, өргөжүүлэх гэсэн асуудлууд байсаар байна. Тухайлбал: “бүрэн эрх” хэмээх нэр томъёог англи хэлний “authority” болон “sovereign” гэх үгтэй, “онц байдал” хэмээх нэр томъёог англи хэлний “state emergency”, “national emergency”, “state of defence” гэх байдлаар утга дүйцүүлэн хэрэглэж байгаа бол “зөвшилцөх” хэмээх нэр томъёог “санал нэгтэйгээр буюу эсрэг саналгүйгээр шийдэлд хүрнэ гэсэнтэй ойролцоо утгатай” мөн “эрх бүхий байгууллага батлан гаргах актын төсөл, эсхүл аль нэг албан тушаалд томилохоор нэр дэвшүүлсэн хүний талаар нөгөө байгууллагаас урьдчилан санал дүгнэлт авах ажиллагаа юм” гэх зэргээр өөр өөр байдлаар тайлбарлаж хэрэглэх ч тохиолдол байсаар байгаа нь ажиглагдлаа.

Аливаа нэр томъёо нь нийгмийн хөгжлөө дагаад хувьсан өөрчлөгдөх, шинээр бий болохыг үгүйсгэхгүй ч цаашид хууль зүйн нэр томъёог жигдлэх үүднээс нэр томъёоны хэрэглээ, орчуулгад баримтлах журам боловсруулах, хууль зүйн нэр томъёоны судалгаан дахь эрдэмтэн, судлаачдын оролцоог сайжруулах, эрдэмтэн, судлаачид тус тусдаа биш, нэгдэн нийлж хууль зүйн тайлбар толь бичиг гаргах, үүнийгээ тогтмол баяжуулж, сайжруулан ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

Монгол Улсын хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, /1992/.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, /1993/.
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006/.
- Сонгуулийн тухай хууль, /2015/.
- Дайчилгааны тухай хууль, /1998/.
- Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, /2016/.
- Онц байдлын тухай хууль, /1995/.

Гадаад улсын хууль, тогтоомж

- АНУ-ын Үндсэн хууль, /1787/.
- Аргентин Улсын Үндсэн хууль, /1853/.
- БНСУ-ын Үндсэн хууль, /1948/.
- Бразил Улсын Үндсэн хууль, /1988/.
- Исланд Улсын Үндсэн хууль, /2011/.
- Испани Улсын Үндсэн хууль, /1978/.
- Итали Улсын Үндсэн хууль, /1947/.
- Ирак Улсын Үндсэн хууль, /2005/.
- Литва Улсын Үндсэн хууль, /1992/.
- Мексик Улсын Үндсэн хууль, /1917/.
- ОХУ-ын Үндсэн хууль, /1993/.
- Пакистан Улсын Үндсэн хууль, /1973/.
- Португал Улсын Үндсэн хууль, /1976/.
- Румын Улсын Үндсэн хууль, /1991/.
- Унгар Улсын Үндсэн хууль, /2011/.
- Франц Улсын Үндсэн хууль, /1958/.
- Япон Улсын Үндсэн хууль, Орч. П.Амаржаргал (Уб, 2011)

Ном, өгүүлэл, нийтлэл:

- Ж.Амарсанаа, Эрх зүйн мэдлэгийн товч толь, (Уб, 1986).
- Ж.Амарсанаа, Монгол улсын Үндсэн хуульд орсон харь үг, (Уб, 2013).
- Ж.Амарсанаа нар Хууль зүйн тайлбар толь, (Уб, 2003).
- Ж.Амарсанаа нар Англи- Солонгос- Монгол- Орос- Герман – Хууль зүйн толь, (Уб, 2011).
- Ж.Амарсанаа, Англи-орос-герман-монгол Олон улсын эрх зүйн толь, (Уб, 2004).
- Ж.Амарсанаа, Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг, (Уб, 2014).
- П.Амаржаргал, Парламентын хууль тогтоох бүрэн эрх ба Ерөнхийлөгчийн хориг, *Хууль дээдлэх ёс*, №2, (2014),

- П.Амаржаргал. “УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаан дахь Ерөнхийлөгчийн оролцоо, хууль тогтоомжид тавих хориг” Үндсэн хуульт ёс ба Ерөнхийлөгчийн бүрэн эрх сэдэвт олон улсын онол-практикийн бага хурал. (УБ, 2015).
- Т.Азжаргал, “Үндсэн хуулийн дэг журам зөрчсөн үйлдэлд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах үндэслэл журам”, Хүний эрх онол арга зүйн сэтгүүл, №2, (2015).
- Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, Цэргийн нэр томъёоны тайлбар толь, (УБ, 2014).
- Д.Гангабаатар, “Үндсэн хуулийн эрх зүйн нэр томъёог цэгцлэх асуудал”, Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ, эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, (УБ, 2016).
- Т.Ганхуяг, Зөвшилцөл, (УБ, 2003).
- Т.Гантулга, Улс төрийн зөвшилцлийн онол-практикийн асуудал, (УБ, 2000).
- Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, (УБ, 2012).
- Я.Долгоржав “Онол, практикийн бага хурлыг нээж хэлсэн үг” Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь онол практикийн бага хурал (УБ, 2003).
- Л.Дамбадорж, Орчин үеийн англи-орос-монгол толь, (УБ, 2004).
- Ч.Лувсанжав, Ц. Сумъяа, English- Mongolian Dictionary, (УБ,1990).
- Л.Лүндээжанцан, Ч.Энхбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, (2000).
- О.Машбат, Үндсэн хууль, улс төр-хянал-тэнцэл, (УБ, 2015).
- Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (УБ, 2018).
- М.Мөнхбат, Олон улсын гэрээний эрх зүй, (УБ, 2017).
- Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтийн талаарх судалгаа, (УБ, 2018),
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (УБ, 2015).
- С.Нарангэрэл, Хууль зүйн судлалын англи-монгол тайлбар толь, (УБ, 2005).
- П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль /хэрэгжилт, хяналт, судалгаа/, (УБ, 2017).
- Олон Улсын нийтийн эрх зүй, /гарын авлага/
- П.Очирбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр, (УБ, 2001),
- Б.Өлзийхуяг, аюулгүй байдлын ухааны хөгжлийн асуудал, Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл, №26, (36) (2018).
- Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал, (УБ, 2005).
- Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ,2000).
- Д.Солонго, Төрийн эрх зүйн тайлбар толь, (УБ, 2003).
- Ц.Сарантуяа, “Монгол Улсын хууль зүйн нэр томъёо судлал: сургамж ба шийдэл”,
- Т.Сэнгэдорж “Монгол Улсын хууль зүйн нэр томъёо судлал: сургамж ба шийдэл”, Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ, эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, (УБ,2016).
- О.Сүхбаатар, Монгол хэлний харь үгийн толь, (УБ,2018).
- Я.Төгөлдөр, “Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн институтийн байр суурь эрх мэдлийн хэрэгжилтийн шинжилгээ”, Монгол Улсын Төрийн байгуулал дахь засаглалын инстутын талаарх судалгаа (судалгааны эмхэтгэл), (УБ, 2018).
- Д.Ундралсайхан, Орчин үеийн олон улсын эрх зүй, (УБ, 2016).
- Э.Уранчимэг, Монгол хэлний шинэ үг, хэллэгийн толь, Монгол хэл соёл 13, (УБ, 2014).

- Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага:Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. (УБ, 2012).
- Ханнс-Зайделийн сан, 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, (УБ, 2007).
- ХБНГУ-н Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (УБ, 2009).
- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан, (2018).
- Хууль зүйн үндэсний төв, “Хуулийн нэр томъёоны дагалга”, (УБ,2004).
- Ш.Цогтоо, Ерөнхийлөгчийн институт ба Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, Эрх зүй сэтгүүл, №2, (2014).
- П.Цагаан, Хууль зүйн латин, англи, орос монгол толь, (УБ, 2013).
- Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (УБ, 1966).
